ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ ХХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ, НОЁН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 он

ӨМНӨГОВЬ АЙМАГ, НОЁН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-MV-017301/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-5671833/

ХЯНАСАН: БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын ахлах шинжээч: Ц. Жаргалнэмэх

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Дун Шиан Руи

Тайлан боловсруулсан: Байгаль орчны мэргэжилтэн: О.Түвшинтөр

2024 ОН

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ 6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 10
1.1. Төслийн нэр 10
1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани 10
1.3. Уурхайн хүчин чадал 10
1.4. Төслийн байршил 11
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ 12
2.1. Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл 12
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 16
3.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 17
3.1.1. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх ажлын биелэлт 17
3.1.2. Тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар арчилгаа хийх ажлын биелэлт 18
3.1.3. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах, хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх ажлын биелэлт 18
3.1.4. Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх ажлын биелэлт 19
3.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 21
3.2.1. Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах ажлын биелэлт 23
3.2.2. Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах 23
3.2.3. Усыг үр ашигтай хэрэглэх талаар мэдээллийн хуудсыг самбарт байршуулах 24
3.2.4. Уурхайн ногоон байгууламж, зам талбайн усалгаанд зориулж ус ашиглах 24
3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 25
3.3.1. Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, бүртгэл хөтлөх, хаягжуулах 26

3.3.2. Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх ажлын биелэлт . 27
3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 27
3.4.1. Хяналтгүйгээр газрын гадарга хөндөгдөхөөс сэргийлж, зөвшөөрөл олгох, ГМС ашиглаж зураглах ажлын биелэлт 27
3.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 28
3.5.1. Баяндалай суманд мод тарих ажлын биелэлт..... 29
3.5.2. Уурхайн хүрээ хязгаар, гадаад овоолго, уурхайн гадаад дотоод зам талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх ажлын биелэлт..... 31
3.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 32
3.6.1. Ажилчдад ховор болон нэн ховор амьтдын сургалт явуулах ажлын биелэлт 32
3.6.2. Биотехникийн арга хэмжээний биелэлт 33
3.6.3. Уурхайн орчимд ажиглагдсан амьтад 34
3.7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт 35
3.7.1. 2024 онд уурхайн бүтээн байгуулалтын ажлаар эвдэгдсэн газрын хэмжээний биелэлт 35
3.7.2. Нэмэлт хайгуул судалгааны ажлын үед эвдрэлд өртсөн газруудад (өрмийн зүмп) техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийх..... 36
3.7.3. Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамал тариалсан ажлын биелэлт 37
3.8. Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 39
3.8.1. Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах, гарын авлага хэвлүүлэх ажлын биелэлт 39
3.8.2. Хилчдэд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалт явуулсан ажлын биелэлт 41
3.8.3. Говийн нөхцөлд амьдрах чадвартай мод, сөөгний суулгацыг тодорхой тоогоор үржүүлж үржүүлгийн эх тарьц бэлтгэх ажлын биелэлт 42
3.8.4. Зэрлэг ан амьтны тогтвортой идээшин байрших нөхцлийг тэтгэх арга хэмжээний биелэлт 42
3.8.5. Баяндалай сумын Цагааны голд заг мод тарих ажил..... 43
3.9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө биелэлт 47

3.10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 47
3.11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....49
3.11.1. Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материал, тосох савыг зохих газруудад байрлуулах ажлын биелэлт.....50
3.11.2. ШТМ алдагдсан үед шингээгч, саармагжуулагч материалыг зохих газруудад байршуулах ажлын биелэлт 50
3.11.3. Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах.....51
3.11.4. Галын сургалт, семинар зохион байгуулах ажлын биелэлт 51
3.11.5. Засварын хэсгээс үүсэж буй аюултай хог хаягдлыг ангилж, шилжүүлэх ажлын биелэлт 52
3.12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....53
3.12.1. Төвлөрсөн ахуйн хог хаягдлын цэгийг зэрэгцээ байрлах уурхайнуудтай хамтран байгуулах ажлын биелэлт.....54
3.12.2. Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах, ангилан ялгалт бүхий хогийн савыг байршуулах ажлын биелэлт.....55
3.12.3. Уурхайн ойр орчмыг хамруулсан нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах ажлын биелэлт 56
3.12.4. Хаягдал дугуй, төмрийг цуглуулах талбайн биелэлтийн тайлан.....56
3.12.5. Аюултай хог хаягдлыг төвлөрсөн цэгт хуримтлуулж, мэргэжлийн байгууллагад шилжүүлэх ажлын биелэлт 57
3.12.6. Уурхайн ажилчдад хог хаягдлын сургалт орсон ажлын биелэлт.....58
3.13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....59
3.13.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний биелэлт.....59
3.13.2. Усны хяналт шинжилгээний биелэлт 64
3.14. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....77
3.14.1. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх.....78
3.14.2. Гэрээт компаниудын ажилчдын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулан, хяналт тавьж ажиллах.....79
3.14.3. Баяндалай сумдын ЕБС-ын сурагчид болон иргэдийг хамруулан тэдний экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлын биелэлт 79
3.14.4. Уурхай дээр хийгдэж байгаа байгаль орчны ажлуудын талаарх тайлан мэдээллийг уурхайн нийт ажилчдад танилцуулах ажлын биелэлт.....79

3.14.5. Хүрээлэн буй орчны гэмт хэргийн талаарх ойлголтыг уурхайн нийт ажилчдад сургалтаар мэдээллэх ажлын биелэлт 79
3.14.6. Сайжруулсан шороон замын ажлын биелэлт 80
3.14.7. Байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан байгалийн ургамлыг таньж мэдэцгээе сургалтын биелэлт 80
3.15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг орон нутагт танилцуулах ажлын биелэлт 81
3.15.1. Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх ажлын биелэлт 82
3.15.2. Иргэдийн төлөөлөл, шалгалтын комиссд БОМТ-ийн биелэлтийг танилцуулах 82
3.15.3. 2024 оны БОМТ-нд оруулах орон нутгийн саналын биелэлт 82
3.16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн төсвийн задаргаа 84
ДҮГНЭЛТ 86

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг 11
Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр 12
Зураг 2-2. Өндөржилтийн зураг 13
Зураг 2-3. Төслийн талбай орчмын хөрсний зураг 14
Зураг 2-4. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг 15
Зураг 3-1. Зам талбайн усалгаа хийж байгаа явц 18
Зураг 3-2. Замын засвар үйлчилгээ хийгдэж буй байдал 18
Зураг 3-3. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал 19
Зураг 3-4. Зүлэгжүүлэлт хийсэн талбайн зураг 19
Зураг 3-5. Кемпийн ногоон байгууламж, зүлэгжүүлэлт хийсэн талбайн зураг 19
Зураг 3-6. Оффис орчмын цэцгийн мандалын ургалтын зураг 20
Зураг 3-7. Кемпийн модны ургалтын зураг (2022 он) 20
Зураг 3-8. Кемпийн модны ургалтын зураг (2024 он) 20
Зураг 3-9. Уурхайн эдэлбэр газарт тариалсан модны ургалтын зураг 21
Зураг 3-10. Шүүрлийн ус, ногоон байгууламж, зам талбайн усны хэмжээ 22
Зураг 3-11. Унд ахуйд ашигласан усны хэмжээ /м^3/ 23
Зураг 3-12. Ус хуримтлуулах зориулалттай цөөрөм 23
Зураг 3-13. Усны бичиг баримтууд 24
Зураг 3-14. Мэдээллийн самбарт зааварчилгаа байрлуулах 24
Зураг 3-15. Үйлдвэрлэлийн зориулалттай ус ашиглалт 25
Зураг 3-16. Ногоон байгууламжийн усалгаа 25
Зураг 3-17. Шимт хөрсний овоолгын тэлэлтийн зураг 26
Зураг 3-18. Шимт хөрсний овоолгыг хаягжуулсан байдал 27

Зураг 3-19. Хөрсний овоолгын тэлэлтийн зураг 28
Зураг 3-20. Мод тарьсан талбайн зураг 29
Зураг 3-21. Баяндалай сумын төвд 2024 оны 5-р сард нөхөн тариалалт хийх үйл явц30
Зураг 3-22. Усалгааны систем угсарах үйл явц (2024.7 сар) 31
Зураг 3-23. Мод тарилт хийгдсэн талбайг хүлээлгэн өгсөн ажлын акт 31
Зураг 3-24. Уурхайн ногоон байгууламжийн талбайд ургамлын гербарын цуглуулга хийх 32
Зураг 3-25. Биотехникийн арга хэмжээ 33
Зураг 3-26. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын байршил 34
Зураг 3-27. Уурхайн хойд ууланд ажиглагдсан хар сүүлт 34
Зураг 3-28. Шимт хөрс хуулалт 36
Зураг 3-29. Шимт хөрсний овоолго 36
Зураг 3-30. Хайгуулын өрмийн техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал 37
Зураг 3-31. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа 37
Зураг 3-32. Шимт хөрсний талбайн хөрс бэлдэх явц 37
Зураг 3-33. Шимт хөрсний талбайд усалгаа хийж бэлтгэх үе 37
Зураг 3-34. Шимт хөрсний талбайд тариалалт хийж байх үе 38
Зураг 3-35. Шимт хөрсний талбайд усалгаа хийж байгаа байдал 38
Зураг 3-36. Шимт хөрсний овоолгод тариалалт хийсний дараах байдал 38
Зураг 3-37. Шимт хөрсний талбайн одоогийн байдал (2024.09.30) 38
Зураг 3-38. Ургамлын үр түүх гарын авлагууд 40
Зураг 3-39. Байгалийн ургамлын үр хадгалах зориулалтын сав 40
Зураг 3-40. Цагаан толгойн талын ургамлын зураг 41
Зураг 3-41. Загийн үр түүх үеийн зураг 41
Зураг 3-42. Цэргийн ангид сургалт орох үеийн фото зураг 42
Зураг 3-43. Модлог ургамал тариалсан талбай 42
Зураг 3-44. Цагаан толгойн талд зэрлэг ан амьтанд зориулсан камер байршуулсан байдал 43
Зураг 3-45. Заган ойжуулалт хийсэн газрын байршил (Баяндалай сум, Наран баг, Цагааны гол) 44
Зураг 3-46. Худгийн өрөмдлөгийн ажил 44
Зураг 3-47. 10 га талбайн хашаажуулалтын ажил 45
Зураг 3-48. Модны нүх ухах үеийн зураг (2024 оны 9-р сар) 45
Зураг 3-49. Тарьцыг татан авалт тээвэрлэлтийн явц 45
Зураг 3-50. Тарилт хийгдэх үеийн зураг (2024 он 10 сар) 46
Зураг 3-51. Тарилт хийгдэж дууссаны дараа цэнэг усалгаа хийгдсэн байдал (2024.10.22-27) 46
Зураг 3-52. Баяндалай суманд Заг мод тарьсан талбайн зураг 46
Зураг 3-53. Нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговрын гэрээ 47
Зураг 3-54. Дугуй булшийг хаягжуулж хашаалсан байдал 48
Зураг 3-55. Хашаалж хамгаалсан дугуй булшны байршлын зураг 49
Зураг 3-56. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах талбай 50
Зураг 3-57. Галын сарай 51

Зураг 3-58. Галын үед ашиглагдах хувцас хэрэгсэл 51
Зураг 3-59. Гал түймэр унтраах 067-р ангийн хамт олон сургалт зохион байгуулж буй явц 52
Зураг 3-60. Гал унтраах төлөвлөгөө 52
Зураг 3-61. Хог хаягдлыг зөөвөрлөн устгасан байдал 54
Зураг 3-62. Ахуйн хог хаягдал тээвэрлэсэн тоо 54
Зураг 3-63. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав 55
Зураг 3-64. Ахуйн хог хаягдал цуглуулах талбай 55
Зураг 3-65. Бүх нийтийн их цэвэрлэгээ 56
Зураг 3-66. Ганзагат баг орчмын хог хаягдлыг цэвэрлэх явц 56
Зураг 3-67. Дахин боловсруулагдах хаядлыг тээвэрлэн нийлүүлсэн 57
Зураг 3-68. Аюултай хог хаягдал цуглуулах талбай 57
Зураг 3-69. Аюултай хог хаягдал тээвэрлэсэн байдал 58
Зураг 3-70. Ажилчдад сургалт орсон байдал 58
Зураг 3-71. Агаарын хяналт шинжилгээний мониторингийн цэгүүд 59
Зураг 3-72. Тоосны хэмжилтийн багаж 61
Зураг 3-73. Агаарын хэмжилт судалгаанд орон нутгийн оролцоог хангах 62
Зураг 3-74. PM 2.5 тоосонцорын агууламж 63
Зураг 3-75. PM 10 тоосонцорын агууламж 63
Зураг 3-76. PM 2.5 тоосонцорын агууламж 63
Зураг 3-77. PM 2.5 тоосонцорын агууламж 64
Зураг 3-78. IN-SITU усны түвшиг хэмжигч багаж 65
Зураг 3-79. Унд ахуйн худгийн усны дээж авсан цэгүүд 66
Зураг 3-80. Худгийн усны түвшин хэмжсэн цэгүүд 66
Зураг 3-81. 2023-2024 хур тунадасны хэмжээ 67
Зураг 3-82. Худгийн хэмжилт хийх үеийн фото зураг 68
Зураг 3-83. Худгийн хэмжилт 2024 он 69
Зураг 3-84. Гүн худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 70
Зураг 3-85. Хар овоо худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 70
Зураг 3-86. Бударгана толгой худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 70
Зураг 3-87. Заяагийн худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 71
Зураг 3-88. Дэлгэрэх худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 71
Зураг 3-89. Индэрт худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 72
Зураг 3-90. Төмөрбаатарын худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн 72
Зураг 3-91. Худаг-1 /оффис зүүн хойно/ 73
Зураг 3-92. Уурхайн оффисын гал тогооноос усны дээж авч буй байдал 73
Зураг 3-93. Усны урвалын орчин 73
Зураг 3-94. Усны аммоны агууламж 74
Зураг 3-95. Усны кальцийн агууламж 74
Зураг 3-96. Усны магнийн агууламж 75
Зураг 3-97. Хуурай үлдэгдэл 75
Зураг 3-98. Хатуулаг 75
Зураг 3-99. Хлоридын агууламж 76

Зураг 3-100. Цахилгаан дамжуулах чанар....76
Зураг 3-101. Уурхайн худгийн усны нянгийн тоо....77
Зураг 3-102. Байгаль орчны аудитын тайлан....78
Зураг 3-103. Ой ба Ногоон ирээдүй, Ус ба энхтайван тэмдэглэлт өдөр....79
Зураг 3-104. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт....80
Зураг 3-105. Сайжруулсан шороон зам....80
Зураг 3-106. Байгаль хамгаалах өдрийн хүрээнд зохион байгуулсан сургалт....81

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга....10
Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим....10
Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд....11
Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт....16
Хүснэгт 3-2. Унд ахуйн усны хэрэглээ....22
Хүснэгт 3-3. Шүүрлийн ус, ногоон байгууламж зам талбайн усалгаа....22
Хүснэгт 3-4. Баяндалай сумын наадмын талбайн мод тарилтын ажлын зардал....29
Хүснэгт 3-5. Эвдрэлд өртсөн талбай....35
Хүснэгт 3-6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн зардал....38
Хүснэгт 3-7. 2024 онд Баяндалай суманд хийгдсэн мод тарилтын ажлын зардал....46
Хүснэгт 3-8. Агаарын шинжилгээ хийсэн цэгийн байршил....59

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Баруун Ноён Уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани

Төсөл хэрэгжүүлэгч “Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь 2013 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан Монгол улсын 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаартай, 100% БНХАУ-ын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгж юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь MV-017301 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн энэ төсөл дээр төвлөрөн ажиллаж байгаа юм.

Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга

Аж ахуйн нэгжийн нэр	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	39019071068
Регистрийн дугаар	5671833
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-017301
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон огноо	2013.04.17
Ашиглалтын талбай	1085.2 га
Төслийн байршил, хаяг	Өмнөговь аймаг, Ноён сум хот, Сайран баг, Цагаан дэрс

1.3. Уурхайн хүчин чадал

2022 оны эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлэгчийн техникийн чадамж нь жилд 3000.0 мян.м^3 уулын цул гаргах боломжтой байна. 2023 онд төсөл хэрэгжүүлэгч нь техникийн хүчин чадлаа нэмэгдүүлж жилд 8.2 сая м^3 уулын ажил явуулах боломжтой болж байна. Уурхайн хүрээ хязгаарт багтсан нөөцийг энэ хүчин чадлаар 2 жилийн хугацаанд ашиглах боломжтой байна.

Уурхай нь одоогийн байдлаар 14/14 хоногийн уртын ээлжинд бүрэн шилжиж өдөр, шөнө 12 цагаар үргэлжлэх 2 ээлжээр ажиллаж байна. Ээлжинд цэвэр ажлын 10 цаг ажиллах буюу цаг ашиглалтын коэффициент 0.83 байна.

Жилд баяр ёслол, амралтын өдрүүд, төлөвлөгөөт засвар, цаг ашиглалтын коэффициент 0.83 байна. Жилд баяр ёслол, амралтын өдрүүд, төлөвлөгөөт засвар, цаг агаарын болзошгүй саатлаас шалтгаалж цэврээр 330 хоног ажиллахаар ТЭЗҮ-д тооцоолсон.

Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Хуанлийн хоногийн тоо	хоног	365
2	Баяр ёслол, сул зогсолт	хоног	35
3	Жилд ажиллах өдрийн тоо	хоног	330
4	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	цаг	12

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2

1.4. Төслийн байршил

“Баруун Ноён Уул” нэртэй MV-017301 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт бөгөөд Улаанбаатар хотоос 780 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 210 км, Ноён сумын төвөөс зүүн тийш 30км зайд оршино.



Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг

Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1	102^0 23' 4.9"	43^0 6' 0.26"
2	102^0 23' 4.9"	43^0 5' 29.58"
3	102^0 30' 0.89"	43^0 5' 29.58"
4	102^0 30' 0.89"	43^0 5' 1.29"
5	102^0 22' 0.8"	43^0 5' 1.31"
6	102^0 22' 0.8"	43^0 6' 0.26"

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл

Өмнөговь аймгийн Ноён сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Алтайн уулархаг их мужийн Говийн-Алтайн мужид багтдаг. Төслийн нутаг дэвсгэрт Эхэн хайлааст уул (1873м), Дэнгийн нуруу (1975м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь д.т.дээш 1600-1900м, мөн Гурвантэс-Борзонгийн говийн элсний мужид хамаарагдах Жарангийн элс байрлана. Уулсын онцлог нь гүн сайраар нилээд хэрчигдсэн, маш эгц хажуутай, харьцангуй тэгш хэмт байдалтай юм. Уулсаас эх авсан сайрууд нь хуурай зарим хэсэгтээ овоо өргөн бөгөөд урт нь хэдэн км-ээс хэдэн арван км хүрнэ.



Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр

Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар далайн түвшнээс дээш 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурвансайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг далайн түвшнээс дээш 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.

Тус орд нь нутаг дэвсгэрийн мужлалын хувьд Алтайн уулархаг мужийн Говь-Алтайн мужийн Говь-Алтайн зүүн тойрогт багтдаг.

Олборлолтын талбай нь Эхэн Хайлаастын синклиналийн баруун хойт хэсэгт байрших ба нүүрсний давхраас агуулагч дээд пермийн Дэлийн шанд формацын хурдас нь хойт хэсгээрээ дунд-дээд карбоны Тост формацын андезит-базальтаас тогтох эффузив зузаалаг болон түүнийг зарим хэсгээрээ тасалдалтайгаар хучих доод пермийн

Тогоот хар формацын риолит, риодацитаас тогтох хүчиллэг зузаалаг дээр угаагдлын гадаргуугаар хилэлдэг болно. Дэлийн шанд формац хайгуулын талбайн энэ хэсэгт бараг бүхэлдээ дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдах боловч гуу жалгаар хэрчигдэж идэгдсэн хэсгийн хоёр захаар байнга ил гардаг гаршийн уналын азимут нь 170-200^0, налуугийн өнцөг нь 35-40^0 байна.

Уулзүй

Тус ордын талбай нь газрын гадаргын хувьд Говь-Алтайн уулсын дундах тал хээрийн бүсэд орших ба ихэнх хэсэг нь бэсрэг уулс толгодорхог гадаргуутай газруудыг хамарна.

Талбайн хамгийн өндөрт өргөгдсөн цэг нь талбайн хойд хэсэгт карьерын зүүн хойно орших далайн түвшнээс дээш 1703 м өндөрт өргөгдсөн уулын орой болно. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1560 м өндөртэй талбайн зүүн өмнөд хэсэг дэх жалга болно.



Зураг 2-2. Өндөржилтийн зураг

Ус зүй

Ус зүй, гадаргуугийн усан сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд тогтмол урсацтай гол горхи, нуур, цөөрөм байхгүй гадаргын ус ховортой бүсэд багтана. Энд зөвхөн уулс хоорондын хотгорт жижиг шал, тойром бүхий газарт хур бороо ихтэй үед уулсын жижиг ам, хөндий хуурай сайраар түр зуурын урсац бүхий ус урсаж хотгоруудын ёроолд хурж тогтох ба сэвсгэр хурдсан доогуур шурган замхардаг.

Талбайн хэмжээнд байнгын урсгалтай гол горхи бараг байхгүй боловч зарим үедээ усны ажиллагаа нилээд идэвхждэг болохыг гэрчлэх ор мөр цөөнгүй бий. Талбайд уртрагийн дагуу чиглэлтэй голын хуурай сайр түүнд цутгах жижиг сайрууд, хэрчигдэл багатай хөндийнүүд хөгжсөн байна. Цас их орж хайлах үргэлжилсэн бороо орох зэрэг

үед эдгээр сайр нь бага зэрэг устай болох боловч бороо татрахад усгүй болно. Хур бороотой үед жижиг хонхор хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрдэг. Хүн малын унданд бага гүнтэй, гар худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон хуурай сайр, нуурын зах хөвөөг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 5-6 м-т заримдаа 9-10 м-т хүрдэг.

Хөрс

Монгол орны ургамал, газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн ГовьАлтайн зүүн тойрогт багтах ба энэ талбайн хөрс нь Монгол орны байгалийн бүсийн хуурай хээр, заримдаг цөлийн бүсэд хамрагдана. Говийн цайвар бор хөрс, уулын цөлөрхөг хээрийн бор саарал хөрс, хужирлаг говийн бор саарал, цөлөрхөг хээрийн бор хөрс, уулын цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, элсэрхэг говийн бор хөрс зэрэг хэв шинжийн хөрс тархсан байна. Ургамлын хувьд Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алашаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуу-чулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.



Зураг 2-3. Төслийн талбай орчмын хөрсний зураг

Ургамал зүй

Ургамлын хувьд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь- Алтайн уулын цөлөрхөг хээр, Алашаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуу чулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.



Зураг 2-4. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг

Амьтны аймаг

Амьтдын хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Алтайн өвөр говийн тойрогт багтана. Уг нүүрсний орд орчмын газар нутагт том хөхтөнөөс Янгир ямаа, хар сүүлт тэмдэглэгдсэн байна. Жижиг хөхтөн, хоёр нутагтан ба мөлхөгчид зэрэг зарим амьтдын зүйлийн бүрдлийг харвал Цөлийн хөхтөний бүлгэмдлээс Боролзон туулай, Элссэг зузга, Бордуу шишүүхэй, шаргал чичүүл, морин цөцүүл, шивэр алаг даага, Өмнөговийн алаг даага, Элсч савгадаахай, Гувруу тажигдаахай зэрэг амьтад байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өмнөговь аймгийн Ноён суманд орших “Баруун Ноён Уул” нүүрсний уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д\д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	19	19	-
2	Нөхөн сэргээлт	3	3	-
3	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4	4	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1	1	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1	1	-
6	Осол эрсдлийн менежмент	5	5	-
7	Хог хаягдлын менежмент	5	5	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	8	8	-
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	5	5	-
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	2	2	-
Нийт		**53**	**53**	**-**

3.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай	Уурхайн авто замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн шүүрлийн уусnaас 20 тонны зориулалтын машинаар усыг сорууулж, усалгааг хийдэг
2	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийх		Уурхайн нүүрс тээврийн зам, кемп орчим, дотоод тээврийн замуудад замын арчилгааг дор бүр хийнэ ажилсан
3	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрсний агуулах, ШТС, засварын талбай	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн хурдыг дотоод журамд тусгагдсаны дагуу хурдны хязгаарлалтыг мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн хурд сааруулагч байршуулж, замын тэмдэг тэмдэглэгээг тухай бүрт нь шинэчлэн байршуулсан
4	Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх	Уурхайн тосгон	Уурхайн кемпэд орчны тохижилт, ажилчдын амрах орчинг бүрдүүлхээр зүлэгжүүлэлт хийсэн. Модлог ургамал, ногоон байгууламжийн арчилгааг хийж, дулааны улиралд тогтмол усалгаа хийдэг

3.1.1. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх ажлын биелэлт

Уурхайн дотоод технологийн зам, нүүрс тээврийн зам, гаалийн хяналтын бүсийн ачиж буулгах талбай зэрэгт тогтмол усалгааг хийж ажиллаж байна. 2024 онд усалгааны зориулалттай нийт 9 техник уурхайд ажилласан. Зам талбайн усалгаанд ашиглаж байгаа усыг хянах зорилгоор ашигласан усны тоолуурын заалтыг сар бүр тэмдэглэн ажилладаг. 2024 оны 1-р сараас 10-р сарын 1-ны өдөр хүртэлх зам, талбайн усалгаанд 24010 $м^3$ усыг зарцуулсан байна.

Зураг 3-1. Зам талбайн усалгаа хийж байгаа явц

3.1.2. Тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар арчилгаа хийх ажлын биелэлт

Уурхайн технологийн зам талбай, техник хэрэгслийн нөлөөгөөр эвдрэлд өртөх бүрт зам засварын ажлыг хийн ажиллаж байна.

Зураг 3-2. Замын засвар үйлчилгээ хийгдэж буй байдал

3.1.3. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах, хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх ажлын биелэлт

Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн хурдыг дотоод журмын дагуу технологийн замд 30км\ц, налуу замд 20км\ц, хөрсний овоолго дээр 20км\ц, нүүрсний овоолго, ШТС, засварын талбай, кемпийн ойр орчимд 5км\ц, байхаар зааж тоосжилтоос сэргийлж байна. Мөн замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд саруулагчийг зохих түвшинд нь байршуулан хурдны хязгаарлалтыг тогтоож тоос үүсэх нөхцөлийг багасган ажиллаж байна.

Зураг 3-3. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал

3.1.4. Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх ажлын биелэлт

Уурхайн кемпэд орчны тохижилт, ажилчдын амрах орчинг бүрдүүлхээр зүлэгжүүлэлт хийсэн. Модлог ургамал, ногоон байгууламжийн арчилгааг хийж, дулааны улиралд тогтмол усалгаа хийн ажиллаж байна. Зүлэгжүүлэлтэнд өлөнгө /psathyrostachys/, ерхөг /agropyron cristatum/-ийн үрийг 50х50 харьцаатай хольж тариалалт хийсэн.

Зураг 3-4. Зүлэгжүүлэлт хийсэн талбайн зураг

Зураг 3-5. Кемпийн ногоон байгууламж, зүлэгжүүлэлт хийсэн талбайн зураг

Зураг 3-6. Оффис орчмын цэцгийн мандалын ургалтын зураг

Зураг 3-7. Кемпийн модны ургалтын зураг (2022 он)

Зураг 3-8. Кемпийн модны ургалтын зураг (2024 он)

Зураг 3-9. Уурхайн эдэлбэр газарт тариалсан модны ургалтын зураг

3.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах	Уурхайн тосгон	Уурхайн усны хэрэглээг хянахын тулд кемпийн унд ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа 1 болон 2-р худгийн тоолуурын заалтыг сар бүр бүртгэж, өмнөх сарын дүнтэй харьцуулан, хяналт шинжилгээг хийж , усны төлбөрийг тухай бүрт нь төлж байна
2	Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах	Уурхайн хэсэг	Уурхайн ногоон байгууламжийн усалгааг шүүрлийн усаар хангаж, шүүрлийн усанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна
3	Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	Уурхайн ажилчдын өглөө, оройны ажлын төлөвлөлт өгөх /наряд/ үеэр ажилчдад сургалт болон постероор танилцуулга хүргүүлдэг
4	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх		Жил бүрийн усны өдрөөр мэдээллийн самбарт зааварчилгаа байршуулан, нийт ажилчдад мэдээллийг хүргэдэг
5	Уурхайн карьерт шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор ашиглах	Уурхайн хэсэг	Уурхайн шүүрлийн усыг зориулалтын авто машинаар соруулан авто замын усалгаанд ашигладаг

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь унд ахуйн хэрэглээний 2 худагтай, зам талбай болон ногоон байгууламжийн усалгаанд шүүрлийн усыг ашигладаг. 2024 оны 10-р сарын байдлаар нийт 143117 м^3 усыг унд ахуйн болон технологийн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигласан байна. Үүнээс унд ахуйн хэрэглээнд 1-р худгаас 5540 м^3, 2-р худгаас 2664 м^3 нийт 8204 м^3 усыг зарцуулаад байна. Нийт шүүрлийн 143117 м^3 уснаас 24010 м^3-ийг зам талбайн усалгаанд, 10857 м^3-ийг ногоон байгууламжийн усалгаанд ашигласан.



Зураг 3-10. Шүүрлийн ус, ногоон байгууламж, зам талбайн усны хэмжээ

1-10-р сарын унд ахуйн худгийн уснаас хамгийн их хэрэглээг 8-9-р сарын хооронд 1118-1149 м^3 хэрэглэсэн байна. Хамгийн бага хэрэглээг 2 болон 4-р сард хэрэглэсэн.

Хүснэгт 3-2. Унд ахуйн усны хэрэглээ

Худаг	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	Нийт
I худаг	955	146	404	171	225	331	386	1149	1118	655	5540
II худаг	-	-	581	691	515	401	476	-	-	-	2664
Нийт											**8204**

1-10-р сарын шүүрлийн усны хэмжээ 1109-32349 м^3 бөгөөд арван сарын дундаж 14311.7 м^3, зам талбайн усалгаанд ашигласан усны хэмжээ 1109-3100 м^3 бөгөөд арван сарын дундаж дундаж 2401.0 м^3, ногоон байгууламжид ашигласан усны хэмжээ 250-2153 м^3 бөгөөд арван сарын дундаж дундаж 1551.0 м^3 байна.

Хүснэгт 3-3. Шүүрлийн ус, ногоон байгууламж зам талбайн усалгаа

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	Нийт
Шүүрлийн ус	1953	1612	1109	2234	7736	15811	26774	22589	30950	32349	110768
Зам усалгаа	1953	1612	1109	2234	2565	2895	2742	2950	2850	3100	20910
Ногоон байгууламж	-	-	-	250	280	2052	2016	2153	2000	2106	8751

3.2.1. Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах ажлын биелэлт

Уурхайн кэмпэд унд ахуйн зориулалттай 2 худаг ашиглаж байгаа ба сар бүр тоолуурын заалтаар ус ашиглалтын хэмжээг тогтмол бүртгэж ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлж байна. Унд ахуйн усны хэрэглээг товч дүгнэвэл: 2-р худгийг 3-7-р сард ашигласан бөгөөд нийт 2664 м^3 ус ашигласан байна. 1-р худгийн ашиглалтын хугацаанд 5540 м^3 ус ашигласан. 2024 оны 10-р сарын байдлаар унд ахуйн зориулалтаар 8204 м^3 усыг ашигласан бөгөөд сарын дундаж хэрэглээ 543 м^3 байна.



Зураг 3-11. Унд ахуйд ашигласан усны хэмжээ /м^3/

3.2.2. Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах

Уурхайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022 онд тарьсан 8 төрлийн 4000 модноос одоо ургаж байгаа 2000 орчим модыг зуны улиралд уурхайн шүүрлийн уснаас тогтмол усалсан. Модны усалгаанд зориулан ус хуримтлуулах цөөрмийг байгуулж, уурхайн шүүрлийн уснаас зөөвөрлөн хуримтлуулж модны усалгааг хийсэн. Ус хуримтлуулах зориулалттай цөөрмийг 2024 оны 5-р сард 20мх17мх15м харьцаатай 5100 м^3 эзлэхүүнтэй байгуулсан.

Зураг 3-12. Ус хуримтлуулах зориулалттай цөөрөм

3.2.3. Усыг үр ашигтай хэрэглэх талаар мэдээллийн хуудсыг самбарт байршуулах

Жил бүрийн усны өдрөөр мэдээллийн самбарт зааварчилгаа байршуулан, нийт ажилчдад мэдээллийг хүргэдэг. Усыг үр ашигтай ашиглах ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газраас гаргасан усны боломжит нөөцийн дүгнэлт, ус ашиглуулах дүгнэлт, Алтайн өвөр говийн сав газрын захиргаанаас ус ашиглах гэрээ, хаягдал усны дүгнэлт зэрэг устай холбоотой бичиг баримтыг ажилчдад танилцуулж, усаа хэмнэх арга зөвлөмжийг өгөн ажиллаж байна.

Зураг 3-13. Усны бичиг баримтууд

Зураг 3-14. Мэдээллийн самбарт зааварчилгаа байрлуулах

3.2.4. Уурхайн ногоон байгууламж, зам талбайн усалгаанд зориулж ус ашиглах

2024 оны 10-р сарын байдлаар нийт 143117 м^3 шүүрлийн уснаас технологийн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигласан байна. 1-10-р сарын шүүрлийн усны хэмжээ 1109-32349 м^3 бөгөөд арван сарын дундаж 1411.7 м^3, зам талбайн усалгаанд ашигласан усны хэмжээ 1109-3100 м^3 бөгөөд арван сарын дундаж 2401 м^3, ногоон байгууламжид ашигласан усны хэмжээ 250-2153 м^3 бөгөөд арван сарын дундаж 1551 м^3 байна. Ахуйн цэвэрлэх байгууламжаас гарсан 3521 м^3 саарал усыг зам талбайн усалгаанд ашигласан.



Зураг 3-15. Үйлдвэрлэлийн зориулалттай ус ашиглалт

Зураг 3-16. Ногоон байгууламжийн усалгаа

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, бүртгэл хөтлөх, хаягжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан, шимт хөрсийг зохих гүний дагуу хуулж, бүртгэл маягтыг хөтлөн, талбайн хэмжээг газарзүйн мэдээллийн системд зурагласан
2	Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгийн байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгыг газар дээр нь хаягжуулах		
3	ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэх		Уурхайн уулын хэсэг болон уурхайн тосгонд шатах тослох материал санамсаргүйгээр алдагдах үед ашиглагдах

			шингээгч материалыг шаардлагатай хэсгүүдэд байршуулсан

3.3.1. Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, бүртгэл хөтлөх, хаягжуулах

“Баруун Ноён Уул” ХХК-ийн лицензийн талбайд 2024 оны 1-р сарын байдлаар 3.02 га талбайд шимт хөрсний овоолго-1, 132718.5 м^3 эзлэхүүнтэй, 0.26 га талбайд шимт хөрсний овоолго-2, 1479.9 м^3 эзлэхүүнтэй байсан. Харин 2024 оны 10-р сарын байдлаар шимт хөрсний овоолгод тэлэлт хийгдэж 3.4 га талбайд 41238.6 м^3 эзлэхүүнтэй шимт хөрсний овоолго үүссэн байна.

Зураг 3-17. Шимт хөрсний овоолгын тэлэлтийн зураг

Шимт хөрсний “овоолго-1”-ийг анх 2019 онд үүсгэсэн ба хадгалалтын хугацаа урт байх тул үржил шимт чанарыг алдагдуулахгүй байхын тулд олон наст ургамлыг үрээр 2023, 2024 онуудад тарилт хийсэн. Шимт хөрсний ургамалжуулалтанд зориулан өлөнг, ерхөгийг 1.5 га талбайд нийт 400 кг үрээр тарилт хийсэн. 2023 онд тарилт хийх үед уурхайн шүүрлийн ус ногоон байгууламжийн усалгаанд хүрэхгүй байсан. Харин 2024 онд шүүрлийн ус хангалттай байсан тул усалгааг тогтмол шүүрлийн усаар усалсан. Мөн шимт хөрсний овоолго 1 болон 2-ыг хаягжуулсан.

Зураг 3-18. Шимт хөрсний овоолгыг хаягжуулсан байдал

3.3.2. Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх ажлын биелэлт

Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилан ялган түр байрлуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д шилжүүлдэг. Ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Эко стандарт петролиум” ХХК, “Алтан Оршихуй Групп” ХХК -д шилжүүлдэг. /Дэлгэрэнгүйг 3.11-ээс үзнэ үү/

3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Зайнаас тандан судлах аргазүйг ашиглан газар ашиглалтыг хянах, зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах шаардлагатай арга хэмжээг авах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Газар хөндөх зөвшөөрөл олгох хуудсыг баримтжуулан хөтөлж, хөндөгдөж буй газрын хэмжээг газарзүйн мэдээллийн системд зурагладаг
2	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх		

3.4.1. Хяналтгүйгээр газрын гадарга хөндөгдөхөөс сэргийлж, зөвшөөрөл олгох, ГМС ашиглаж зураглах ажлын биелэлт

Газрын гадаргын эвдрэл доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн хэмжээнд газар хөндөх зөвшөөрөл олгох журмыг хэрэгжүүлж, уурхайн эдэлбэр газрын хэмжээнд газар ашиглалтыг бүртгэн, шинээр хөндөх тохиолдолд байгаль орчны мэргэжилтнээс зөвшөөрөл аван ажиллаж байна. Кемп орчимд бүтээн байгуулалтын ажил хийгдэх үед тухай бүрт ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийг хийдэг.



Зураг 3-19. Хөрсний овоолгын тэлэлтийн зураг

3.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Баяндалай суманд мод тарих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх	Баяндалай сум	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Баяндалай сумын наадмын талбайг тойруулан нийт 2.2 га талбайд 2023.05.25-наас 06.25-ны хооронд 5500 ширхэг хайлаас, улиасны тарилт хийж, нөхөн тариалалтаар 2023.10.10-наас 25-ний хооронд 3000 гаруй мод тарих ажлыг хийсэн. 2024 онд Баяндалай сумын наадмын талбайд ус хадгалах усны ёмкость, усны насос, усалгааны системийг бүрэн суурилуулан ажиллуулж, нэмэлтээр 500 ширхэг бортоготой хайлаасны нөхөн тарилт хийж, модны ургалтын түвшин, амьдрах чадвар сайн байсан тул 7-р сарын 1-нд хүлээлгэн өгсөн

2	Уурхайн хүрээ хязгаар, гадаад овоолго, уурхайн гадаад, дотоод зам талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх	Уурхайн бүс	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд өртөгдөж байгаа газрын ургамлын судалгааг хийж, ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн бүртгэл хийн ажиллаж байна.

3.5.1. Баяндалай суманд мод тарих ажлын биелэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Баяндалай сумын наадмын талбайг тойруулан нийт 2.2 га талбайд 2023 оны 05 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 25-ны хооронд 5500 ширхэг хайлаас, улиасны тарилт хийж, нөхөн тариалтаар 2023 оны 10 дугаар сарын 10-наас 25-ний хооронд 3000 гаруй мод тарих ажлыг хийсэн.

Зураг 3-20. Мод тарьсан талбайн зураг

Хүснэгт 3-4. Баяндалай сумын наадмын талбайн мод тарилтын ажлын зардал

Хийгдсэн ажил		**Зардлын төрөл**
Тарьц суулгац	5000 ш улиас хайлаасны суулгац	20,800,000
Намар нөхөн тарилтын тарьц суулгацын зардал	3000 ш улиас хайлаас	12,500,000
Тарилт хийх үед шаардлагатай тоног төхөөрөмж бараа материал	Усалгааны систем	37,329,500
	Усны ёмкость /3ш/	33,000,000
	Усны насос	700,000
	Бусад шаардагатай бараа материал (хүрз бээлий)	10,000,000
Нийт зардал		**114,329,500**

Зураг 3-21. Баяндалай сумын төвд 2024 оны 5-р сард нөхөн тариалалт хийх үйл явц

Зураг 3-22. Усалгааны систем угсарах үйл явц (2024.7 сар)

2024 онд Баяндалай сумын наадмын талбайд ус хадгалах усны ёмкость, усны насос, усалгааны системийг бүрэн суурилуулан ажиллуулж, нэмэлтээр 500 ширхэг бортоготой хайлаасны нөхөн тарилт хийж, модны ургалтын түвшин, амьдрах чадвар сайн байсан тул 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Баяндалай сумын Засаг дарга, байгаль хамгаалагч нарт талбайг хүлээлгэн өгсөн.

Зураг 3-23. Мод тарилт хийгдсэн талбайг хүлээлгэн өгсөн ажлын акт

3.5.2. Уурхайн хүрээ хязгаар, гадаад овоолго, уурхайн гадаад дотоод зам талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх ажлын биелэлт

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд өртөгдөж байгаа газрын ургамлын судалгааг хийж, ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн бүртгэл хийн ажиллаж байна.

Уурхайн ойр орчмын бүсэд тохиолддог ховор ургамлын зүйлийн жагсаалтыг гаргаж уурхайн байгаль орчны мэргэжилтнүүдэд таниулах хамгаалах арга хэмжээний талаар тодорхой арга замуудыг судлан ажиллаж байна. Мөн энэ жил говийн бүс нутагт хур тунадас өмнөх жилүүдтэй харьцуулахад сайн байсан тул ургамлын төрөл зүйлийн гарц ургалт сайн байсан. Тиймээс уурхайн эдэлбэр газрын дотор ногоон байгууламж бүхий мод тариалсан газарт ургасан ургамлын зүйлүүдээс түүж ургамлын зүйлийн

мэдээллийн сан үүсгэх, ажилчдад говийн ургамлын төрөл зүйлийг таниулах зорилготой гербар хийхээр бэлтгэж ажилласан.

Зураг 3-24. Уурхайн ногоон байгууламжийн талбайд ургамлын гербарын цуглуулга хийх

3.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар нийт ажилчид, туслан гүйцэтгэгч нарт сургалт явуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд, уурхайн нийт ажилчид	Уурхайн нийт ажилчдад сургалтыг зохион байгуулуулан ажилласан
2	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	Өвөлжилт хүндрэх, хаврын тарчиг үед өвс болон тэжээлийг бэлчээр нутагт нь байршуулсан
3	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай компанийн дотоод журмын хэрэгжилтийг хангах үүднээс үзлэг шалгалт хийдэг харуул хамгаалалтын ажилчдад мэдээлэл өгөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох талаар ажилчдад мэдээлэл сургалт орсон

3.6.1. Ажилчдад ховор болон нэн ховор амьтдын сургалт явуулах ажлын биелэлт

Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох талаар ажилчдыг мэдээлэл сургалтаар хангасан.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас өгсөн чиглэлийн дагуу Ноён, Гурвантэс, Цогтцэций сумдын байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх, хууль бус агнуур хулгайн антай тэмцэх смарт дата төслийг 2024 онд 5,134,000 төгрөгөөр санхүүжүүлсэн. /Хавсралт/

3.6.2. Биотехникийн арга хэмжээний биелэлт

2023-2024 оны өвөл өмнөх жилүүдэд хур тунадас их байсан учраас өвөлжилтийн байдал нэлээн хүндэрсэн. Тиймээс манай компани зэрлэг амьтдад зориулан биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Зэрлэг ан амьтанд мөс болон өвс тавих биотехникийн арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 20, 03 дугаар сарын 13, 04 дүгээр сарын 17-ний өдөр нийт 100 боодол өвс, 50 ш хорголжин тэжээлийг “Зэрлэг амьтдад (аргаль, янгир, зээр)” зориулан биотехникийн арга хэмжээг дараах цэгүүдэд хийж гүйцэтгэсэн.

1. Цоохондойн цөөрөм-42^0 59’ 2”N, 102^{0}34’34”E /20 боодол өвс, 10 шуудай хорголжин/
2. Гүн худаг-43^0 5` 24” N, 102^{0}27’41” E /20 боодол өвс, 10 шуудай хорголжин/
3. Уртын гол-43^0 3` 20” N, 102^{0}21’23” E /20 боодол өвс, 10 шуудай хорголжин/
4. Уртын гол-43^0 4` 17” N, 102^{0}30’2” E /20 боодол өвс, 10 шуудай хорголжин/

Зураг 3-25. Биотехникийн арга хэмжээ



Зураг 3-26. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын байршил

3.6.3. Уурхайн орчимд ажиглагдсан амьтад

Уурхайн ойр орчимд ажиглагдсан амьтдын бүртгэлийг уурхайн 4-р постны харуулын цэг дээр харуул нараар ажиглалт хийлгэж бүртгэлийг тогтмол хийдэг. Ихэнх тохиолдолд аргаль, хар сүүлт ганц хоёроор уурхайн хойд ууланд ажиглагдах ба зарим тохиолдолд уурхайн олборлолтын бүс рүү нэвтрэх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд тухайн амьтныг уурхайн бүсээс аюулгүй гаргах арга хэмжээг тухай бүр авч ажилладаг.

Зураг 3-27. Уурхайн хойд ууланд ажиглагдсан хар сүүлт

Уурхайн кемп орчимд үнэг, хярс, шувууд ажиглагдах нь элбэг байдаг. Үнэг нь хоол хүнс олж идэх зорилгоор кемпийн хашаан дотор шөнийн цагт нэвтрэх тохиолдол ажиглагддаг. Шувуудын хувьд кемпийн ногоон байгууламж мод бутыг дагаж ихэвчлэн тохиолддог. 2024 онд кемп оффисын орчимд 2 удаагийн тохиолдлоор 2 өөр зүйлийн гэмтсэн шувуу ажиглагдсан.

3.7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн үйл ажиллагаанд өртөх шимт хөрсийг хуулж, тусгай талбайд овоолго үүсгэх	Уурхайн бүс	Ил уурхай-1-ийн ахилт, хөрсний овоолго-1-ийн тэлэлтээр шимт хөрсний хуулалт хийсэн
2	Нэмэлт хайгуул судалгааны ажлын үед эвдрэлд өртсөн газруудад (өрмийн зүмп) техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийх	Уурхайн бүс	2024 онд нэмэлт хайгуул судалгааны ажлын хүрээнд шинээр өрөмдсөн цооногууд, хайгуулын сувгуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн
3	Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамлыг туршилтаар тариалах	Уурхайн бүс	3.6 га талбайд шимт хөрсний овоолго үүсгэсэн бөгөөд салхины элэгдлээс үүдэн шимт хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж олон наст ургамал (өлөнгө, ерхөг) тус бүр 200 кг буюу нийт 400 кг үрийг хольж тарилт хийсэн

3.7.1. 2024 онд уурхайн бүтээн байгуулалтын ажлаар эвдэгдсэн газрын хэмжээний биелэлт

2024 онд Ил уурхай-1-ийн ахилтаар нийт 6.07 га талбай, 12.1 мян.м^3 шимт хөрсний хуулалт хийгдсэн. Овоолго-1-ийн ахилтаар 8.23 га, шинээр үүсгэсэн овоолго-2-ын ахилтаар 20.28 га нийтдээ 28.51 га талбай хөрсний овоолгын ахилтаар ашиглагдсан байна. Уурхайн тосгонд ажилчдын амрах байр барих, худгийн шугам хоолой татахаар газар ашигласан ба тус талбайнуудад бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссанаар нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 3-5. Эвдрэлд өртсөн талбай

№	2024 онд эвдрэл өртсөн хэсэг	Талбайн хэмжээ		Хуулах шимт хөрсний хэмжээ тооцоогоор		
		м^2	га	м^3	мян.м^3	мян.м^3
1	Ил уурхайн 1-р хэсгийн ахилтаар эвдрэлд өртсөн талбай	60652.84	6.07	12130.6	12.1	28.6
2	Овоолго 1-ийн ахилтаар эвдрэлд өртсөн талбай	82266.77	8.23	16453.4	16.5	
5	Амрах байрны эвдрэлд өртсөн талбай	880.42	0.09	176.1	0.2	
6	Саг, Волейволын эвдрэлд өртсөн талбай	1739	0.17	347.8	0.3	
7	Худгийн шугам хоолой	1876.8		5630.4	5.6	

Уурхайн ахилт, хөрсний овоолгын тэлэлтээр газар ашиглалт үргэлжилсээр байгаа бөгөөд шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалалт арчилгааг хийж ажиллаж байна.



Зураг 3-28. Шимт хөрс хуулалт

Зураг 3-29. Шимт хөрсний овоолго

3.7.2. Нэмэлт хайгуул судалгааны ажлын үед эвдрэлд өртсөн газруудад (өрмийн зүмп) техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийх

2024 онд “Баруун Ноён Уул” ордын талбайд ашиглалтын үеийн нөөцийн зэрэг ахиулах хайгуул судалгааны ажлын хүрээнд нийт 42 хайгуулын цооногт өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хайгуулын цооногуудын нөхөн сэргээлт, өмнөх онуудад хийгдсэн хайгуулын суваг малталтуудын техникийн нөхөн сэргээлтийг энэ онд гүйцээн хийсэн.

Зураг 3-30. Хайгуулын өрмийн техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал

Зураг 3-31. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа

Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа ургамал ургах нөхцлийг бүрдүүлэн шимт хөрсөөр хучсан.

3.7.3. Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамал тариалсан ажлын биелэлт

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь 3.6 га талбайд шимт хөрсний овоолго үүсгэсэн бөгөөд салхины элэгдлээс үүдэн шимт хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж олон наст ургамлыг (өлөнгө, ерхөг) тус бүр 200 кг буюу нийт 400 кг үрийг хольж тарилт хийсэн.

Зураг 3-32. Шимт хөрсний талбайн хөрс бэлдэх явц

Зураг 3-33. Шимт хөрсний талбайд усалгаа хийж бэлтгэх үе

Зураг 3-34. Шимт хөрсний талбайд тариалалт хийж байх үе

Зураг 3-35. Шимт хөрсний талбайд усалгаа хийж байгаа байдал

Зураг 3-36. Шимт хөрсний овоолгод тариалалт хийсний дараах байдал

Зураг 3-37. Шимт хөрсний талбайн одоогийн байдал (2024.09.30)

Хүснэгт 3-6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн зардал

№	Нөхөн сэргээлт	Нэгж ажлын зардлын төрөл	Нийт зардал
1	Техникийн нөхөн сэргээлт	Түлш, тоног төхөөрөмж, ажиллах хүч	Уурхайн үйл ажиллагааны зардал
2	Биологийн нөхөн сэргээлт	Олон наст ургамлын үр, хөрс бэлдэх, бордоо г.м	11,600,000
Нийт зардал			**11,600,000**

3.8. Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах, гарын авлага хэвлүүлэх	Цагаан толгойн тал	Төслийн талбайн байршилтай уялдуулан ургамлын онцлог, амьдрах чадварт тохируулан, үрийг түүх боломжит ургамлын судалгааг хийж, гарын авлагыг боловсруулан байгалийн ургамлыг түүхдээ удирдамж болгон ажилласан
2	Хилчдэд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалт явуулах	Хилийн бүс	ДХ талбайн хөрсний хэв шинж, ургамлын аймаг зонхилон ургах ургамал, ховор болон нэн ховор ургамлын талаар, бүс нутагт амьдрах амьтны аймаг, төрөл зүйлийг хууль бусаар ан хийсэн болон нэн ховор ургамал түүсэн тохиолдолд Байгалийн нөөц ашигласны төлбөрйн тухай хуулийг танилцуулж, Цагаан толгойд талд хэрэгжүүлж буй ДХ ажилыг танилцуулсан
3	Говийн нөхцөлд амьдрах чадвартай мод, сөөгний суулгацыг тодорхой тоогоор үржүүлж үржүүлгийн эх тарьц бэлтгэнэ	Кемп орчим	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн уурхайн тосгонд улиас, шар хуайс, улаан сухай зэрэг ургамлыг мод үржүүлгийн талбай байгуулан тариалсан
4	Зэрлэг ан амьтны тогтвортой идээшин байрших нөхцлийг тэтгэх	Цагаан толгойн тал	Цагаан толгойн талд нарны зайн үүсгүүрээр ажилладаг, хөв цөөрөмтэй, автомат мэдрэгчээр усаа шахдаг худгийг гарган биологийн олон янз байдлыг тэтгэн ажиллаж байна
5	Баяндалай сумын Цагааны голд заг мод тарих ажил	Баяндалй сум	Баяндалай сумын Наран багийн нутагт Цагаан голд 10 га талбайг Заган ойжуулах ажлын хүрээнд гүний худаг гарган, 5-н га талбайд 4132 Заг модны тарилт хийж цэнэг усалгааг бүх модонд хийж дуусгасан

3.8.1. Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах, гарын авлага хэвлүүлэх ажлын биелэлт

Төслийн талбайн байршилтай уялдуулан ургамлын онцлог, амьдрах чадварт тохируулан, үрийг түүх боломжит ургамлын судалгааг хийж, гарын авлагыг боловсруулан байгалийн ургамлыг түүхдээ удирдамж болгон ажилласан.

Зураг 3-38. Ургамлын үр түүх гарын авлагууд

Ургамлын үрүүдийг түүж MNS0246:2010 стандартын шаардлагын дагуу нарны гэрэл шууд тусахаас сэргийлж, хуурай сэрүүн нөхцөлд зориулалтын саванд хадгалдаг.

Зураг 3-39. Байгалийн ургамлын үр хадгалах зориулалтын сав



Зураг 3-40. Цагаан толгойн талын ургамлын зураг

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь Цагаан толгойн талд биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Цагаан толгойн талаас ургамлын үр түүж бэлтгэх гарын авлагыг боловсруулан, үрийг түүж, стандартын дагуу хадгалан ажиллаж байна.

Зураг 3-41. Загийн үр түүх үеийн зураг

3.8.2. Хилчдэд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалт явуулсан ажлын биелэлт

Өмнөговь аймгийн Ноён сумын Цайлангийн 0142 цэргийн ангийн нийт хамт олонд “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн хэрэгжүүлж буй дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ДХ талбайн хөрсний хэв шинж, ургамлын аймаг зонхилон ургах ургамал, ховор болон нэн ховор ургамлын талаар, бүс нутагт амьдрах амьтны аймаг, төрөл зүйл, хууль бусаар ан хийсэн болон нэн ховор ургамал түүсэн тохиолдолд Байгалийн нөөц

ашигласны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйл, 12 дугаар зүйл болон амьтны тухай хуулийн 7 зүйл зэргийг үндэслэн ховор болон нэн ховор ургамал амьтан хууль бусаар агнасан тохиолдолд хэр хэмжээний мөнгөн торгуулиар торгох, мөн “Баруун Ноён Уул” уурхайн дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө зэргийг хилчдэд танилцуулах сургалтыг зохион байгууллаа.

Зураг 3-42. Цэргийн ангид сургалт орох үеийн фото зураг

3.8.3. Говийн нөхцөлд амьдрах чадвартай мод, сөөгний суулгацыг тодорхой тоогоор үржүүлж үржүүлгийн эх тарьц бэлтгэх ажлын биелэлт

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн уурхайн тосгонд улиас, шар хуайс, улаан сухай зэрэг ургамлыг мод үржүүлгийн талбай байгуулан тариалсан.

Зураг 3-43. Модлог ургамал тариалсан талбай

3.8.4. Зэрлэг ан амьтны тогтвортой идээшин байрших нөхцлийг тэтгэх арга хэмжээний биелэлт

Цагаан толгойн талд нарны зайн үүсгүүрээр ажилладаг, хөв цөөрөмтэй, автомат мэдрэгчээр усаа шахдаг худгийг гарган биологийн олон янз байдлыг тэтгэн ажиллаж байна. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Цагаан толгойн талд зэрлэг ан амьтанд зориулсан, нарны үүсгүүрээр ажиллах автомат мэдрэгчтэй худаг гаргаж байсан бол 2024 онд тус бүс нутагт зэрлэг ан амьтны ажиглалт хийх зорилгоор нарны зай үүсгүүртэй камерыг байршуулсан.

Зураг 3-44. Цагаан толгойн талд зэрлэг ан амьтанд зориулсан камер байршуулсан байдал

3.8.5. Баяндалай сумын Цагааны голд заг мод тарих ажил

2024 онд Баяндалай сумаас баруун урагшаа 42 км зайд байрлах Наран багийн нутаг Цагаан гол-д 10 га талбайг заган ойжуулах төлөвлөгөөний дагуу тухайн талбайг бүрэн хашаажуулсан. Тарилт хийгдсэний дараах усалгааг шийдвэрлэх зорилгоор “Эрдэнэдрийлинг” ХХК-аар гүний усны хайгуулын ажлыг хийлгүүлэн 8-р сард худгийн өрөмдлөгийн ажлыг хийлгүүлэн гүний худгийг гаргасан.

Цагааны голд мод тарих газрын байршил координатыг Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал болгосны дагуу сийрэг заган ойн тархац бүхий газар нутаг мөн тус газрын ойжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тухайн газрыг сонгон авч ажилласан.

Талбайн хашаажуулалтын ажлыг 2024 оны 5-р сарын 1-ээс эхлэн 5-р сарын 20-ны хооронд нийт 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Энэхүү хугацаанд тухайн талбайг хашаалах ажил дууссаны дараа тарилтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн байсан боловч тарилт хийгдсэний дараа усалгааг хаанаас хэрхэн хийх нь тодорхойгүй байсан тул тарилтын ажлыг шууд тухайн үед эхлүүлэх боломжгүй байсан. Тиймээс манай компани усалгааны асуудал шийдэгдсэний дараа тарилтыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. 2024 оны 8-р сард манай компани аймгийн Байгаль орчны газраас өгсөн саналын дагуу тухайн талбайд гүний худаг гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Гүний худаг гаргасны дараа 9-р сарын 1-ээс 10-р сарын 27-ны хүртэлх 2 сарын хугацаанд мод тарилтанд ажиллах 15 хүний бүрэлдэхүүнтэй баг талбай дээр ажиллаж 5 га талбайд 4132 загийн тарилт хийж цэнэг усалгааг бүх модонд хийж дуусгасан.

2-3 настай загийн тарьц суулгацыг Цогтцэций, Булган сумдаас 4 удаагийн татан авалт хийж талбай дээр тарилт хийх, хашаа татах, модны нүх бэлтгэж ажлуудыг компани өөрийн ажиллах хүч, техник хэрэгслийн нөөц чадамжид тулгуурлан хийж гүйцэтгэсэн.



Зураг 3-45. Заган ойжуулалт хийсэн газрын байршил (Баяндалай сум, Наран баг, Цагааны гол)

Зураг 3-46. Худгийн өрөмдлөгийн ажил

Зураг 3-47. 10 га талбайн хашаажуулалтын ажил

Зураг 3-48. Модны нүх ухах үеийн зураг (2024 оны 9-р сар)

Зураг 3-49. Тарьцыг татан авалт тээвэрлэлтийн явц

Зураг 3-50. Тарилт хийгдэх үеийн зураг (2024 он 10 сар)

Зураг 3-51. Тарилт хийгдэж дууссаны дараа цэнэг усалгаа хийгдсэн байдал (2024.10.22-27)

Зураг 3-52. Баяндалай суманд Заг мод тарьсан талбайн зураг

Хүснэгт 3-7. 2024 онд Баяндалай суманд хийгдсэн мод тарилтын ажлын зардал

Хийгдсэн ажил		Нийт зардал
	Усалгаа	1,000,000

Сумын төвийн наадмын талбайн мод усалгаа, нөхөн тарилт	Нөхөн тариалалт (бортоготой хайлаас)	3,000,000
Цагааны голд мод усалгаанд зориулан гүний худаг гаргасан	Усны хайгуул судалгаа	6,297,500
	Гүний худаг өрөмдлөгийн ажил	59,620,000
	Усны насос	800,000
Цагааны гол 10 га газар хашаа барих	Хашааны материал	24,530,000
Цагааны гол 5 га-д заг тарилт хийсэн	Загийн тарьц суулгац	16,000,000
	Цогтцэций, Булган сумаас тарьцыг тээвэрлэх ажлын зардал	6,000,000
	Хөрсний чийг баригч	1,600,000
	Бордоо	4,570,000
Нийт		**123,417,500**

3.9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллана	Уурхайн нөлөөллийн бүсд хамрагдсан айл өрхүүд	Уурхайн нөлөөллийн бүсэд байсан 13 айлтай 2022 онд хатмран ажиллах гэрээ байгуулан, гэрээний дагуу нөхөн олговрыг олгон ажилласан

Уурхайн нөлөөллийн бүсэд байсан 13 айлтай 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний дагуу нөхөн олговрыг олгон ажиллаж байна.



Зураг 3-53. Нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговрын гэрээ

3.10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах чиглэлээр хийгдэх ажил	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл

1	Дугуй булшийг хашаалж тэмдэгжүүлэх	Уурхайн бүс	Хайгуулын шатанд археологийн судалгааны үр дүнд 6 дурсгал тэмдэглэгдсэн. Эдгээр дурсгалуудаас №5 дугаартай дугуй булш лицензийн талбай дотор байгаа бөгөөд тухайн дурсгал орчимд одоогоор ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд №5 дугуй булшийг хашиж хамгаалан тэмдэгжүүлсэн

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн “Баруун Ноён Уул” нүүрсний уурхайн лицензийн талбайд 2012 онд “Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэн”, археологийн хайгуул хийхэд, археологийн олдвор илрээгүй болно.

2023 оны 4 болон 6-р саруудад Палеонтологийн хайгуул судалгааны ажил, Угсаатан зүйн авран хамгаалах, тандан судалгааны ажил хийгдсэн. Төслийн талбайд хайгуулын шатанд археологийн судалгааны үр дүнд 6 дурсгал тэмдэглэгдсэн байна. Эдгээр дурсгалуудаас №5 дугаартай дугуй булш лицензийн талбай дотор байгаа бөгөөд тухайн дурсгал орчимд одоогоор ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд №5 дугуй булшийг хашиж хамгаалан тэмдэгжүүлсэн.

Зураг 3-54. Дугуй булшийг хаягжуулж хашаалсан байдал



Зураг 3-55. Хашаалж хамгаалсан дугуй булшны байршлын зураг

3.11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материал, тосох савыг зохих газруудад байрлуулах	Засвар үйлчилгээний хэсэг	Уурхайн засвар үйлчилгээний хэсэгт химийн бодис асгарсан үед бохирдсон хөрсийг хусаж аван түр хадгалах талбайд цуглуулж хог хаягдлын мэргэжлийн гэрээт компанид хандан ажилладаг
2	ШТМ алдагдсан үед шингээгч, саармагжуулагч материалыг зохих газруудад байршуулах		Уурхайн уулын хэсэг болон уурхайн тосгонд шатах тослох материал санамсаргүйгээр алдагдах үед ашиглагдах шингээгч материалыг шаардлагатай хэсгүүдэд байршуулсан
3	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Үйл ажиллагаа явуулж байгаа бүх барилга байгууламж	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтыг хийж, гал гарсан үед ашиглагдах багаж хэрэгслийг талбайн гадна болон дотор байршуулан ажилсан

4	Галын сургалт, семинар орох	Галын сургалт семинар орох	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гал түймэр унтраах аврах 067-р ангийн баг хамт олон “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн уурхайн тосгонд хүрэлцэн ирж Галын аюулгүй байдлын мэдлэг олгох онол, практикын дадлага сургуулилтыг амжилттай зохион байгуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх бичиг баримтыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна
5	Засвар үйлчилгээний хэсгээс үүсэж буй аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь стандартын дагуу бохирдол үүсгэхгүйгээр түр хадгална, аюултай хог хаягдал хүлээн авах мэргэжлийн байгууллага руу шилжүүлнэ	*	Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилж, ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д, ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан Оршихуй Групп” ХХК, “Эко Стандарт Петролиум” ХХК-д шилжүүлдэг

3.11.1. Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материал, тосох савыг зохих газруудад байрлуулах ажлын биелэлт

Уурхайн засвар үйлчилгээний хэсэгт химийн бодис асгарсан үед бохирдсон хөрсийг хусаж аван түр хадгалах талбайд цуглуулж “Түмэн Эгшиг” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр аюултай хог хаягдлыг устгадаг.

Зураг 3-56. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах талбай

3.11.2. ШТМ алдагдсан үед шингээгч, саармагжуулагч материалыг зохих газруудад байршуулах ажлын биелэлт

Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилаж ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д, ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан Оршихуй Групп” ХХК, “Эко Стандарт Петролиум” ХХК-д шилжүүлдэг. /Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 3.11-ээс үзнэ үү/

3.11.3. Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах

Галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтыг хийж, гал гарсан үед ашиглагдах багаж хэрэгслийг талбайн гадна болон дотор байршуулан ажилсан. Тухайлбал засвар үйлчилгээний хэсэг, хоол үйлдвэрлэл, оффисын урд, шатахуун түгээх станц, гааль экспортын талбай, ажилчдын амрах байр, гэр кемпийн дунд, авто зогсоол орчимд байршуулсан.

Зураг 3-57. Галын сарай

Гал эсэргүүцэх гал сөнөөгчийн хувцас, хамгааллын хэрэгсэл, иж бүрдлийг бэлэн байлгаж учирч болох аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Зураг 3-58. Галын үед ашиглагдах хувцас хэрэгсэл

3.11.4. Галын сургалт, семинар зохион байгуулах ажлын биелэлт

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн хүсэлтийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын гал түймэр унтраах 067-р ангийн хамт олон 2024 оны 8-р сарын 25-ны өдөр уурхайн тосгонд ирж галын аюулгүй байдлын мэдлэг олгох онол, практик, дадлага

сургуулилтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтанд 6-н хэсэг нэгжийн 250 гаруй ажилтан хамрагдсан бөгөөд гал түймэр гарсан үед анхан шатны багаж хэрэгслүүдийг хэрхэн ашиглах, гал түймрийн үед хэрхэн ажиллах, хэрхэн гал түймрээс өөрийгөө болон бусдыг аюулгүй гаргах, галыг хэрхэн зөв унтраах зэрэг мэдлэг мэдээллийг ажилчдад олгосон.

Зураг 3-59. Гал түймэр унтраах 067-р ангийн хамт олон сургалт зохион байгуулж буй явц

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь дотооддоо хэрэгжүүлэх дүрэм, журмыг үндэслэн галын аюулгүй ажиллагааны нийтлэг заавар, галын аюулгүй байдлыг хангаж ажиллах дотоод журам, гал унтраах шуурхай төлөвлөгөө, гамшгийн үеийн төсөв, объектын гал түймрийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн эрсдэлийн үнэлгээ зэрэг дараах бичиг баримтыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна.

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН
ГАЛ УНТРААХ ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

Зураг 3-60. Гал унтраах төлөвлөгөө

3.11.5. Засварын хэсгээс үүсэж буй аюултай хог хаягдлыг ангилж, шилжүүлэх ажлын биелэлт

Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилаж ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д, ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан Оршихуй Групп” ХХК, “Эко Стандарт Петролиум” ХХК-д шилжүүлдэг. /Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 3.11.5-аас үзнэ үү/

3.12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Ажлын гүйцэтгэл
1	Төвлөрсөн ахуйн хог хаягдлын цэгийг зэрэгцээ байрлах уурхайнуудтай хамтран байгуулах	Уурхайн тосгон	Өмнөговь аймгийн Ноён суманд байрлах төвлөрсөн хогийн цэгийн талбайг 361 м^2-аар төлөвлөж сумаас 116 м² талбайг хашаажуулж, үлдсэн 245 м² талбайг “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн зүгээс шаардлагатай бараа материалыг захиалж хогийн цэгийг бүрэн ашиглалтанд оруулсан
2	Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах, ангилан ялгалт бүхий хогийн савыг байршуулах		Уурхайн тосгонд байрлах үед хог хаягдлын дотоод журмыг баримталж, ангилан ялгах хогийн савыг байршуулсан, өмнө нь байсан хогийн цэгийг засаж янзалсан, эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савуудыг уурхайн тосгон болон гааль хяналтын хэсэгт байршуулсан
3	Уурхайн ойр орчмыг хамруулсан нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхайн тосгон НАБТ	Уурхайн нийт ажилчид 7 хоног бүрийн Ням гаригт уурхайн тосгонд бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэдэг
4	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлэх талбайг тохижуулах	Засвар үйлчилгээний хэсэг	Засварын хэсгээс гарч байгаа хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлэн, гэрээт байгууллага руу нийлүүлдэг
5	Засвар үйлчилгээний хэсгээс үүсэж буй аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь стандартын дагуу бохирдол үүсгэхгүйгээр түр хадгална; аюултай хог хаягдал хүлээн авах мэргэжлийн байгууллага руу шилжүүлнэ		Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилаж ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д шилжүүлдэг. Ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан оршихуй групп” ХХК, “Эко стандарт петролиум” ХХК-д шилжүүлдэг. Эмнэлгийн хог хаягдлын бүртэлийг хөтлөж Ноён сумын эмнэлэгт 14 хоногт нэг удаа нийлүүлж устгуулдаг

Ахуйн хог хаягдлыг “Ноён Мэлмий” ХХК, ахуйн хэрэглээнээс үүссэн хаягдал тосыг “Стандарт Хүнс ХХК”, хаягдал хуванцар, маслын шүүр, принтерын хор, агаар шүүгч филтер, бээлий болон нийлэг материал, хаягдал батерейг “Түмэн эгшиг” ХХК, эмнэлгийн хог хаягдлыг Ноён сумын хүн эмнэлэгт, хаягдал тос, маслыг “Эко Стандарт Петролиум” ХХК, “Алтан Оршихуй Групп ХХК”-д тус тус гэрээний үндсэн дээр нийлүүлэн устгуулж байна.



Зураг 3-61. Хог хаягдлыг зөөвөрлөн устгасан байдал

3.12.1. Төвлөрсөн ахуйн хог хаягдлын цэгийг зэрэгцээ байрлах уурхайнуудтай хамтран байгуулах ажлын биелэлт

Өмнөговь аймгийн Ноён суманд байрлах төвлөрсөн хогийн цэгийн талбайг 361 м^2-аар төлөвлөж сумаас 116 м² талбайг хашаажуулж, үлдсэн 245 м² талбайг “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн зүгээс шаардлагатай бараа материалыг захиалж хогийн цэгийг бүрэн ашиглалтанд оруулсан.

2024 оны эхний хагас жилийн байдлаар “Хур Эрдэнэ Баялаг” ХХК уурхайгаас сард дунджаар 96.66 тн ахуйн хог хаядал тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.



Зураг 3-62. Ахуйн хог хаягдал тээвэрлэсэн тоо

Уурхайгаас гарах ахуйн хог хаягдал нь улирал болон тухайн сарын бараа материалын захиалгын хэмжээнээс хамааран сард дунджаар 3-4 удаа “Ноён Мэлмий” ХХК-д нийлүүлэлт хийдэг, 1 ачилт нь 20 тн хог хаягдал тээвэрлэдэг.

Хог хаягдлын тухай хуулийн 11-р зүйлийн 11.2 дахь заалтыг үндэслэн Өмнөговь аймгийн Ноён сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/06 тоот

захирамжийг үндэслэн ахуйн энгийн хог хаягдлыг тээвэрлэх эрх бүхий “Ноён мэлмий” ХХК-д ахуйн энгийн хог хаягдлын тээврийн төлбөр нь ачилтын давтамж тооноос үл хамааран сар бүр 2,000,000 /Хоёр сая/ төгрөг төлдөг. 2024 онд ахуйн энгийн хог хаягдалд 26,400,000 /Хорин зургаан сая дөрвөн зуун мянган/ төгрөг төлсөн байна.

3.12.2. Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах, ангилан ялгалт бүхий хогийн савыг байршуулах ажлын биелэлт

Уурхайн тосгонд байрлах үед хог хаягдлын дотоод журмыг баримталж, ангилан ялгах хогийн савыг байршуулсан, өмнө нь байсан хогийн цэгийг засаж янзалсан, эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савуудыг уурхайн тосгон болон гааль хяналтын хэсэгт байршуулсан.

Засварын хэсэг | Ажилчдын амрах байр | Амрах гэр | Уурхайн 1-р пост

Зураг 3-63. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав

Уурхайгаас гарах ахуйн хог хаягдлаас дахин боловсруулалтанд ордог хаягдлыг хогийн саванд ангилан, хаягдал авах цэгүүдтэй гэрээ байгуулан нийлүүлдэг. Энэ оны 7-р сараас эхлэн ангилан ялгах хогийн савны ангилалыг нэмэх зорилгоор төмөр хогийн сав байршуулан Шил болон лааз, HDPE хуванцар, Цаас болон бусад гэсэн үндсэн 4 хэсэгт хуваасан.

Зураг 3-64. Ахуйн хог хаягдал цуглуулах талбай

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК уул уурхай нь хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах, ангилан ялгах хог хаягдлын төрлийг нэмэх зорилгоор зөөврийн хогийн сав болон төмөр хогийн савыг 2024 онд хийж байршуулсан. Зөөврийн хогийн савыг уурхайн тосгон болон уулын хэсэгт байршуулсан бол төмөр хогийн савыг хог хаягдлын ангилан ялгах нэгдсэн цэгт байршуулсан. Нийт хог хаягдлыг ангилан ялгалтанд **10,650,000** /Арван сая жаран таван мянга/ төгрөг зарцуулсан.

3.12.3. Уурхайн ойр орчмыг хамруулсан нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах ажлын биелэлт

Хүрээлэн буй орчноо цэвэр хоггүй байлгах, цаашлаад байгаль орчинд хог хаягдлаас үүдэлтэй хөрс, ус, агаарын бохирдол үүсгэхгүй үүднээс 7 хоног бүрийн ням гарагт нийт хэсэг нэгжийн ажилчдыг хамруулсан нийтийн их цэвэрлэгээг хийдэг.

Зураг 3-65. Бүх нийтийн их цэвэрлэгээ

Нүүрс тээврийн авто замын дагуух Ганзагат баг орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн.

Зураг 3-66. Ганзагат баг орчмын хог хаягдлыг цэвэрлэх явц

3.12.4. Хаягдал дугуй, төмрийг цуглуулах талбайн биелэлтийн тайлан

Засварын хэсгээс гарч байгаа хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлсэн. Уурхайгаас дахин боловсруулах боломжтой хаягдал хуванцар сав (PET буюу polyethylene terephthalate хатуу хуванцар) 10 шуудай буюу 65 кг, мөн хаягдал төмөр 15700 кг-ийг нийлүүлсэн. Мөн иргэний хүсэлтийн дагуу 200 хаягдал дугуйг олгосон байна.

Зураг 3-67. Дахин боловсруулагдах хаядлыг тээвэрлэн нийлүүлсэн

3.12.5. Аюултай хог хаягдлыг төвлөрсөн цэгт хуримтлуулж, мэргэжлийн байгууллагад шилжүүлэх ажлын биелэлт

Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилан ялган түр байрлуулж, /гидрийн шингэн, тос масло, шингээгч материал, авто машины зай хураагуур, агаар шүүгч, хаягдал бээлий болон нийлэг материал, химийн бодисын хаягдал хуванцар сав, принтерийн хор, ахуйн хэрэглээний тос, эмнэлгийн хог хаягдал/ тус тусын гэрээт компанид шилжүүлдэг. Гидрийн шингэн, тос масло шингээгч материал, авто машины зай хураагуур, агаар шүүгч, хаягдал бээлий болон нийлэг материал, химийн бодисын хаягдал хуванцар сав, принтерийн хор зэргийг “Түмэн Эгшиг” ХХК-д шилжүүлдэг. Ашигласан тос маслыг 50 тонны ёмкость хадгалж “Алтан оршихуй групп ХХК”, “Эко Стандарт Петролиум” ХХК-д шилжүүлдэг. Ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал тосыг Стандарт Хүнс ХХК-д, эмнэлгийн хог хаягдлын бүртэлийг хөтлөж Ноён сумын эмнэлэгт 14 хоногт нэг удаа нийлүүлж устгуулдаг.

Зураг 3-68. Аюултай хог хаягдал цуглуулах талбай

Засварын хэсэгт аюултай хог хаягдлыг нэр төрлөөр нь ангилан ялгаж, бүртгэн тээвэрлэдэг. 2024 оны 10-р сарын байдлаар хаягдал тос, масло 39 тн, 1279 ширхэг масло шүүр, 1203 ширхэг хаягдал агаар шүүгч /том жижиг/, 543 ширхэг химийн бодисын хаягдал хуванцар сав, 63 кг хаягдал бээлий болон гийлэг материал, 20 ширхэг принтерийн хор, 2.25 кг хаягдал батерей нийлүүлсэн байна. Тайлант хугацаанд аюултай хог хаягдлын гэрээт байгууллага руу 14,496,485 /Арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун наян таван/ төгрөг шилжүүлсэн байна.



Зураг 3-69. Аюултай хог хаягдал тээвэрлэсэн байдал

3.12.6. Уурхайн ажилчдад хог хаягдлын сургалт орсон ажлын биелэлт

Ажилчдад хог хаягдлын боловсролыг дээшлүүлэх үүднээс хог хаягдлыг ангилан ялгах /жишээ нь: хуванцар (PET) ус ундааны савыг хэмжээг нь багасгаж хадгалах, тухайн саванд өөр зүйл хийхгүй байх нь дахин боловсруулахад илүү боломжтой болох талаар/, хог хаягдлын хоруу чанар, байгаль орчинд хог хаягдал хэрхэн нөлөөлдөг цаашлаад ус, хөрс, агаараар дамжин хүний эрүүл мэндэд дам сөрөг нөлөө үзүүлэх сургалтыг орсноор хог хаягдлыг зөв ангилан ялгах, дахин хэрэглэх ашиглах, хаягдал бага гаргах бараа бүтээгдэхүүн худалдан авах зэрэг ойлголтуудыг ажилчдад олгосон.

Зураг 3-70. Ажилчдад сургалт орсон байдал

3.13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Баруун Ноён Уул” уурхайн орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаарын чанар, усны хяналт шинжилгээ, ургамлын хяналт шинжилгээ, хөрсөн бүрхэвчийн цэгүүдийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

3.13.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний биелэлт

Агаар орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөт ажлын хүрээнд уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосны хэмжилтийг хийж гүйцэтгэхдээ хэмжилт судалгаа хийх аргазүй боловсруулан хээрийн хэмжилт судалгаа хийх, цуглуулсан датаг боловсруулан тайлагнахдаа удирдамж болгон ажиллаа.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тоосны хэмжилтийг тогтоосон цэгүүдэд байгаль орчны мэргэжилтнүүд сард 2 удаагийн давтамжтайгаар тогтмол хийж гүйцэтгэсэн.

Зураг 3-71. Агаарын хяналт шинжилгээний мониторингийн цэгүүд

Хүснэгт 3-8. Агаарын шинжилгээ хийсэн цэгийн байршил

Цэгийн дугаар	Цэгийн байршил	Координат
BNU-AM-01	Ил уурхай 2-ын зүүн хойд тал	102° 23' 17.806", 43° 5' 26.7"
BNU-AM-02	Ил уурхай-1 овоолгын зүүн тал, ШТС-ын хойно	102° 22' 39.516", 43° 5' 12.1"
BNU-AM-03	Ил уурхай -1 уланд	102° 22' 18.405", 43° 5' 48.4"
BNU-AM-04	Гаалийн талбайн зүүн урд, 1-р овоолгын баруун урд технологийн замын хойд талд	102° 22' 12.219", 43° 5' 20.7"

BNU-AM-05	Ил уурхай-2-ын хөрсний овоолгын зүүн урд хормойд	102° 22' 30.166", 43° 5' 7.99"
BNU-AM-06	Кемп дотор	102° 23' 10.639", 43° 5' 2.62"
BNU-AM-07	Кемпийн зүүн тал орон нутгийн зам дагуу	102° 24' 30.708", 43° 5' 25.8"
BNU-AM-08	Нүүрс тээврийн зам дагуу	102° 19' 43.304", 43° 5' 27.1"
BNU-AM-09	Нам даралтын зуух -1	
BNU-AM-10	Нам даралтын зуух -2	

3.13.1.1. Агаарын чанар тоосны хэмжилт хийх аргачлал

1. Хэмжилт хийхээс өмнө багажийг сайтар цэнэглэсэн байна
2. Агаар орчин дахь тоосны хэмжилт хийхдээ цаг агаарын орчны хүчин зүйлсийн хээрийн тэмдэглэл хийх
3. Хэмжилтийн багажийн хэмжилт хийх цэгт байршуулан PM 2.5 ширхэглэгт тоосонцорыг соруулах зориулалттай хошуувчийг хийж 20 минутын турш хэмжилтийг хийнэ.
4. Хэмжилтийн багажийг хэмжилт хийх цэгт байршуулан PM 10 ширхэглэгт тоосонцорыг соруулах зориулалттай хошуувчийг хийж 20 минутын турш хэмжилтийг хийнэ.
5. 24 цагийн хэмжилтийг хийхдээ багажийг зөөврийн цахилгааны эх үүсвэрт холбох
6. Хэмжилт хийгдэх явцыг фото зургаар баримтжуулна
7. Хэмжилтийн утгыг багажнаас тухай бүр хуулбарлан мэдээллийн сан үүсгэнэ.
8. Мэдээллийн сан үүсгэхдээ хэмжилтийн утгыг багажнаас компьютерт хуулбарлан хэмжилт хийсэн цэгийн дугаарын дагуу он сар хугацаатай, хэмжилт хийх үеийн фото зургийн хамт мэдээллийн сан үүсгэж хадгална

Тоос тоосонцор. Агаар дахь тоосны агууламжийг DustTrak загварын зөөврийн автомат багажуудаар тодорхойлсон бөгөөд энэ төрлийн багаж нь агаар дахь нийт тоос, PM10, PM4.0, PM2.5, PM1.0 хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг тодорхойлох боломжтой.

Мониторингийн судалгааны ажлын хүрээнд DUSTTRAK II Aerosol Monitor DRX багаж, Extech VP300 гар багаж ашиглан агаарын хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

DUSTTRAK II Aerosol Monitor DRX багаж ***Extech VP300 гар багаж***

Зураг 3-72. Тоосны хэмжилтийн багаж

DUSTTRAK II Aerosol Monitor DRX багажаар хэмжсэн хэмжилтийн үзүүлэлтийг Монгол улсын стандарт. Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарттай харьцуулсан бол гар багажны хэмжилтийн утгыг, гар багажны хэмжилтийн лавлахтай харьцуулан тодорхойллоо.

3.13.1.2. Агаар орчны хяналт шинжилгээнд орон нутгийн иргэдийн оролцоог хангасан талаар

Агаар орчны хяналт шинжилгээг 2024 оны 5 болон 9-р сард мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн ба тайланг БОМТ-ний биелэлтийн тайланд хавсралтаар оруулаа.

Мэргэжлийн байгууллага уурхайн талбай дээр ажиллаж, хээрийн хэмжилт судалгаа хийх үед орон нутгийн малчин иргэдийн төлөөллийг оролцуулан хяналт шинжилгээ хийлгэсэн. Мэргэжлийн судлаачид иргэдийн сонирхсон асуултад тайлбар мэдээлэл өгч, нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллалаа.

Зураг 3-73. Агаарын хэмжилт судалгаанд орон нутгийн оролцоог хангах

3.13.1.3. Агаарын судалгааны ажлын үр дүн

Агаарын мониторинг судалгааны ажлын хүрээнд агаарын хэмжилт судалгааг ил уурхай 2-ын зүүн хойд тал, ил уурхай-1 овоолгын зүүн тал, ШТС-ын хойно, ил уурхай-1 уланд, гаалийн талбайн зүүн урд, 1-р овоолгын баруун урд технологийн замын хойд талд, ил уурхай-2-ын хөрсний овоолгын зүүн урд хормойд, кемп дотор, кемпийн зүүн тал орон нутгийн зам дагуу, нүүрс тээврийн зам дагууд агаарын хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

Тоосонцор (PM2.5, PM10). Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамааралд маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрон хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг. Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос /PM10/-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрон диаметр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг. Агаар дахь нийт тоосны агууламжийг дараах зургаар харуулав.



Зураг 3-74. PM 2.5 тоосонцорын агууламж



Зураг 3-75. PM 10 тоосонцорын агууламж

Агаарын чанарын мониторингийн судалгааны үр дүнгээс үзэхэд PM 2.5, PM 10 тоосны агууламж гаалийн хяналтын талбайд МУ-ын агаарын чанарын стандарт MNS 4885:2016 стандартаас давсан үзүүлэлттэй байна. Харин бусад цэгт хэмжсэн тоосны хэмжээ MNS 4885:2016-аас бага буюу хэвийн хэмжээнд байна.

Агаарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхайн кемп, засварын талбай, уурхайн бүс, гаалийн хяналтын талбай гэсэн 4 цэгээс сард 6 удаагийн давтамжтай, PM2.5, PM10 тоосны агууламжийг 9 сарын хугацаанд 216 удаа хэмжилтийг хийлээ. “Хур Эрдэнэ Баялаг ХХК”-ийн Extech VP300 гар багажаар хэмжсэн тоосны үзүүлэлтийг дараах зургаар харууллаа.



Зураг 3-76. PM 2.5 тоосонцорын агууламж

Extech VP300 гар багажаар хэмжсэн PM 2.5, PM10, тоосны хэмжээг багажийн лавлах утгатай харьцуулж үзэхэд гаалийн хяналтын талбай, уурхайн бүс орчимд лавлах үзүүлэлтийн утгаас давсан үзүүлэлттэй байна.



Зураг 3-77. PM 2.5 тоосонцорын агууламж

Extech VP300 гар багажаар хэмжсэн утгад Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулах үзүүлэлт байхгүй бөгөөд багажны лавлах утгатай харьцуулан тайланд боловсруулсан.

3.13.2. Усны хяналт шинжилгээний биелэлт

Монгол орны газар доорх усны нөөц нь жигд бус тархалттай, чанар нь харилцан адилгүй бөгөөд нутаг дэвсгэрийн хувьд баруунаас зүүн тийшлэх, хойноос урагшлах тутам эрдэсжилт нь ихсэх хандлага ажиглагддаг. Энэ нь орох хур тунадасны хэмжээ багасах, агаарын температур, ууршилт нэмэгдэх зэрэг уур амьсгалын өөрчлөлт болон ус агуулагч хурдас чулуулгийн үндсэн шинж чанартай холбоотой байдаг.

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн Баруун Ноён Уул нүүрсний уурхайн газрын доорхи усны чанарыг тодорхойлох зорилгоор Гүн худаг, Бударгана толгой, Хар овоо, Заяа, Сухайт, Дэлгэрэх, Төмөрбаатар, Инднэртийн худагт сар бүрийн 26-ны өдөр усны түвшний хэмжилтийг орон нутгийн иргэний оролцоотой хамтран гүйцэтгэдэг.

Унд ахуйн худгийн зориулалттай өөрийн эзэмшлийн 2 /худаг-1, 2/ худгаас сар бүр дээжлэлт хийж Өмнөговь аймгийн стандарт хэмжилзүйн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Мөн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд III, IV улирлын тайланг “Цавчирын хөндий” ХХК боловсруулсан. /Хавсралт/

3.13.2.1. Судалгааны арга зүй

Усны түвшин хэмжих судалгааны арга зүй: IN-SITU багаж нь хөнгөн цагаан дамар, 600 метр хүртэл хэмжих боломжтой, миллметрийн нарийвчлалтай хэмжилт хийдэг, усанд зэвэрдэггүй ган датчик гадаргуутай, багажны үзүүр хэсэг нь худгийн усанд хүрмэгц дуут дохио дугарч усны түвшин болон гүнийг хэмжинэ.

Зураг 3-78. IN-SITU усны түвшиг хэмжигч багаж

Өмнөговь аймгийн Стандарт хэмжилзүйн газар: Химийн шинжилгээний дээж авах аргачлал MNS 3934:1986, усны дээж авах стандарт MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу дээжний савыг дээж авч буй эх үүсвэрийн усаар 2 удаа зайлж савыг дээжээр дүүргэж агаар байх зайгүйгээр 1.5-2 л дээж авдаг.

Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн лабораторийн аргазүй:

№	Шинжилсэн үзүүлэлт	Шинжилгээний арга
1	Ерөнхий хатуулаг	Комплексометрийн арга
2	Хлорид	Аргонометрийн арга
3	Кальци	Комплексометрийн арга
4	Магни	Тооцооны арга
5	Сульфат	Турбидиметрийн арга
6	Төмөр	Колориметрийн арга
7	Аммони, нитрат, нитрит	Харааны колометрийн арга

3.13.2.2. Зураглал

Унд ахуйн худгийн усны шинжилгээ болон малчдын гар худгийн усны түвшин хэмжсэн цэгүүдийг Газарзүйн мэдээллийн системд 1:4000, 1:25000 масштабатай зураглалаа. Хэмжилт хийсэн цэгүүдийн зургийг доор үзүүлэв.



Зураг 3-79. Унд ахуйн худгийн усны дээж авсан цэгүүд



Зураг 3-80. Худгийн усны түвшин хэмжсэн цэгүүд

3.13.2.3. Судалгааын үр дүн

3.13.2.3.1. Худгийн түвшин хэмжилт

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь төслийн талбайн ойр орчмын малчин иргэдийн 8-н худагт сар бүрийн 26-ны өдөр тогтмол усны түвшин хэмжилтийг хийж гүйцэтгэдэг. 2024 оны хувьд Монгол орны хэмжээнд хур тунадас ихтэй жил байсан. Өмнөговь аймгийн 2024 оны хур тунадасны хэмжээг 2023 оны хур тунадасны хэмжээтэй харьцууллаа.

Нийт 8-н худагт хэмжилт хийдэг бөгөөд 2024 онд Сухайт худагт 1-р сард нэг удаа хэмжилтийг хийсэн.

2023 оны хур тунадасны мэдээнээс үзэхэд жилийн нийт хур тунадас 81 мм, 4-р сард хамгийн бага буюу 0.7 мм, 7-р сард хамгийн их буюу 31.1 мм хур тунадас орсон байна. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 9 мм. Харин 2024 оны хур тунадасны мэдээнээс үзэхэд жилийн нийт хур тунадас 355.7 мм, 3-р сард хур тунадас унаагүй, 7-9-р сард хамгийн их буюу 70.6-134.44 мм хур тунадас орсон байна. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 39 мм байна. Энэ нь өмнөх оны нийт хур тунадасны хэмжээнээс 4.3 дахин их буюу нийт хур тунадас 274 мм-ээс их унасан үзүүлэлтэй байна.



Зураг 3-81. 2023-2024 хур тунадасны хэмжээ

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь орон нутгийн иргэдтэй хамтран худгийн усны хэмжилтийг хийдэг. Худгийн хэмжилт хийж байх үеийн фото зургийг доор үзүүллээ.

Зураг 3-82. Худгийн хэмжилт хийх үеийн фото зураг

2024 оны худгийн хэмжилтийн үр дүнгээс харахад хэмжилт хийсэн хугацааны нийт худгийн усны дундаж түвшин 2.6 м, өмнөх оны дүнтэй харьцуулах үзэхэд 0.90 м-ээр багассан байна. Худгийн усны сар бүрийн хэмжилтийн үр дүнг харьцуулан трендийн шугам татаж үзэхэд хар овоо, бударгана толгой худгийн усны түвшин нэмэгдсэн үзүүлэлттэй байхад бусад худгийн усны түвшин багассан байна.



Зураг 3-83. Худгийн хэмжилт 2024 он

Худгийн усны сарын хэмжилтийн үр дүнг 2023 оны хэмжилтийн дүнтэй харьцуулан худаг тус бүрээр дэлгэрэнгүй орууллаа.

Гүн худгийн усны 2023 оны дундаж түвшин 1.73 м, 2024 оны дундаж түвшин 1.43 м байна. Худгийн усны түвшин 0.30 м-ээр буурсан байна.



Зураг 3-84. Гүн худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Хар овоо худгийн усны 2023 оны дундаж түвшин 3.2 м, 2024 оны дундаж түвшин 3.6 м байна. Худгийн усны түвшин 0.40 м-ээр нэмэгдсэн байна.



Зураг 3-85. Хар овоо худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Бударгана толгой худгийн усны 2023 оны дундаж түвшин 3.9 м, 2024 оны дундаж түвшин 2.7 м байна. Худгийн усны түвшин 1.2 м-ээр буурсан байна.



Зураг 3-86. Бударгана толгой худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Заяагийн худгийн усны 2023 оны дундаж түвшин 1.0 м, 2024 оны дундаж түвшин 0.85 м байна. Худгийн усны түвшин 0.15 м-ээр буурсан байна.

Зураг 3-87. Заяагийн худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Дэлгэрэх худгийн усны 2023 оны дундаж түвшин 1.01 м, 2024 оны дундаж түвшин 1.23 м байна. Худгийн усны түвшин 0.12 м-ээр нэмэгдсэн байна.

Зураг 3-88. Дэлгэрэх худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Индэрт худгийн усны 2023 оны дундаж түвшин 0.99 м, 2024 оны дундаж түвшин 0.75 м байна. Худгийн усны түвшин 0.24 м-ээр нэмэгдсэн байна.



Зураг 3-89. Индэрт худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Төмөрбаатарын худгийн усны 2023 оны дундаж түвшин 0.69 м, 2024 оны дундаж түвшин 0.41 м байна. Худгийн усны түвшин 0.28-м-ээр буурсан байна.

Зураг 3-90. Төмөрбаатарын худгийн усны түвшин хэмжилтийн үр дүн

Сухайтын худгийн усыг 2024 оны 1-р сард нэг удаа хэмжсэн. Худгийн усны түвшин 1 метр байна.

3.13.2.3.2. Унд ахуйн худгийн усны хяналт шинжилгээ

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн унд ахуйн худгийн зориулалттай мониторингийн худгуудаас дээжлэлт хийж Өмнөговь аймгийн стандарт хэмжилзүйн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, шинжилгээний үзүүлэлтүүдийг Монгол улсын ундны усны стандарттай харьцуулан тайланг боловсруулсан.

Худгийн усны дээжлэлт хийж байгаа үеийн фото зургийг доор үзүүллээ.

Зураг 3-91. Худаг-1 /оффис зүүн хойно/

Зураг 3-92. Уурхайн оффисын гал тогооноос усны дээж авч буй байдал

Уурхайн унд ахуйн хэрэглээнд ашиглагдаж буй ундны усны худаг, оффисын угаалтуурын ус, оффисын гал тогооны ус, нийтийн гал тогооны ус, нийтийн ариун цэврийн байгууламж гэсэн 6-н цэгээс усны дээжийг авсан. Усны шинжилгээний хими шинж чанарын үзүүлэлтийг доор үзүүллээ.

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны урвалын орчин 7-7.5, дундаж агууламж 7.35 саармаг урвалын орчинтой байна.



Зураг 3-93. Усны урвалын орчин

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны аммоны агууламж 0.08-0.14 мг/л буюу стандартын агууламж 1.5 мг/л-с давсан үзүүлэлтгүй стандарт түвшинд байна. Нийт дээжний аммоны дундаж агууламж 0.1 мг/л байна.



Зураг 3-94. Усны аммоны агууламж

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны кальцийн агууламж 10.02-32.06 мг/л буюу стандартын агууламжаас хэтрээгүй, стандарт түвшинд байна. Нийт дээжний кальцийн дундаж агууламж 15.9 мг/л байна.



Зураг 3-95. Усны кальцийн агууламж

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны магнийн агууламж 14.59-110.08 мг/л буюу стандартын агууламжаас давсан үзүүлэлттэй байна. Нийт дээжний магнийн агууламж 51.0 мг/л байна. Усанд ууссан кальци, магнийн давсны агуулга их байх тусам түүний хатуулаг нь их байдаг.

Магни нь ферментийн найрлага, үйл ажиллагаанд оролцдог биохимийн идэвхтэй элемент юм. Хүний биед 20-40 гр хүртэл магни агуулагдана. Ундны усны магнийн агууламж багасах (11 мг/л-ээс) нь чичрэх, татах, нүд анивчих, зүрхний цохилт олшрох шинж тэмдгүүд илэрнэ.



Зураг 3-96. Усны магнийн агууламж

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны хуурай үлдэгдэлийн агууламж 264.0-370.0 мг/л буюу стандартын агууламжаас хэтрээгүй, стандарт түвшинд байна. Нийт дээжний хуурай үлдэгдэлийн дундаж агууламж 337.8 мг/л байна.



Зураг 3-97. Хуурай үлдэгдэл

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны хатуулагийн агууламж 1.0-1.1 мг-экв/л буюу стандартын агууламжаас хэтрээгүй, стандарт түвшинд байна. Нийт дээжний хатуулагийн дундаж агууламж 1.4 мг-экв/л байна.



Зураг 3-98. Хатуулаг

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны хлоридын агууламж 77.9-106.3 мг/л буюу стандартын агууламжаас хэтрээгүй, стандарт түвшинд байна. Нийт дээжний хлоридын дундаж агууламж 90.6 мг/л байна.



Зураг 3-99. Хлоридын агууламж

Мониторингийн судалгааны үр дүнгээс харахад усны цахилгаан дамжуулах чанар 518.0-719.0 см буюу стандартын агууламжаас хэтрээгүй, стандарт түвшинд байна. Нийт дээжний цахилгаан дамжуулах чанарын дундаж агууламж 661.3 см байна.



Зураг 3-100. Цахилгаан дамжуулах чанар

Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян нь 1мл усанд 100-с ихгүй байх бөгөөд уурхайн худгийн усны нянгийн тоо стандартын агууламжаас хэтрээгүй буюу бохирдолгүй байна.



Зураг 3-101. Уурхайн худгийн усны нянгийн тоо

Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян буюу ялтас шүүлтүүр нь MNS ISO 9308-1:1998 стандартын дагуу 100 мл усанд агуулагдах нянгийн шинжилгээ 3 удаа буюу улирал тутамд хийлгэхэд илрээгүй байна.

Гэдэсний бүлгийн нян болох сальмонелла нянгийн шинжилгээг MNS ISO 19250:2017 стандартын дагуу 25мл усанд агуулагдах нянгийн шинжилгээг 3 удаагийн давтамжтай улирал тутам хийлгэхэд мөн илрээгүй байна.

3.14. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцсан албан тушаалтан	Ажлын гүйцэтгэл
1	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 онд “Энвайроментал Комплайнц” ХХК хийж гүйцэтгэсэн
2	Гэрээт компаниудын ажилчдын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулан, хяналт тавьж ажиллах		“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн гэрээт байгууллагууд болох харуул хамгаалалт, тэсэлгээ, өрмийн компаниудын ажилчдын байгаль хамгаалах үүргийг сайжруулан, хяналт тавин ажиллаж байна
3	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг Ноён, Баяндалай сумдын ЕБС-ын сурагчид болон иргэдийг хамруулан тэдний экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах		Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Цэнхэр тууз” аяны уриан дор Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн албан хаагчдын дунд "Ой ба Ногоон ирээдүй Ус ба Энхтайван" сэдвийн хүрээнд Алтан хонх, АХА тэмцээн зохион байгуулсан. "Ус ба Энхтайван" уриан дор Өмнөговь аймгийн 11 сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах Дэвжээ тэмцээнд Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дэмжин ажилласан

4	Байгаль орчныг хамгаалах талаархи сургалт, уурхай дээр хийгдэж байгаа байгаль орчны ажлуудын талаарх тайлан мэдээллийг уурхайн нийт ажилчдад танилцуулах		Уурхайн нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгаль орчны чиглэлээр уурхайд хийгдэж буй ажлыг танилцуулж, сургалтуудыг зохион байгуулдаг. Тухайлбал БОМТ-нд тусгагдсан ажлууд, хог хаягдлын менежмент, төслийн талбай орчмын ховор ургамал, ургах орчин, амьдралын хэлбэр, үрлэх цэцэглэх хугацаа, амьтны байршил идээшлэн амьдрах орчин ховордлын зэрэг, суурь үнэлгээ, усны хэрэглээ гэх мэт болно
5	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх багийг гаргах, тухайн багийн ажлын төлөвлөгөө гаргах үүнд: хүрээлэн буй орчны гэмт хэргийн талаарх ойлголтыг уурхайн нийт ажилчдад сургалт мэдээллээр өгөх		Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт семинарыг ажилчдын дунд зохион байгуулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт” сургалт

3.14.1. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 онд “Энвайроментал Комплайнц” ХХК хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны аудитын хүрээнд “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн “Баруун Ноён Уул нүүрсний уурхайд аудит хийх явцад үл нийцэл илрээгүй өмнөх 2 удаагийн төлөвлөгөөт аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа сайжруулж илэрсэн зөрчил, дутагдлуудаа арилгасан байгаа тул нэмэлт зөвлөмж байхгүй” гэсэн зөвлөмж өгсөн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ
АУДИТЫН ТАЙЛАН

4 Байгаль орчны аудитын зөвлөмж

Зураг 3-102. Байгаль орчны аудитын тайлан

3.14.2. Гэрээт компаниудын ажилчдын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулан, хяналт тавьж ажиллах

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн гэрээт байгууллагууд болох харуул хамгаалалт, тэсэлгээ, өрмийн компаниудын ажилчдын байгаль хамгаалах үүргийг сайжруулан, хяналт тавин ажиллаж байна.

3.14.3. Баяндалай сумдын ЕБС-ын сурагчид болон иргэдийг хамруулан тэдний экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлын биелэлт

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “УСНЫ ГАЗАР”-аас санаачлан гол мөрөн булаг шандаа Монгол түмний дээд бэлгэдэл цэнхэр хадгаар төлөөлүүлж, гол мөрөн маань үр хүүхдүүдийн маань үед ч өнө мөнхөд урсахын бэлгэдэл болгон "Цэнхэр Тууз" аян эхлүүлсэн.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Цэнхэр тууз” аяны уриан дор Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн албан хаагчдын дунд "Ой ба Ногоон ирээдүй Ус ба Энхтайван" сэдвийн хүрээнд Алтан хонх, АХА тэмцээн зохион байгуулсан. "Ус ба Энхтайван" уриан дор Өмнөговь аймгийн 11 сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах Дэвжээ тэмцээнд Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дэмжин ажилласан.

Зураг 3-103. Ой ба Ногоон ирээдүй, Ус ба энхтайван тэмдэглэлт өдөр

3.14.4. Уурхай дээр хийгдэж байгаа байгаль орчны ажлуудын талаарх тайлан мэдээллийг уурхайн нийт ажилчдад танилцуулах ажлын биелэлт

Уурхайн нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгаль орчны чиглэлээр уурхайд хийгдэж буй ажлыг танилцуулж, сургалтуудыг зохион байгуулдаг. Тухайлбал БОМТ-нд тусгагдсан ажлууд, хог хаягдлын менежмент, төслийн талбай орчмын ховор ургамал, ургах орчин, амьдралын хэлбэр, үрлэх цэцэглэх хугацаа, амьтны байршил идээшлэн амьдрах орчин ховордлын зэрэг, суурь үнэлгээ, усны хэрэглээ гэх мэт болно.

3.14.5. Хүрээлэн буй орчны гэмт хэргийн талаарх ойлголтыг уурхайн нийт ажилчдад сургалтаар мэдээллэх ажлын биелэлт

Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт семинарыг ажилчдын дунд зохион байгуулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт” сургалтыг зохион байгуулсан.

Зураг 3-104. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт

3.14.6. Сайжруулсан шороон замын ажлын биелэлт

Орон нутгийн удирдлагаас тавьсан саналын дагуу Ноён сум–Сэврэй сум хоорондох зам дагуу Жарангийн элс нэртэй газарт 3.2 км орон нутгийн шороон замыг засаж сайжруулах ажлыг 2024 оны 7-р сард хийж гүйцэтгэсэн.

Зураг 3-105. Сайжруулсан шороон зам

3.14.7. Байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан байгалийн ургамлыг таньж мэдэцгээе сургалтын биелэлт

9-р сарын 4 дэх долоо хоногт “Байгаль хамгаалах” өдрийг тохиолдуулан Ноён сумын дунд сургуулийн сурагчдад “Байгалийн ургамлыг таньж мэдэцгээе” сэдэвт танхимын болон практик сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар сурагчдад говийн бүсд ургадаг мод, байгалийн ургамлыг таних, ховор болон нэн ховор зүйлийн ургамлыг байгаль дээр таниулах ажлыг уурхайн бүсэд зохион байгуулсан.

Зураг 3-106. Байгаль хамгаалах өдрийн хүрээнд зохион байгуулсан сургалт

3.15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг орон нутагт танилцуулах ажлын биелэлт

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Хариуцсан албан тушаалтан	Ажлын гүйцэтгэл
1	Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчдад шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх /ус ашиглалт, хог хаягдал/	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь орон нутгийн байгаль орчны байцаагч Т.Болдмаатай хамтран ажилдаг. Сар бүрийн 25-ны өдөр ашигласан усны хэмжилтийг шүүрлийн ус, унд ахуйн хэрэглээний 2 худагт хамтран хийж, аюултай болон ахуйн хог хаягдлын

			хэмжээ, ачилтын мэдээллийг хамтран хөтөлдөг
2	Иргэдийн төлөөлөл, шалгалтын комиссд БОМТ-ийн биелэлтийг танилцуулах	-	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг сум орон нутгийн иргэдэд танилцуулж санал, зөвлөмжийг тусган ажиллаж байна

3.15.1. Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх ажлын биелэлт

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь орон нутгийн байгаль орчны байцаагч Т.Болдмаатай хамтран ажилдаг. Сар бүрийн 25-ны өдөр ашигласан усны хэмжилтийг шүүрлийн ус, унд ахуйн хэрэглээний 2 худагт хамтран хийж, аюултай болон ахуйн хог хаягдлын хэмжээ, ачилтын мэдээллийг хамтран хөтөлдөг.

3.15.2. Иргэдийн төлөөлөл, шалгалтын комиссд БОМТ-ийн биелэлтийг танилцуулах

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг сум орон нутгийн иргэдэд танилцуулж санал, зөвлөмжийг тусган ажиллаж байна.

3.15.3. 2024 оны БОМТ-нд оруулах орон нутгийн саналын биелэлт

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтөд уурхайн дотоод тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх

Уурхайн тоосжилтын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд, зам талбайн засвар арчилгаа, дотоод журмын хүрээнд хурдны хязгаарлалт тогтоож тэмдэг, тэмдэглэгээг байршуулан, тоосжилт үүсдэг уурхайн бүсийн зам талбай, нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын талбайд усалгааг шүүрлийн ус ашиглан тогтмол хийж байна.

2. Хог хаягдлын төв байгуулах ажлын зэрэгцээ, хогийг сумын нэгдсэн хог хаягдлын цэгт хаяхгүй байх

Өмнөговь аймгийн Ноён суманд байрлах төвлөрсөн хогийн цэгийн талбайг 361 м^2-аар төлөвлөж сумаас 116 м² талбайг хашаажуулж, үлдсэн 245 м² талбайг “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн зүгээс шаардлагатай бараа материалыг захиалж хогийн цэгийг бүрэн ашиглалтанд оруулсан.

3. Хог хаягдлыг ангилан ялгалтыг сайжруулах, аюултай хог хаягдлыг хадгалах цэгийг стандартын шаардлагыг хангаж байгуулах, нийт талбайн хэмжээнд 7 хоног бүрийн нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, ил задгай хаягдалгүй байх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх

Уурхайн нийт ажилчид 7 хоног бүрийн ням гарагт уурхай болон уурхайн кемпийн орчмын хог хаягдлыг тогтмол цэвэрлэж байна. Хог хаягдлын дотоод журмыг баримталж, ангилан ялгах хогийн савыг байршуулсан, өмнө нь байсан хогийн цэгийг засаж янзалсан, эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савуудыг байршуулан ажиллаж байна.

4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ойжуулалтын төлөвлөлт хийж, 2024 онд 10-аас доошгүй га талбайд заг тарих

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Наран багийн Цагаан гол нэртэй газарт 10 га талбайг хашаажуулан “Эрдэнэдрийлинг” ХХК-аар усны хайгуулын судалгааг хийлгэж, худаг гаргуулан усалгааны системыг шийдүүлж, эгнээ хооронд 3м, зайтай 4132ш заг модыг тариалаад байна.

5. Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг 3-с доошгүй удаа сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Цэнхэр тууз” аяны уриан дор Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн албан хаагчдын дунд "Ой ба Ногоон ирээдүй Ус ба Энхтайван" сэдвийн хүрээнд Алтан хонх, АХА тэмцээн зохион байгуулсан. "Ус ба Энхтайван" уриан дор Өмнөговь аймгийн 11 сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах Дэвжээ тэмцээнд Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дэмжин ажилласан.

“Байгаль хамгаалах” өдрийг тохиолдуулан Ноён сумын дунд сургуулийн сурагчдад “Байгалийн ургамлыг таньж мэдэцгээе” сэдэвт танхимын болон практик сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар сурагчдад говийн бүсд ургадаг мод, байгалийн ургамлыг таних, ховор болон нэн ховор зүйлийн ургамлыг байгаль дээр таниулах ажлыг уурхайн бүсэд зохион байгуулсан.

6. Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах зорилгоор биотехникийн арга хэмжээг санхүүжилтийг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

Зэрлэг ан амьтанд мөс болон өвс тавих биотехникийн арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 20, 03 дугаар сарын 13, 04 дүгээр сарын 17-ний өдөр нийт 100 боодол өвс, 50 ш хорголжин тэжээлийг “Зэрлэг амьтдад (аргаль, янгир, зээр)” зориулан биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн.

7. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг ажиллуулах төлөвлөгөө, санхүүжилтийг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

Орон нутагтай хамтран хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг ажиллуулах ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.

8. Хяналт шинжилгээ, мониторинг хийх арга зүйг батлан мөрдөж ажиллах, хяналт мониторингийн ажилд иргэдийг оролцуулан хөндлөнгийн хяналттай хийж байх

Мэргэжлийн байгууллага уурхайн талбай дээр ажиллаж, хээрийн хэмжилт судалгаа хийх үед орон нутгийн малчин иргэдийн төлөөллийг оролцуулан хяналт шинжилгээ хийлгэсэн. Мэргэжлийн судлаачид иргэдийн сонирхсон асуултад тайлбар мэдээлэл өгч, нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллалаа. Мөн сар бүрийн худгийн усны хэмжилтэд орон нутгийн иргэдийг оролцуулан ажиллаж байна.

9. Байгаль хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа ажлын тайланг уурхай дээрээ танилцуулах ажлыг 2-с доошгүй удаа зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлэх

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэл, хог хаягдлын менежмент, биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг танилцуулдаг. Жил бүрийн усны тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын төлөвлөгөө,

жилийн эцсийн биелэлтийн тайланг ажилчдад танилцуулж, цаашид анхаарч ажиллах арга хэмжээг ярилцан төлөвлөж, танилцуулгыг тогтмол хийдэг.

10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд хайгуулын ажлын үед эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг төлөвлөн, хэрэгжүүлж байх

Жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан нөхөн сэргээлт хийх талбайг төлөвлөн ажилладаг. 2024 онд хайгуулын цооногуудын нөхөн сэргээлт, өмнөх онуудад хийгдсэн хайгуулын суваг малталтуудад техникийн нөхөн сэргээлтийг энэ онд гүйцээн хийсэн. Шимт хөрсний овоолго үүсгэсэн бөгөөд салхины элэгдлээс үүдэн шимт хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж олон наст ургамлыг (өлөнгө, ерхөг) тус бүр 200 кг буюу нийт 400 кг үрийг хольж тарилт хийсэн.

11. Шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүй хадгалах стандарт шаардлагыг хангаж ажиллах

Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт хийх Монгол улсын стандарт MNS 5916:2008 стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тухайлбал: Өндөр нь 5 м-ээс илүүгүй, тусгай талбайд хадгалж, олон наст өвслөг ургамал тариалан ажиллаж байна.

12. Төлөвлөлтийг сайжруулах, хийх ажлыг нарийвчлан тодорхой тусгах, тайлангийн бичилтийг сайжруулах, тоо баримт үндэслэлийг тодорхой оруулах, баримт нотлогоог хавсралтаар бүрэн оруулах

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь байгаль орчны чиглэлээр хийгдэж буй ажлын тайлан мэдээг дэлгэрэнгүй оруулан ажиллаж байна.

3.16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн төсвийн задаргаа

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардалд **265,103,885** /хоёр зуун жаран таван сая нэг зуун гурван мянга найман зуун наян таван/ төгрөгийг зарцуулсан.

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зардал, мян.төг	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Агаарын чанар, газрын доорхи ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баяндалай Цагааны гол заг тариалалт	123,417,500
			Баяндалай сумын наадмын талбайн мод тарилтын ажилд 2024 онд нэмэлтээр хийгдсэн ажлын зардал	4,000,000
			Биотехникийн арга хэмжээ	9,500,000
2	Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны дотоод зардал	
		Биологийн нөхөн сэргээлт /Мод сөөг үржүүлэх, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих/	11,600,00 ₮	
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах, гарын авлага хэвлүүлэх	Үйл ажиллагааны дотоод зардал	

		Хилчдийн байгаль хамгаалах ажлын мэдлэгийг дээшлүүлэх сургалт	Үйл ажиллагааны дотоод зардал
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн 13-н айлын нөхөн олговор	Үйл ажиллагааны дотоод зардал
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Дугуй булшийг хашиж хамгаалах	Үйл ажиллагааны дотоод зардал
6	Осол эрсдэлийн менежмент	Байгаль орчны чиглэлийн сургалтууд, галын аюулгүй байдлын сургалт, дадлага	10,000,000
7	Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах, ангилан ялгалт бүхий хогийн савыг байршуулах, аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь стандартын дагуу бохирдол үүсгэхгүйгээр түр хадгалах цэгийг тохижуулах, мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах	71,104,385 ₮
8	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны аудит, байгаль орчны дотоод хяналтыг зохион байгуулах, сургалт мэдээлэл өгөх, орон нутгийн байгаль орчны байцаагчтай хамтарч ажиллах	10,000,000 ₮
9	Орчны хяналт шинжилгээ	Агаарын чанарын хяналт шинжилгээ	30,000,000 ₮
		Усны хяналт шинжилгээ	
		Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ	
		Хөрсний хяналт шинжилгээ	
10	Олон нийтэд тайлагнах	ОХШ-ний ажилд малчин иргэдийг оролцуулан судалгаа хийх, төрийн захиргааны төв байгууллагад тайлан мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж ажиллах	Үйл ажиллагааны дотоод зардал
Нийт зардал, мян.төг			**265,103,885**

ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Ноён суманд орших “Баруун Ноён Уул” нүүрсний уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд нийт 53 ажлыг төлөвлөсөн. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ 19, нөхөн сэргээлт 3, биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 4, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 1, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 1, осол эрсдэлийн менежмент 5, хог хаягдлын менежмент 5, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 8, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ 5, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах 2 гэсэн ажлуудыг төлөвлөсөн.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

Уурхайн зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор тогтмол усалгаа хийж байна. Уурхайн нүүрс тээврийн зам, кемп орчим, дотоод тээврийн замуудад замын арчилгааг дор бүр хийнэ ажилсан. Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн хурдыг дотоод журамд тусгагдсаны дагуу хурдны хязгаарлалтыг мөрдлөг болгон ажиллаж байна. Уурхайн кемпэд орчны тохижилт, ажилчдын амрах орчин бүрдүүлэхээр зүлэгжүүлэлт хийсэн. Модлог ургамал, ногоон байгууламжийн арчилгааг хийж, дулааны улиралд тогтмол усалгаа хийдэг. Уурхайн усны хэрэглээг хянахын тулд кемпийн унд ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа 1 болон 2-р худгийн тоолуурын заалтыг сар бүр бүртгэж, өмнөх сарын дүнтэй харьцуулан, хяналт шинжилгээг хийж, усны төлбөрийг тухай бүрд нь төлж байна. Уурхайн ногоон байгууламжийн усалгааг шүүрлийн усаар хангаж, шүүрлийн усанд өдөр бүр хяналт тавин ажилладаг. Уурхайн ажилчдын өглөө, оройны ажлын төлөвлөлт өгөх /наряд/ үеэр ажилчдад усны хэрэглээний талаар сургалт болон постероор танилцуулга хүргүүлдэг. Жил бүрийн усны өдрөөр мэдээллийн самбарт зааварчилгаа байршуулан, нийт ажилчдад мэдээллийг хүргэдэг. Уурхайн шүүрлийн усыг зориулалтын авто машинаар соруулан авто замын усалгаанд ашигладаг.

Уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан, шимт хөрсийг зохих гүний дагуу хуулж, бүртгэл маягтыг хөтлөн, талбайн хэмжээг газарзүйн мэдээллийн системд зурагласан. Уурхайн уулын хэсэг болон уурхайн тосгонд шатах тослох материал санамсаргүйгээр алдагдах үед ашиглагдах шингээгч материалыг шаардлагатай хэсгүүдэд байршуулсан.

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд Өмнөговь аймгийн Баяндалай сумын наадмын талбайг тойруулан нийт 2.2 га талбайд 9000 ш хайлаас, улиас тариалсан ба 2024 онд нэмэлтээр усалгааны системийг угсран орон нутагт хүлээлгэн өгсөн. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд өртөгдөж байгаа газрын ургамлын судалгааг хийж, ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн бүртгэл хийн ажиллаж байна.

Өвөлжилт хүндрэх, хаврын тарчиг үед өвс болон тэжээлийг бэлчээр нутагт нь байршуулсан. Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох талаар ажилчдад мэдээлэл сургалт орсон.

Нөхөн сэргээлт:

2024 онд нэмэлт хайгуул судалгааны ажлын хүрээнд шинээр өрөмдсөн цооногууд, хайгуулын сувгуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 3.6 га талбайд шимт хөрсний овоолго үүсгэсэн бөгөөд салхины элэгдлээс үүдэн шимт хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж олон наст ургамал (өлөнгө, ерхөг) тус бүр 200 кг буюу нийт 400 кг үрийг хольж тарилт хийсэн.

Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ:

Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ: Төслийн талбайн байршилтай уялдуулан ургамлын онцлог, амьдрах чадварт тохируулан, үрийг түүх боломжит ургамлын судалгааг хийж, гарын авлагыг боловсруулан байгалийн ургамлыг түүхдээ удирдамж болгон ажилласан. ДХ талбайн хөрсний хэв шинж, ургамлын аймаг зонхилон ургах ургамал, ховор болон нэн ховор ургамлын талаар, бүс нутагт амьдрах амьтны аймаг, төрөл зүйлийг хууль бусаар ан хийсэн болон нэн ховор ургамал түүсэн тохиолдолд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг танилцуулж, Цагаан толгойд талд хэрэгжүүлж буй ДХ ажлыг танилцуулсан. “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн уурхайн тосгонд улиас, шар хуайс, улаан сухай зэрэг ургамлыг мод үржүүлгийн талбай байгуулан тариалсан. Цагаан толгойн талд нарны зайн үүсгүүрээр ажилладаг, хөв цөөрөмтэй, автомат мэдрэгчээр усаа шахдаг худгийг гарган биологийн олон янз байдлыг тэтгэн ажиллаж байна.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ:

Уурхайн нөлөөллийн бүсэд хамрагдсан 13 айлтай 2022 онд гэрээ байгуулан, гэрээний дагуу нөхөн олговрыг олгон ажилласан.

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ:

Хайгуулын шатанд археологийн судалгааны үр дүнд 6 дурсгал тэмдэглэгдсэн. Эдгээр дурсгалуудаас №5 дугаартай дугуй булш лицензийн талбай дотор байгаа бөгөөд тухайн дурсгал орчимд одоогоор ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд №5 дугуй булшийг хашиж хамгаалан тэмдэгжүүлсэн.

Осол, эрсдэлийн менежмент:

Галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтыг хийж, гал гарсан үед ашиглагдах багаж хэрэгслийг талбайн гадна болон дотор байршуулан ажилласан. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гал түймэр унтраах аврах 067-р ангийн баг хамт олон “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн уурхайн тосгонд хүрэлцэн ирж Галын аюулгүй байдлын мэдлэг олгох онол, практикын дадлага сургуулилтыг амжилттай зохион байгуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх бичиг баримтыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна. Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилж, ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д, ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан оршихуй групп” ХХК, “Эко стандарт петролиум” ХХК-д шилжүүлдэг. Уурхайн засвар үйлчилгээний хэсэгт химийн бодис асгарсан үед бохирдсон хөрсийг хусаж аван түр хадгалах талбайд цуглуулж хог хаягдлын мэргэжлийн гэрээт компанид хандан ажилладаг. Уурхайн уулын хэсэг болон уурхайн тосгонд шатах тослох материал

санамсаргүйгээр алдагдах үед ашиглагдах шингээгч материалыг шаардлагатай хэсгүүдэд байршуулсан.

Хог хаягдал:

Уурхайн тосгонд байрлах үед хог хаягдлын дотоод журмыг баримталж, ангилан ялгах хогийн савыг байршуулсан, өмнө нь байсан хогийн цэгийг засаж янзалсан, эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савуудыг уурхайн тосгон болон гааль хяналтын хэсэгт байршуулсан. Өмнөговь аймгийн Ноён суманд байрлах төвлөрсөн хогийн цэгийн талбайг 361 м2-аар төлөвлөж сумаас 116 м² талбайг хашаажуулж, үлдсэн 245 м² талбайг “Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн зүгээс шаардлагатай бараа материалыг захиалж хогийн цэгийг бүрэн ашиглалтад оруулсан. Уурхайн нийт ажилчид 7 хоног бүрийн Ням гаригт уурхайн тосгонд бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэдэг. Засварын хэсгээс гарч байгаа хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлэн, гэрээт байгууллага руу нийлүүлдэг. Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилаж ялган түр байршуулж, “Түмэн Эгшиг” ХХК-д шилжүүлдэг. Ашигласан тос маслыг 50 тн-ий ёмкость хадгалж “Алтан оршихуй групп” ХХК, “Эко стандарт петролиум” ХХК-д шилжүүлдэг. Эмнэлгийн хог хаягдлын бүртгэлийг хөтөлж Ноён сумын эмнэлэгт 14 хоногт нэг удаа нийлүүлж устгуулдаг.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:

“Баруун Ноён Уул” уурхайн орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаарын чанарын 8 цэг, хөрсөн бүрхэвчийн 7, усны хяналт шинжилгээний 11 цэг, ургамлын хяналт шинжилгээний 8 цэгт БО-ны хэлтэс болон мэргэжлийн байгууллага “Цавчирын Хөндий” ХХК-тай хамтран хийж гүйцэтгэсэн.

Агаарын чанарын хүрээнд 8 цэгт хэмжилт хийхэд PM 2.5, PM 10 тоосны агууламж гаалийн хяналтын талбайд МУ-ын агаарын чанарын стандарт MNS 4885:2016 стандартаас давсан үзүүлэлттэй байна. Харин бусад цэгт хэмжсэн тоосны хэмжээ MNS 4885:2016-аас бага буюу хэвийн хэмжээнд байна.

Төслийн талбайн ойр орчимд байрлах малчны 8-н худагт сар бүрийн 26-нд усны түвшин хэмжилтийг хийж гүйцэтгэдэг. 2024 оны худгийн хэмжилтийн үр дүнгээс харахад хэмжилт хийсэн хугацааны нийт худгийн усны дундаж түвшин 2.8 м, өмнөх оны дүнтэй харьцуулах үзэхэд 0.4 м-ээр ихэссэн байна. Худгийн усны сар бүрийн хэмжилтийн үр дүнг харьцуулан трендийн шугам татаж үзэхэд бударгана толгой худгийн усны түвшин ялимгүй 10 см багассан үзүүлэлттэй байхад бусад худгийн усны түвшин нэмэгдсэн байна. Худгийн усны түвшин нэмэгдэх нь орох хур тунадасны хэмжээтэй шууд хамааралтай байна. Уурхайн унд ахуйн хэрэглээнд ашиглагдаж буй ундны усны худаг, оффисын угаалтуурын ус, оффисын гал тогооны ус, нийтийн гал тогооны ус, нийтийн ариун цэврийн байгууламж гэсэн 6-н цэгээс усны дээжийг авсан. Худгийн усны судалгааны үр дүнгээс харахад саармаг урвалын орчин, аммоны, кальци, хатуулаг, хлорид, цахилгаан дамжуулах чанар стандарт хэмжээнээс хэтрээгүй байна.

Ургамалжилтын судалгааны үр дүнд судалгааны талбай түүний орчимд ландшафтын онцлогоос хамааран гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн Монгол өвс-харганат болон Баглуур-бударганат бүлгэмдэл тархсан байна. Бүлгэмдлийн зүйлийн бүрэлдэхүүний хувьд 13 овгийн, 26

төрөлд хамаарах 33 зүйл ургамал бүртгэгдсэн байна. Эдгээр ургамлын амьдралын хэлбэрийн хувьд сөөглөг ургамлууд 71 хувьтай зонхилж, өвслөг ургамал 29 хувьтай дэд зонхилогчоор тархсан байна. Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу бэлчээрийг доройтлын зэргээр нь сул, дунд, хүчтэй доройтсон ба доройтоогүй хэвийн соргог бэлчээр гэж дүгнэлт өгсөн.

Хөрсний судалгаа шинжилгээний ажлын хүрээнд 7-н цэгээс өнгөн хөрсний дээжлэлтийг хийж, бохирдлын дээжийг холимог байдлаар авсан. Хөрс нь шүлтлэгээс хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж багатай, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, бүх дээж карбонаттай, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамж дундаж, хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд элсэн фракцийн утга давамгайлсан, элсэнцэр болон нарийн элсэн хөрстэй байна. Хөрсний мониторингийн цэгүүдээс авсан өнгөн хөрс (0-10см)-ний дээжүүдэд Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цагаан тугалга (Sn), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг тодорхойлуулсан. Хөрсний бохирдуулагчийн бодисын стандарт MNS 5850:2019 стандарттай харьцуулж үзэхэд хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдолгүй байна.

БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт:

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 онд “Энвайроментал Комплайнц” ХХК хийж гүйцэтгэсэн. Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Цэнхэр тууз” аяны уриан дор Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн албан хаагчдын дунд "Ой ба Ногоон ирээдүй Ус ба Энхтайван" сэдвийн хүрээнд Алтан хонх, АХА тэмцээн зохион байгуулсан. "Ус ба Энхтайван" уриан дор Өмнөговь аймгийн 11 сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах Дэвжээ тэмцээнд Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дэмжин ажилласан. Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт семинарыг ажилчдын дунд зохион байгуулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт” сургалтыг орсон.

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ажлын хүрээнд **265,103,885** /хоёр зуун жаран таван сая нэг зуун гурван мянга найман зуун наян таван/ төгрөг зарцуулсан байна.

ХАВСРАЛТ

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээ
2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл
3. БОНХҮ батлагдсан нүүр
4. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
5. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө
6. Байгаль орчны барьцаа төлбөр байршуулсан баримт
7. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт
8. 2024 оны усны дүгнэлт
9. 2024 оны ус ашиглах гэрээ, зөвшөөрөл
10. Ой ус, тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй эсэх лавлагаа
11. Худгийн тоолуур суурилуулалтын акт
12. Сарын бүрийн ус ашиглалтын төлбөрийн баримт
13. Хаягдал усны дүгнэлт
14. Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар
15. Аюултай хог хаягдлын гэрээ
16. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг, нэхэмжлэх, төлбөрийн баримт
17. Ахуйн бохир ус зайлуулах гэрээ, гэрээний дагуу бохирын зөөвөрлөлтийн бүртгэлийн хуулбар, төлбөрийн баримт
18. Энгийн хог хаягдал тээвэрлэх гэрээ, хог тээврийн бүртгэл, төлбөрийн баримт
19. Орчны хяналт шинжилгээ 1, 2-р улирлын дээжний үр дүн
20. Орчны хяналт шинжилгээ 3-р улирал
21. Орчны хяналт шинжилгээ 4-р улирал

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2013.02.04 — № 000048128 — 9019071068

/ Бүртгэсэн он,сар,өдөр / — / Улсын бүртгэлийн дугаар /

5671833

/ Регистрийн дугаар /

Хур эрдэнэ баялаг

Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тушаал — Г/253 — 2013.01.15

/ шийдвэрийн нэр / — / дугаар / — / он, сар, өдөр /

4610 — Гадаад худалдаа

/ код / — / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

13.01.25~15.01.25 — 1 — 139,500.00

/ хугацаа / — / гишүүдийн тоо / — / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 5-р хороо, үндсэн хуулийн гудамж, Их үйлсийн эрэлд ХХК-ийн байр 108 тоот,
Утас1: 91912618, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Хаданбамжийн банк	Валютын	10450059385	Э.Эрдэнэбилэг

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	GENG овогтой XIN-г Захирал-р томилсныг бүртгэв.	2013.02.04	Э.Эрдэнэбилэг
2	Хувь нийлүүлэгчээс 3 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2013.06.14	Э.Эрдэнэбилэг
3	Худалдаа хөгжлийн банк банкны 404212547 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Худалдаа хөгжлийн банк банкны 404212548 тоот валютын дансыг бүртгэв. Худалдаа хөгжлийн банк банкны 404212549 тоот валютын дансыг бүртгэв.	2013.07.22	Э.Мөнхзаяа
5	Өөрийн хөрөнгийн хэмжээ 1626900 мян.төг-р нэмэгдэж нийт 1766400 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2014.04.15	Э.Мөнхзаяа
6	Ажиллах хугацааг 2014.09.15 -ний өдрөөс 2017.01.25 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2014.09.16	С.Уянга
7	Ажиллах хугацааг 2017.01.25 -ний өдрөөс 2019.01.25 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2016.12.02	Ж.Оюунаа
8	WANG овогтой YIDA -г Захирал-р томилсныг бүртгэв.	2017.06.29	Ж.Оюунаа
9	Ажиллах хугацааг 2019.01.25 -ний өдрөөс 2021.01.25 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2019.01.07	Г.Алтай
10	Улаанбаатар, Сүхбаатар, 3-р хороо, 5 хороолол, , , "Номуун хотхон" 37-р байр, 152 тоот, Утас1 85956868, Утас2 , Факс хаягийг шинэчлэн бүртгэв.	2019.08.08	Г.Алтай
11	0899 Ашигт малтмал ашиглалт /2043.04.17 хүртэл/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4530 Авто машины сэлбэг, эд ангийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4923 Авто машинаар ачаа тээвэрлэх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 7820 Гэрээгээр ерөмдлөгө хийх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 7710 Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн түрээс эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 5210 Уул уурхайн тоног төхөөрөмж, авто машины агуулах эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.08.08	Г.Алтай
14	овогтой DONG XIANGRUI -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.08.08	Г.Алтай

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛААЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-017301***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Өмнөговь аймаг /хот/-ийн

Ноён сум /дүүрэг/-ын

Баруун ноён уул нэртэй газарт орших

1085.20 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***9019031059*** тоот гэрчилгээтэй

"Пибодивинсвэй ресорсез" ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2043.04.17*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЧИНБААТАР

2013 оны 4 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-017301

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	• Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2013.04.17	1085.2 Га	0 Га	1	102° 23' 4.9"	43° 6' 0.26"
				2	102° 23' 4.9"	43° 5' 29.58"
				3	102° 30' 0.89"	43° 5' 29.58"
				4	102° 30' 0.89"	43° 5' 1.29"
				5	102° 22' 0.8"	43° 5' 1.31"
				6	102° 22' 0.8"	43° 6' 0.26"
				2013-04-17 Д. Мягмарсүрэн		
002-TF	• Тусгай зөвшөөрлийг 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаартай Хур эрдэнэ баялаг ХХК-д шилжүүлэх Шийдвэрийн огноо: 2014.01.24	1085.2 Га	0 Га	1	102° 23' 4.9"	43° 6' 0.26"
				2	102° 23' 4.9"	43° 5' 29.58"
				3	102° 30' 0.89"	43° 5' 29.58"
				4	102° 30' 0.89"	43° 5' 1.29"
				5	102° 22' 0.8"	43° 5' 1.31"
				6	102° 22' 0.8"	43° 6' 0.26"
				2014-01-24 Д. Мягмарсүрэн		

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-017301

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	• Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2013.04.17, дуусах хугацаа 2043.04.17 • Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв • Кадастрын хэлтсийн даргын 2013.04.15-ний 173 тоот шийдвэр	2013-04-17
002-TF	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаартай Хур эрдэнэ баялаг ХХК-д шилжүүлэх • Кадастрын хэлтсийн даргын 2014.01.24-ний 26 тоот шийдвэр	2014-01-24
003-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.04.17 – 2015.04.17 хүртэл	2014-04-10 01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
004-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.04.17 – 2016.04.17 хүртэл	2015-03-02 01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
005-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.04.17 – 2017.04.17 хүртэл	2016-03-17 01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
006-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.04.17 – 2018.04.17 хүртэл	2017-05-31 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
007-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.04.17 – 2019.04.17 хүртэл	2018-04-16 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-017301

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.04.17 – 2020.04.17 хүртэл	2019-04-22
009-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.04.17 – 2021.04.17 хүртэл	2020.11.09
010-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.04.17 – 2022.04.17 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХХА0685 2021.05.12
011-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.04.17 – 2023.04.17 хүртэл	1 АМГТГ ГЭНДЭГИЙН УНДУУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2022.03.31
012-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.04.17 – 2024.04.17 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.04.10

БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Ц. УРАНЧИМЭГ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ С. НЯМЖАВ

ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ-НИЙ ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
6726658

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"ГУРВАН ОРЧИЛ МАНДАЛ" ХХК Нэр: ..... Гарын үсэг: .....

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ Нэр: ..... Гарын үсэг: .....

2024 ОН

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК
ЗАХИРАЛ

ДУН ШИАН РУИН

"ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК НИЙ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ."ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ" ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017301
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5671833

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц. ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:
"ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Д.БУЯНЗУЛ

2024 ОН

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2022 оны 12 дугаар сарын ..... –ны өдрийн
..... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

Батлав:
Хур эрдэнэ баялаг ХХК-ийн
захирал ..... / Ц.Ганзориг /

Хүлээн авсан:
АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн
дарга ..... / Т.Зуунхаст /

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН БАРУУН НОЁН УУЛ ОРДЫН 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашигт малтмалын төрөл: Чулуун
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-017301
Нэмэлт АТЗ-ийн дугаар:

ХҮЛЭЭН АВАВ
Уул уурхайн хэлтэс

Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн /П.Зоригт/

БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер .....
2. Уулын инженер .....
3. Баяжуулагч инженер .....
4. Механик инженер .....
5. Эдийн засагч .....

2024 он

ХААН БАНК

Огноо/Date: 2024.01.10 13:28:55

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000631089990

Системийн огноо/System Date:2024.01.10 12:31:39

Дт/From	**Дансны/Картын дугаар Account/Card number** 5179028119	**Нэр/Name** ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ	**Дүн/Amount** 95,800,000.00 MNT	**Ханш/Rate** 1.00
/ Ерэн таван сая найман зуун мянган төгрөг /				
Кт/To	**Банкны дугаар/Branch No** 90 **Дансны/Картын дугаар Account/Card number** 100900013406	**Банкны нэр Bank Name** Төрийн Сан **Нэр/Name** БО нөхөн сэргээх баталгаа	95,800,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Хур Эрдэнэбаялаг 5671833 2024 оны БОМТ-ийн барьцаа

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.12.20 № 01/1487

танай 2023.11.21-ны № 11/06-т

“ГУРВАН ОРЧИЛ МАНДАЛ” ХХК-Д

Дүгнэлт хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2023 оны 11/06 тоот албан хүсэлт, Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт “Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн хэрэгжүүлэх “Баруун Ноён уулын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон холбогдох бусад материалыг судлан үзээд Усны тухай хуулийн $16^1.4.10$ дахь заалтыг үндэслэн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гарган хавсралтаар хүргүүлж байна.

Цаашид Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж, ногоон байгууламжийн усалгаанд хур бороony усыг хуримтлуулан ашиглаж, усны нөөцийг хэмнэж ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт: 2 хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө, усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

15[illegible]324

УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар-..217 | Улаанбаатар хот 51-265526, 51-265528

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:
"Хур эрдэнэ баялаг" ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019071068, регистрийн дугаар: 5671833, Холбогдох утасны дугаар: 99703692

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:
"Гурван орчил мандал" ХХК, холбогдох утасны дугаар: 91020792

3. Төслийн нэр, байршил:
Баруун Ноён уулын чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт, Улаанбаатар хотоос 780 км, Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос баруун тийш 210 км, Ноён сумын төвөөс зүүн тийш 30 км зайд байрлах бөгөөд Алтайн Өвөр говийн сав газарт хамаарагдана.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:
MV-017301 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:
Төсөл нь 2 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд жилд 1,000.0 мян.тн чулуун нүүрс олборлох хүчин чадалтай. Уурхайд 450 ажилтан жилд 330 хоног ажиллана.

6. Усны эх үүсвэр, байршил:
Төслийн усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн 2019, 2023 онд гаргуулсан 6.0 л/сек (518.4 м^3/хон) нийлбэр ундаргатай 2 гүний худаг, "Буурцагт алмаз" ХХК-ийн 2023 онд гүйцэтгэсэн "Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь Баруун Ноён Уул нэртэй нүүрсний уурхайн талбайд гүйцэтгэсэн гидрогеологийн судалгааны үр дүн, уурхайд орж ирэх усны тооцоо"-нд тусгагдсан уурхайн 14.0 л/сек (1,209.6 м^3/хон) шүүрлийн уснаас хангахаар төлөвлөсөн байна:

Худгийн байршил: 102° 28' 0.57", 43° 5' 19.086", ундарга 5.0 л/сек;
102° 24' 49", 43° 5' 51.6", ундарга 1.0 л/сек;

7. Ашиглах усны хэмжээ:
Төслийн жилийн усны хэрэглээг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор болон БОННҮ-ийн төсөлд үндэслэн тооцоход:

Унд, ахуйн ус хэрэглээ:
450 хүн x 150 л/хон = 67.5 м^3/хон x 330 хон = 22,275.0 м^3/жил;

Хотхоны халаалтын уурын зуухны усны хэрэгцээ:
4.0 Гкал/жил x 2.0 м^3 = 8.0 м^3/жил (жилд 240 хоног ажиллана);

Ногоон байгууламжийн усалгаанд:
Уурхайн тосгон: 5,500.0 м^2 x 4 л/м^2 = 22.0 м^3/хон x 205 удаа = 4,510.0 м^3/жил;
Хөрсний овоолго: 125,000.0 м^2 x 4 л/м^2 = 500.0 м^3/хон x 205 удаа = 102,500.0 м^3/жил;
Нөхөн сэргээлт: 55,750.0 м^2 x 4 л/м^2 = 223.0 м^3/хон x 205 удаа = 45,715.0 м^3/жил;

Зам, талбайн усалгаанд:
Дотоод: 196,000.0 м^2 x 2 л/м^2 = 392.0 м^3/хон x 252 удаа = 98,784.0 м^3/жил;
Гадаад: 72,000.0 м^2 x 2 л/м^2 = 144.0 м^3/хон x 252 удаа = 36,288.0 м^3/жил;

Төслийн нийт ус ашиглалт 1,348.54 м^3/хон (310,080.0 м^3/жил).

8. Дүгнэлт:

"Хур эрдэнэ баялаг" ХХК-ийн хэрэгжүүлэх "Баруун Ноён уул"-ын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах унд ахуйн, хотхоны ногоон байгууламж, нөхөн сэргээлт, уурын зуухны усны хэрэгцээний 312.5 м^3/хон усны хэрэглээг өөрийн эзэмшлийн 6.0 л/сек (518.4 м^3/хон) нийлбэр ундаргатай 2 гүний худгаас, хөрсний овоолго, зам талбайн усалгааны 1,026.0 м^3/хон усны хэрэгцээг уурхайн 1,209.6 м^3/хон шүүрлийн уснаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ **хүрэлцээтэй** байна.

9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Төслийг хэрэгжүүлэхдээ Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 24 дүгээр зүйлийн 24.4, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1, дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Усны хяналт-шинжилгээг тогтмол хийж усны нөөц, чанарт хяналт тавьж ажиллах, газрын доорх усны мониторингийн ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сард манай газарт хүргүүлэх, 2-ээс доошгүй мониторингийн цэгийг шинээр байгуулж, багаж тоног төхөөрөмж суурилуулж Улсын усны нэгдсэн сүлжээнд холбох;
- Зам талбай ногоон байгууламжийг мананцар үүсгэх, усыг хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлж усалгаанд хэрэглэхийг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна.

УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЖАВХЛАН

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 7 дугаар сарын 18 -ний өдөр

Дугаар Е-2405-000096

Улаанбаатар хот

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр:	Хур эрдэнэ баялаг
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	**5671833**
Захирал:	**Dong Xiangrui**
Холбоо барих дугаар:	**85956868**
Факс :	
И-мэйл хаяг :	

2.Төслийн нэр байршил

Төслийн нэр:	**Нүүрсний уурхай**
Байршил:	**Өмнөговь, Ноён**
Харьяалагдах сав газар:	-
Хамаарах салбар:	**Уул уурхай**

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Хур эрдэнэ баялаг

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
2	2 ээлжээр	360	250	24

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	10000.0	м2	2024 оны уулын ажлын төлөвлөгөө 30-р хуудас, усан хангамжийн хэсэгт 2024 онд 20 тонны цистернээр хоногт 1 удаа нийт 240 хоног тоосжилт дарахаар төлөвлөсөн. Зам талбайн тоосжилт дарах, нөхөн сэргээлт, мод ургуулахад шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.
Дүйцүүлэн хамгаалах нөхөн	22000.0	м2	2024 оны уулын ажлын төлөвлөгөөний 30-р хуудас, ус

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
сэргээлтэд ашиглах усны хэмжээ			хангамжийн хэсэгт жилд 20 удаа, маягт 10-т нийт 2.2 га талбайд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	470.0	хоногт 1 хүн	2024 оны уулын ажлын төлөвлөгөө маягт 12-т нийт 470 ажиллагсад, маягт 3-т 365 хоног ажиллахаар төлөвлөсан. Төслийн талбайд 2019, 2023 онд гаргуулсан 6 л/сек буюу 518.4 м3/хон нийлбэр үндаргатай 2 гүний худгаас хангана.
Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ	1206.5	м3	“Буурцагт алмаз” ХХК 2023 онд гүйцэтгэсэн “Баруун ноён уулын уурхайн талбайн гидрогеологийн нөхцөлийн талаарх товч дүгнэлт”-д “Баруун ноён уулын нүүрсний одоогийн уурхайн хэмжээнд хамгийн их орж ирэх нийт усны хэмжээ 1,206.5 м3/хон буюу 14.0 л/сек байна. Ил уурхайд орж ирэх агаарын хур тунадас, болзошгүй үерийн хэмжээ 199.7 м3/цаг гэж тогтоогдсон. Уурхай 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний маягт 3-т 365 хоног ажиллахаартөлөвлөсөн.
“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2024 онд мод ургуулахад ашиглах усны хэмжээ	20000.0	ш	2024 оны уулын ажлын төлөвлөгөө маягт 10-т Баяндалай суманд 10 га газарт 20,000 ширхэг мод тарьж, ургуулахаар төлөвлөсөн. Уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Унд ахуй	1.0	86.4	
Гүний худаг	Унд ахуй	5.0	432.0	Усны газрын 2023.12.20-ны өдрийн 01/1487 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд ""Хур эрдэнэ баялаг" ХХК-ийн хэрэгжүүлэх "Баруун Ноён уул" -ын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах унд ахуйн, хотхоны ногоон байгууламж, нөхөн сэргээлт, уурын зуухны усны хэрэгцээний 312.5 м3/хон усны хэрэглээг өөрийн эзэмшлийн 6.0 л/сек (518.4 м3/хон) нийлбэр үндаргатай 2 гүний худгаас, хөрсний овоолго, зам талбайн усалгааны 1,026 м3/хон усны хэрэгцээг уурхайн 1,209.6 м3/хон шүүрлийн уснаас хангахад ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна" гэсэн.
Шүүрлийн ус	Усны хэрэглээ	13.964	1206.4896	“Буурцагт алмаз” ХХК 2023 онд “Баруун ноён уулын нүүрсний одоогийн уурхайн хэмжээнд хамгийн их орж ирэх нийт усны хэмжээ 1,206.5 м3/хон буюу 14.0 л/сек гэж тодорхойлсон. Шүүрлийн усыг ногоон байгуулам, нөхөн сэргээлт, зам талбайн тоосжилт дарахад эргүүлэн ашиглана.

7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : **Гурван очил мандал ХХК**

Холбоо барих : **99700075**

Нэмэлт мэдээлэл:

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
Усан сан		Шүүрлийн усыг хуримтлуулах сангийн эзлэхүүн 1,000.0 м3. Ахуйн бохир усыг хуримтлуулах газар дор суурилуулсан 20 м3-ын багтаамжтай 2 ш, оффисын дэргэд 10 м3-ын багтаамжтай 1 ш төмөр ёмкосттой.

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
	Уурхайн зумфээс шүүрлийн усыг хуримтлуулах усан сан хүртэл	55	1200
	Хаягдал бохир усыг цуглуулах хоолой хүртэл	32	670

10. Онцгой нөхцөл

- **Уурхайн ухлага буюу ашиглалт явуулж буй талбай болон хаягдлын санд шар усны болон гэнэтийн үерийн ус орохоос хамгаалах суваг шуудуу эвдрэхээс сэргийлж ажиллах;**
- **Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу усны эх үүсвэрийн гүний худаг, эргэлтийн усны шугам хоолой, ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрд баталгаажуулсан цахим тоолуур суурилуулж ажиллахад анхаарах;**
- **Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох;**
- **Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх гэх мэт арга хэмжээ авч ажиллах;**

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	10000.0	м2	0.002	240.0	Хоног	4,800.00	4,800.00	0.00
Дүйцүүлэн хамгаалах нөхөн	22000.0	м2	0.004	20.0	Удаа	1,760.00	1,760.00	0.00

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
сэргээлтэд ашиглах усны хэмжээ								
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	470.0	хоногт 1 хүн	0.15	365.0	Хоног	25,732.50	0.00	25,732.50
Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ	1206.5	м3	1.0	365.0	Хоног	440,372.50	0.00	440,372.50
“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2024 онд мод ургуулахад ашиглах усны хэмжээ	20000.0	ш	0.05	20.0	Удаа	20,000.00	20,000.00	0.00
Нийт						**492,665.00**	**26,560.00**	**466,105.00**

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	0.00			0.00	0.00		0.00
Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	0.00			0.00	0.00		0.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	25732.50	Газрын доорх ус	0.0	99.74	2,566,623.88	0.0	2,566,623.88
Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ	440372.50	Газрын доорх ус	0.0	797.94	351,390,832.65	0.0	351,390,832.65
“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2024 онд мод ургуулахад ашиглах усны хэмжээ	0.00			0.00	0.00		0.00
Нийт	**466,105.00**				**353,957,456.53**		**353,957,456.53**

13. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- **Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Алтайн өвөр говийн сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулж ажиллах;**
- **Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ундны усны эх үүсвэрийн гүний худаг, шүүрлийн усны шугамд тоолуур суурилуулан баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.3.5-д заасны дагуу**

төсөвт төвлөрүүлэх;

- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.

Боловсруулсан:

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС	**Б.Мэндбаяр**
Боловсруулсан огноо:	**2024.07.18**

БАТЛАВ.

АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

Б. ПҮРЭВТУЛГА

БАТЛАВ.

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

DONG XIANGRUI

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 09 сарын 30-ны өдөр Дугаар 24/06 Даланзадгад хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 07 дугээр сарын 18-ны өдрийн Е-2405-000096 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Алтайн өвөр говийн сав газрын захиргааны 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн А/13 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж “АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА”-ны Газрын доорх усны нөөц, ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Диймаа,

Нөгөө талаас: Ус ашиглагчийг төлөөлж Өмнөговь аймаг, Ноён сум, Сайран баг, 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаар, 5671833 регистрийн дугаартай “ Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн Э.Түвшинбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний хүртэлх (нэг) жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ
- Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1 Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ-440,372.50 $м^3$/жил

2.2.2 Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ-25,732.50 м3/жил

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйн ашиглах уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр сав газрын захиргаанд ирүүлэх

Шинжилгээний аргын стандарт **MNS ISO 6222-1998**	Дээжийн хаяг байршил	Иттэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн
	Гал тогоо	Бактерийн ерөнхий тоо -9 Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо- илрээгүй *Salmonella spp* – Илрээгүй Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/ - Илрээгүй

		Гэдэсний бүлгийн эмгэт төрөгч нян- илрээгүй\ Clostridium perfringens- илрээгүй
	Хойд худаг	Бактерийн ерөнхий тоо -27 Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо- илрээгүй Salmonella spp – Илрээгүй Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/ - Илрээгүй Гэдэсний бүлгийн эмгэт төрөгч нян- илрээгүй\ Clostridium perfringens- илрээгүй

Унд ахуйн усны сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор ерөнхий шинжилгээ хийлгэх.

2.4. Усны эх үүсвэрийн байршил:

Худгийн нэр	Тоолуурын марк	Насосны марк	Ундарга л/сек	Координат
Уурхайн худаг-Цагаан дэрс	LXSG-25	DRON	1.0	102°24'51.6" 43°05'49.0"
Уурхайн худаг-Баруун иоён уул	LXSG-50	LXSG-32	7.5	102°22'51.8" 43°05'28.8"

2.5. Хаягдал усны хэмжээ: стандартынэ шаардлага: Хаягдал бохир усыг цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээ болон хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ MNS:6561:2015, MNS:4943:2015 стандартуудыг мөрдлөг болох

500м3/хоног хүчин чадалтай цогцолбор Топаэро МЕ техикийн үзүүлэлтэй

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодис, шинжилгээний дүн: Ахуйн хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутамд шинжилгээг Ус цаг уур орчны шинжилгээний төвөөр хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр сав газрын захиргаанд ирүүлэх.

- Жинлэгдэх бодис /кг/
- Органик бодис /кг/
- Эрдэс бодис /кг/
- Хүнд метал /кг/
- Аюултай бохирдуулах бодис /гр/

2.7. Цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин.

500м3/хоног хүчин чадалтай цогцолбор Топаэро МЕ техникийн үзүүлэлтэй

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдол, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

Д/д	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал (мян.төг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Уурхайн ундны усны хэрэгцээ тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах;	Уурхайн тосгон	538.38	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах.	Тогтмол

2	Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах	Уурхайн хэсэг	2659.8	Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ" - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага	2,3-р улирал
3	Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах;	Уурхайн нийт ажилчид	200		Хагас жил тутам Шинээр ажилд орж буй бүх ажилчид сургалтад хамрагдах
4	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самарт байрлуулж шинэчилж байх		100		Үйл ажиллагааны туршид
5	Уурхайн карерт шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор ашиглах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд			

- Дэлхийн усны өдөр болон байгаль хамгаалах өдрүүдийг захиргаатай хамтран зохион байгуулах
- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх
- Монгол улсны газрын доорх усны мониторингийн сүлжээний гэмтэлтэй цэгийг засварлах, хэв ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

2.9 Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм-ын дагуу тооцоход:

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ $м^3$ (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ $м^3$	Хөнгөлөх усны хэмжээ $м^3$	Төлбөр тооцох усны хэмжээ
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд	470.0	Хоногт 1 хүн	0.15	365.0	Хоног	25,732.00	0.00	25,732.50

ашиглах усны хэмжээ								
Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	10000.0	$м^3$	0.002	240.0	Хоног	4,800.00	4,800.00	0.00
Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	22000.0	$м^3$	0.004	20.0	удаа	1,760.00	1,760.00	0.00
Уурхайн ухлагад орж шүүрлийн усны хэмжээ	1206.5	$м^3$	1.0	365.0	Хоног	440,372.50	0.00	440,372.50
"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд 2024 онд мод ургуулахад ашиглах усны хэмжээ	20000.0	ш	0.05	20.0	удаа	20,000.00	20,000.00	0.00
Нийт						**492,665.00**	**26,560.00**	**466,105.00**

2.10 Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

"Усны экологи эдийн засгийн үнэлгээг батлах тухай" Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтоолоор Алтайн Өвөр говийн сав газарт тогтоосон усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326, 327-р тогтоолоор ашиглалтын зориулалтын итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож, тогтоосон хэмжээгээр Төсвийн тухай хуулийн 23.8.9-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

2.10.1. Ашиг олох зориулалтаар ахуй үйлдвэрлэл, үйлчилгээнд газар доорх усны нөөц ашигласны төлбөр

<u>1м3 газрын доорх усны үнэ:4,433.0 төг х 0.15 х 0.15=99.74 төг/м3</u>

- 4,433.0төг/м3 – Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Алтайн өвөр говийн сав газарт тогтоосон газрын доорх ус ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
- 15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 10-д заасан газрын доорх усыг ашиг олох зориулалтаар ашигласан усны нөөц ашигласны төлбөрийн хувь
- 0.15-Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Алтайн өвөр говийн сав газарт газрын доорх усны ашиг олох зориулалтаар ашигласны тооцох итгэлцүүр

25732.50м^3/жил х 99.74төг/м3=2,566,559.55 төг

2.10.2. Уурхайн ухлагад орж шүүрлийн усны төлбөр

1м^3 газрын доорх усны үнэ: 4,433.0 төг х 0.15 х 1.2 = 797.94 төг/м^3

- ***4,433.0 төг/м^3*** *– Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Алтайн өвөр говийн сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ;*
- ***15%*** *– Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7.в)-д заасан газрын доорх усыг шавхан зайлуулж усны нөөц ашигласны төлбөрийн хувь;*
- ***1.2*** *– Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолоор Алтайн өвөр говийн сав газарт газрын доорх усыг шавхан зайлуулах зориулалтаар ашигласныг тооцох итгэлцүүр;*

440372.50 м^3* 797.94 төг/м^3 = 351,390,832.65 төг

/Гурван зуун тавин нэгэн сая гурван зуун ерэн мянга найман зуун гучин хоёр төгрөг/

2.13. Дээрх усны нөөц ашигласан төлбөрийг Өмнөговь аймгийн төсөвт " Усны тухай" хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ба тоолуургүй ашигласан хугацаанд ногдуулах төлбөрийг дүгнэлтээр тооцно.

2.14. Усны нөөц ашигласны төлбөр, болон шавхан зайлуулах газрын доорх ус ашигласны төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор гүйцэт төлж барагдуулах;

2.15. Усны хяналтын тоолуурын ажиллагаа техникийн шалтгаанаар зогссон бол холбогдох хүмүүсийг байлцуулан зураг болон акт үйлдэн Сав газарт мэдэгдэх;

2.16. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө унд ахуйн болон бохир ус зайлуулах ажлыг стандартын дагуу хангаж ажиллах;

2.17. Шавхан зайлуулах газрын доорх ус ашигласны төлбөрийн хэмжээг тоолуурын заалтаар төлж барагдуулна. Тоолуур суурилуулаагүй болон ажиллаагүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлтэд заасны дагуу төлбөрийн хэмжээг төлж барагдуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 29.3, 30.1, 30.2, 31.1, 10.1.3-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөвт. Бусад

4.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно;

4.2 Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна;

4.3 Гэрээний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 30-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ;

4.4 Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ;

4.5 Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална.

4.5.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээнд үүргээ биелүүлээгүй тохиолдолд Ус ашиглуулагчийн шийдвэрээр;

4.5.2 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.3 Байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;

4.5.4 Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг төгтөөсөн хугацаанд нь төлөөгүй;

4.5.5 Усны эх үүсвэрийг бохирдуулсан;

4.5.6 Усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

4.5.7. Аль нэг тал татан буугдсан;

4.6 Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ;

4.7 Ус бохирдуулсны төлбөрийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1, 7.2 үндэслэн /Засгийн газрын тогтоол гарсанаар хүчин тоголдор болно/ барагдуулна;

4.8 Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхэд "Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943-2015" стандартад нийцүүлж Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар, Сав газрын захиргаанд ирүүлж байх;

4.9 Усны нөөц бохирдох, хомстохоос сэргийлэх арга хэмжээний хүрээнд олон нийтийг хамарсан сургалт семинар зохион байгуулах, баянбүрдийг сэргээх, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах, инженерийн хийцтэй худаг уст цэг гаргах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ манай байгууллагатай хамтран ажиллах, тайлан мэдээг 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор тус тус ирүүлж байх.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ, АШИГЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С. ДИЙМАА

Хаяг: Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Төрийн банкны байр, 4 давхар.

Харилцах утас: 70534080
Факс: 70534081

Ус ашиглагчийг төлөөлж:

"ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК-НИЙ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ ИНЖЕНЕР

Д.БУЯНЗУЛ

Хаяг: Өмнөговь аймаг, Ноён сум, Сайран баг, Цагаан дэрс

Харилцах утас: 99700075

АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 30 өдөр Дугаар А/13 Даланзадгад сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 17.1.10 дахь заалт, 30 дугаар зүйл, 7.5 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 07 дүгээр сарын 18-ны өдрийн Е-2405-000096 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ний Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт байрлах “Баруун ноён уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн талбайд 2024 оны агаарын чанарын орчны хяналт шинжилгээний хээрийн ажлыг 5 сарын 25-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Агаарын шинжилгээг Дундговь аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид сорилтын дүнг боловсруулсан. Хэмжилт, дээжлэлтийг төсөл хэрэгжүүлэгчээс өгсөн 8 цэгт хийж гүйцэтгэсэн. Мөн нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/ үзүүлэлтийг MNS 4585:2016 стандартын дагуу 24 цагийн хэмжилт хийх шаардлагатай байдаг тул BNU-AM-01ээс BNU-AM-08 гэсэн 8 цэгт хэмжилт хийсэн. 5-р сарын орчны хяналт шинжилгээний агаарын хэмжилтийн үед орчны байдал салхи 5- 10 м/сек, үүлэрхэг газрын гадарга 5-р сарын 25-ны өдөр хуурай, температур 18-21 градус, төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд шинжилгээ авах үед хөдөлгөөнтэй байсан.

Хүснэгт 1. Агаарын мониторингийн цэгүүдийн ерөнхий мэдээлэл

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Уртраг	Өргөрөг
1	BNU-AM-01	Пит-2-ын зүүн хойд тал	102˚24’28.58”	43˚05’19.72”
2	BNU-AM-02	Пит-1 отваллын зүүн тал, ШТС-ын хойно	102˚22’45.03”	43˚05’11.84”
3	BNU-AM-03	Пит-1 карьерын уланд	102˚22’11.72”	43˚05’46.53”
4	BNU-AM-04	Гаалийн талбайн зүүн урд, 1-р отваллын баруун урд технологийн замын хойд талд	102˚22’12.14”	43˚05’11.29”
5	BNU-AM-05	Пит-2-ын отваллын зүүн урд хормойд	102˚23’11.04”	43˚05’00.42”
6	BNU-AM-06	Кемп дотор	102˚24’41.33”	43˚05’08.55”
7	BNU-AM-07	Кемпийн зүүн тал орон нутгийн зам дагуу	102˚24’41.36”	43˚05’08.47”
8	BNU-AM-08	Нүүрс тээврийн зам дагуу	102˚16’53.040”	43˚05’33.37”

Зураг 4. Агаарын чанарын хэмжилт хийсэн мониторингийн цэгүүдийн байршил

2.3. Агаарын чанарын хэмжилт хийх үеийн төлөв байдал

BNU-AM-01, 102˚24’28.58”, 43˚05’19.72”

BNU-AM-02,102˚22’45.03”,43˚05’11.84”

BNU-AM-03,102˚22’11.72”,43˚05’46.53”



BNU-AM-04,102˚22’12.14”,43˚05’11.29”

BNU-AM-07,102˚24’41.36”,43˚05’08.47”

BNU-AM-08,101˚51’03.41”,43˚00’13.55”

Зураг 5. Агаар орчны хэмжилт хийж буй байдал

2.4. Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт

Хот суурин газрын агаарын чанарын хяналт шинжилгээнд ихэвчлэн түлшний шаталтаас үүдэлтэй зарим бохирдуулагч бодисуудыг сонгон тодорхойлдог. Эдгээрээс хамгийн түгээмэл илэрцтэй бохирдуулагч бодисууд нь тоос тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл юм.

Хүхэрлэг хий – Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан бүх төрлийн түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагааны дүнд үүсдэг. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Мөн хүчиллэг тунадас (H_2SO_4) үүсгэх зэргээр

хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг бүхий л салбарт сөргөөр нөлөөлдөг.

Азотын давхар исэл – Азотын давхар исэл нь азот агуулсан түлшний шаталт болон өндөр температурт шаталтын бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн шаталтын үеийн дулаан шингээх урвалын үр дүнд үүсдэг өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Тоосон (PM1.0, PM2.5, PM4.0, PM10, нийт тоос TSP) - Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамааraад маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрон хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг (Зураг 26).

Зураг 6. Агаар мандал дахь тоосонцруудын харьцангуй агууламж

Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос /PM10/-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрон диаметр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад

хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхэгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг (Зураг 27).



Зураг 7. Агаар дахь тоосонцорын ширхгийн хэмжээнээсээ хамааран хүний амьсгалын эрхтэнүүдээр шүүгдэж хуримтлагдах хэмжээ

Тоос үүсгэгч эгэл хэсгүүд нь аэродинамикийн хэмжээ, тунах (хүнд хүчний уналтын) хурд, агаар мандлын турбулент хөдөлгөөнөөс хамааран эх үүсвэрээс янз бүрийн зайд тархаж бохирдуулдаг.

2.5. Агаарын чанарын хэмжилт, судалгааны үр дүн

Судалгааны талбайн агаар дахь бохирдуулагч бодисуудын нэг удаагийн буюу 20 минутын дундаж хэмжилтийн үр дүнгээс үзэхэд нийт тоос, хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016” -д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна (Лабораторийн шинжилгээний үр дүнг хавсаргав).

Хүснэгт 2. Агаарын чанарын шинжилгээний дүн

№	Хэмжилт хийсэн цэгүүд	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий /SO_2/	Азотын давхар исэл /NO_2/	Нийт тоос/TSP/
			мг/м^3		
1	BNU-AM-01	2024 оны 5 дугаар сарын 25-26	0.015	0.041	0.014
2	BNU-AM-02		0.012	0.021	0.020
3	BNU-AM-03		0.018	0.024	0.028
4	BNU-AM-04		0.017	0.038	0.034
5	BNU-AM-05		0.015	0.044	0.027
6	BNU-AM-06		0.062	0.035	0.005
7	BNU-AM-07		0.042	0.050	0.012
8	BNU-AM-08		0.064	0.047	0.009

MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ /20 минутын дундаж хэмжилт/	**0.450**	**0.200**	**0.500**



График 1. Агаар дахь Хүхэрлэг хийн /SO_2/ хэмжээ



График 2. Агаар дахь Азотын давхар исэлийн /NO2/хэмжээ

Төслийн талбайд хэмжсэн агаар дахь тоосны хэмжилтийн үр дүнгээс харахад нийт тоосны хэмжээ 5-р сард 0.012-0.034 мг/м^3-ийн хооронд буюу “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандартаас бага байна (График 2.1).

Хүснэгт 3. Агаарын чанарын шинжилгээний дүн, тоос

№	МЦ	Нийт тоос	MNS 4585:2016	Pm 10	MNS 4585:2016	Pm 2.5	MNS 4585:2016
		5-р сар		5-р сар		5-р сар	
1	BNU-AM-01	0.014	0.5	0.014	0.1	0.013	0.5
2	BNU-AM-02	0.020	0.5	0.019	0.1	0.018	0.5
3	BNU-AM-03	0.028	0.5	0.027	0.1	0.013	0.5
4	BNU-AM-04	0.034	0.5	0.032	0.1	0.022	0.5
5	BNU-AM-05	0.027	0.5	0.016	0.1	0.009	0.5

6	BNU-AM-06	0.005	0.5	0.005	0.1	0.002	0.5
7	BNU-AM-07	0.012	0.5	0.007	0.1	0.002	0.5
8	BNU-AM-08	0.009	0.5	0.005	0.1	0.002	0.5



График 3. Агаарын чанарын шинжилгээ, тоос

2.6. Орчны дуу шуугиан

Орчны дуу шуугианы хэмжилтийг мониторингийн цэгт 20 минутын хугацаатай хийсэн бөгөөд хэмжилтийн үеийн утга 33-55 дБа байна. Энэ нь Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын Өдрийн цаг (07-22 цаг) дуу шуугианы стандарт 60 дБа-аас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 4. Дуу шуугианы үзүүлэлт

№	МЦ	Дуу чимээ, дБА	MNS 4585:2016
1	BNU-AM-01	41	60
2	BNU-AM-02	52	
3	BNU-AM-03	35	
4	BNU-AM-04	55	
5	BNU-AM-05	33	
6	BNU-AM-06	45	
7	BNU-AM-07	40	
8	BNU-AM-08	45	

ГУРАВ. УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

3.1. Судалгааны талбайн усан орчны ерөнхий мэдээлэл

Төслийн талбай нь Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Алтайн өвөр говийн сав газрын түр урсгал бүхий гол горхитой мужид хамаарах ба хойноос өмнө чиглэлд сунаж тогтсон, нүцгэн эгц хажуу, хадархаг тогтоц, уулсын хөндий элбэгтэй бөгөөд хуурай сайр, судаг, жалгууд олноор үүсэж бий болсон байна. Тус сав газар нь ус зүйн сүлжээний нягтшил маш сул хөгжсөн, урсацын модуль 1 л/с км2–аас, урсацын давхраа 25 мм–ээс тус тус бага жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Уг лицензийн талбайд байнгын урсгалтай гол горхи байхгүй, Сухайн худаг, Таван овооны булаг (худаг), Жаргалантын худаг (булаг) зэрэг уст цэгүүд байх боловч тухайн жилийн улирлын цаг уурын нөхцөл, хур тунадсаас хамаарч ширгэх, хатах, шургах зэргээр зөвхөн, хужир мараа үүсгэдэг.



Зураг 8. Усны сав газрын ангилал

3.2. Судалгааны арга зүй

3.2.1. Хээрийн судалгааны арга зүй

“Баруун ноён уулын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 усан орчны мониторингийн хээрийн судалгааны ажлыг 2024 оны 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгааны үед усны дээж авах, тээвэрлэхдээ “Унд ахуйн хэрэгцээний, үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний дээж авах аргачлал” MNS 3934 : 1986, Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж” MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу 1.5 л багтаамжтай цэвэр усны саванд авсан. Дээж авахдаа дээжийн савыг дээж авч

буй эх үүсвэрийн усаар 2 удаа зайлж, савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хүчил төрөгчтэй тухайн дээж харилцан үйлчлэлд орохыг хязгаарлана. Дээжийг харанхуй, сэрүүн нөхцөлд хүйтэн баригч саванд хадгалж тээвэрлэсэн болно.

3.2.2 Лабораторийн задлан шинжилгээний арга зүй

Гүний усны ерөнхий химийн шинжилгээ (аниан, катион, Ph, TDS, ES, физик үзүүлэлтүүд зэрэг)-ийг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний магадлан итгэмжлэгдсэн лабораторид, хүнд элементийн шинжилгээг “Эс Жи Эс” ХХК-ийн олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораторид 57 үзүүлэлтээр шинжилгээний холбогдох аргачлал, стандартын дагуу тус тус шинжлүүлсэн.

3.2.3 Үр дүнгийн боловсруулалтын арга зүй

Газрын доорх усны мониторингийн ажлын боловсруулалтыг хийхдээ унд ахуйн хэрэглээний усны шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай, газрын тосны олборлолт, үйлдвэрлэлд ашиглаж буй усны шинжилгээний үр дүнг Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандарт дүнтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгсөн.

Усны мониторингийн цэгүүдийн байршлын зургийг хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.8 программ дээр Sentinel хиймэл дагуулын 7 сарын мэдээг ашиглан хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А3 болон А4 хуудсан дээр шугаман масштабтайгаар бэлдсэн.

Хүснэгт 5. Усан орчны мониторингийн цэгүүдийн ерөнхий мэдээлэл

№	МЦ-ийн дугаар	МЦ-ийн мэдээлэл	Шинжилгээ хийсэн үзүүлэлт	МЦ-ийн солбилцол		Газар доорх усны түвшин
				Y	X	м
1	NSOW1	Малчны худаг-1	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°26'28.06" E	43° 3'35.33"N	3.24
2	NSOW2	Малчны худаг-2	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°23'59.74" E	43° 2'43.62"N	2.25
3	BNUPW1	Уурхайн худаг-1	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°24'24.52" E	43° 5'19.23"N	
4	BNUPW2	Уурхайн худаг-2	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°24'32.23" E	43° 5'29.21"N	

5	Монгол гал тогоо	Монгол гал тогоо	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°24'27.57" E	43° 5'26.39"N	
6	Хятад гал тогоо	Хятад гал тогоо	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°24'29.87" E	43° 5'28.67"N	
7	Ноён сум Гүний худаг	Худаг	Ерөнхий хими, физик үзүүлэлт	102°7.37.91" E	43° 5'8.56.23"N	
8	Монгол гал тогоо	Монгол гал тогоо	Бактерлиоги	102°24'27.57" E	43° 5'26.39"N	-
9	Хятад гал тогоо	Хятад гал тогоо	Бактерлиоги	102°24'29.87" E	43° 5'28.67"N	-
10	ТР-1	Цэвэршүүлэхээс өмнөх ус	Бактерлиоги	102°24'27.74" E	43° 5'25.33"N	-
11	Шүүрлийн ус	Шүүрлийн ус	Хүнд элемент	102°22'13.80" E	43° 5'46.10"N	-

Товчилсон үгийн тайлбар: МЦ - мониторингийн цэг

3.3. Усан орчны мониторинг хийх үеийн эх үүсвэрүүдийн төлөв байдал

Усны мониторингийн цэг (Уурхайн худаг 1): Дээж авах үед үйл ажиллагаа хэвийн, усны өнгө тунгалаг, үнэргүй байсан. Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 9. Хэрэглээний усны дээж-Уурхайн худаг-1

Усны мониторингийн цэг (Уурхайн худаг 2): Дээж авах үед үйл ажиллагаа хэвийн, усны өнгө тунгалаг, үнэргүй байсан. Энэхүү ус нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфат-гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 10. Хэрэглээний усны дээж-Уурхайн худаг-2

Усны мониторингийн цэг (Монгол гал тогоо): Дээж авах үед үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан. Химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 11. Крантны усны дээж-Монгол гал тогоо

Усны мониторингийн цэг (Хятад гал тогоо): Дээж авах үед үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан. Энэхүү ус нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 12. Крантны усны дээж-Хятад гал тогоо

Усны мониторингийн цэг (Малчны худаг 1): Дээж авах үед усны өнгө тунгалаг үнэргүй байсан. Химийн бүрэлдэхүүнээрээ сульфат-гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус

байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 13 Малчны гар худаг-1

Усны мониторингийн цэг (Малчны худаг 2): Дээж авах үед үйл ажиллагаа хэвийн, усны өнгө тунгалаг, үнэргүй байсан. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэтүүд нь ‘’Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Зураг 14 Малчны гар худаг

Усан орчны ерөнхий химийн үзүүлэлтүүд

Усны ерөнхий шинжилгээний дүнг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандарттай MNS 0900:2018 харьцуулав. Ундны усны байгалийн гаралтай химийн найрлагын үзүүлэлтийг хүснэгт 2 болон графикаас харахад стандартаас даваагүй буюу чанарын шаардлага хангаж байна.



График 4. Cl⁻ Хлорын агууламж



График 5. SO₄⁻⁻ Сульфатын агууламж



График 6. NO₂⁻ Нитритын агууламж



График 7. NO ₃ Нитратын агууламж



График 8. Ca ф Кальцийн агууламж



График 9. Mg ф Магнийн агууламж



График 10. NH₄ Аммонийн агууламж



График 11. Fe Төмрийн агууламж

Хүснэгт 6. 2024 оны усны ерөнхий хими-физикийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Нэгж	Стандарт	Малчны худаг-1	Малчны худаг-2	Уурхайн худаг-1	Уурхайн худаг-2	Монгол гал тогоо	Хятад гал тогоо	Ноё сум Гүний худаг
Физик үзүүлэлтүүд									
Тунгалаг	см	-	30	28	30	30	30	30	30
Өнгө	-*-	20	Үгүй	Цайвар шаргал	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Үнэр			Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Тунадас	-	-	Үгүй	Бага зэрэг бор	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Булингаршил	NTU	5	2.48	4.56	2.46	3.23	2.48	3.23	1.28
Усны орчин, pH	-*-	6.5-8.5	8.1	7.5	7.7	7.8	8.1	7.8	7.9
EC	мСм/см	1	980	771	956	945	980	964	965
Химийн үзүүлэлт									
Cl ⁻Хлорын агууламж	мг/л	350	94.4	41.2	95.9	84.1	94.4	87	88.8
SO_4^{2-}Сульфатын агууламж	мг/л	500	180	98	180	170	180	195	190
NO_2^-Нитритын агууламж	мг/л	1	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0
NO_3^-Нитратын агууламж	мг/л	50	18	8	18	25	18	0.9	20
CO_3^{2-}	мг/л	-	12	0	0	0	12	0	0
HCO_3^-	мг/л	-	158.6	311.1	176.9	207.4	156.8	183	170.8
Na^++K^+	мг/л	-	183.1	102.6	182.4	153.9	183.1	153.7	164
Ca^{2+}Кальцийн агууламж	мг/л	100	32.1	58.7	31.7	49.7	32.1	46.7	42.1
Mg^{2+}Магнийн агууламж	мг/л	30	1.6	12.4	1.6	6.6	1.6	6.1	4.3
NH_4^+Аммонийн агууламж	мг/л	1.5	0.2	0.3	0	0.1	0.2	0.2	0

Fe ф ф	мг/л	0.3	0	0	0	0	0	0	0
Fe ф ф Гөмрийн агууламж	мг/л	0.3	0	0.05	0.05	0	0	0.05	0
TDS	мг/л	-	588	466	573.5	567	588	578	579
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7							

3.4. Усан орчны хүнд элементийн үзүүлэлт

Усны мониторингийн цэг (Уурхайн шүүрлийн ус): Уурхайн шүүрлийн усны хүнд элементийн шинжилгээний үр дүн Хүснэгт 3-аас харахад стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Зураг 15. Уурхайн шүүрдийн усны дээж

Хүснэгт 7. 2024 оны усны хүнд элементийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	MNS 6148:2010	Нэгж	Уурхайн шүүрлийн ус
Мөнгө, Ag	0.1	мкг/л	<0.1
Хөнгөн цагаан, Al	-	мкг/л	0.028
Хүнцэл, As	0.01	мкг/л	<0.01
Бор, B	-	мкг/л	0.19
Ba, Бари	2	мкг/л	<0.01
Берилли, Be	0.001	мкг/л	<0.001
Висмут, Bi	-	мкг/л	<0.01
Кадьми, Cd	0.003	мкг/л	<0.001
Кобальт, Co	-	мкг/л	0.001
Хром, Cr	0.005	мкг/л	<0.005
Зэс, Cu	1	мкг/л	<0.02
Төмөр, Fe	0.3	мкг/л	0.08
Марганец, Mn	0.01	мкг/л	<0.01
Молибден, Mo	0.04	мкг/л	0.005
Никель, Ni	0.1	мкг/л	<0.005
Фосфор,P	-	мкг/л	<0.05
Хар тугалга, Pb	0.05	мкг/л	<0.01
Сурьма, Sb	0,006	мкг/л	<0.01
Селени, Se	0.04	мкг/л	<0.01
Стронций, Sr	-	мкг/л	0.3
Тори, Th	-	мкг/л	<0.005
Титан, Ti	-	мкг/л	<0.005
Уран, U	0.2	мкг/л	<0.10
Ванади, V	0.06	мкг/л	<0.01
Цайр, Zn	5	мкг/л	<0.01

Зураг 16. Уурхай орчмын шүүрлийн ус

3.5. Ундны усны бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлт

Нийт 3 цэгээс ундны усны бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлтийн дээж авсан. Үүнд: Монгол нийтийн гал тогооны хэрэглээний усны крантнаас, Хятад гал тогооны хэрэглээний усны крантнаас болон ус цэвэрлэх байгууламжийн бохир уснаас тус тус авсан болно. Шинжилгээний үр дүн Хүснэгт харахад зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу гэдэсний бүлгийн нян илрээгүй байна.

Зураг 17 Монгол гал тогоо-Бактериологийн дээж

Зураг 18. Хятад гал тогоо- Бактериологийн дээж

Хүснэгт 8. Ундны усны бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлтийн үр дүн

Үзүүлэлт	Стандарт	Зөвшөөрөгдөх хэмжээ	Монгол гал тогоо	Хятад гал тогоо	Цэвэрлэх байгууламж ус
Бактерийн ерөнхий тоо	MNS ISO 6222:1998	100	Илрээгүй	Илрээгүй	-
Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	Илрэхгүй 100мл-д	Илрээгүй	Илрээгүй	-
Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	Илрэхгүй 100мл-д	Илрээгүй	Илрээгүй	-

Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS ISO 19250:2017	Илрэхгүй 25мл-д	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
Clostridium perfringens	MNS ISO 6461-2:1998	Илрэхгүй 100мл-д	Илрээгүй	Илрээгүй	-

3.6 Шинжилгээний үр дүнгийн харьцуулалт

Газрын доорх усанд агуулагдах ерөнхий химийн агууламжийг харьцуулахад Cl ϖ Хлорын агууламж, Ca ϕ ϕ Кальцийн агууламж, Mg ϕ ϕ Магнийн агууламж, NH ϒ ϕ Аммонийн агууламж гэсэн 4 элементийг **2023.08.21, 2024.01.15** саруудад шинжилсэн байсан тул эдгээр элементүүдийг харьцуулах боломжтой байна. Өмнө хийгдсэн лабораторын шинжилгээний үр дүнгээс харахад газрын доорх усны ерөнхий химийн лабораторын шинжилгээ **2023.08.21, 2024.01.15** болон сүүлд хийгдсэн **2024.06.07** саруудын лабораторын шинжилгээтэй төдийлөн уялдахгүй байгаагаас гадна сүүлийн сарын шинжилгээг илүү сайжруулан маш олон төрлийн ерөнхий химийн эдементийн найрлагыг гаргаснаар давуу тал болсон. Улмаар цаашид ямар төрлийн ерөнхий химийн элементүүдийг төвлөрч судлах зэрэг нь харагдаж байгаа юм.

Өмнө хийгдсэн болон сүүлд хийгдсэн ерөнхий химийн шинжилгээний хариуг Хүснэгт 9-д, мөн дараах графикуудад дээж авсан цэг тус бүрээр дэлгэрэнгүй үзүүллээ.

Хүснэгт 9. Ерөнхий химийн элементүүдийн агууламж (2023.08.21, 2024.01.15, 2024.06.07)

Физик болон химийн үзүүлэлтүүд			Монгол гал тогоо			Хятад гал тогоо			Оффисын угаалтуурын ус			Нийтийн ариун цэврийн өрөө			NSOW1	NSOW2	BNUPW1	BNUPW2
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07	2023.08.21	2024.01.15	2024.06.07	2023.08.21	2024.01.15	2024.06.07	2023.08.21	2024.01.15	2024.06.07	2024.06.07	2024.06.07	2024.06.07	2024.06.07
Тунгалаг	см	-	-	-	30		-	30	-	-	Шинжилгээ хийгдээгүй	-	-	Шинжилгээ хийгдээгүй	30	28	30	30
Өнгө	-*-	20	-	-	Үгүй		-	Үгүй	-	-		-	-		Үгүй	Цайвар шаргал	Үгүй	Үгүй
Үнэр			-	-	Үгүй		-	Үгүй	-	-		-	-		Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Тунадас	-	-	-	-	Үгүй		-	Үгүй	-	-		-	-		Үгүй	Багазэрэг бор	Үгүй	Үгүй
Булингаршил	NTU	5	-	-	2.48		-	3.23	-	-		-	-		2.48	4.56	2.46	3.23
Усны орчин, pH	-*-	6.5-8.5	6.87	7.54	8.1	7.19	7.46	7.8	6.81	7.49		6.97	7.43		8.1	7.5	7.7	7.8
EC	мСм/см	1	0.71	0.653	980	1184	0,683	964	0.71	0.674		0.713	0.616		980	771	956	945
Cl₪ Хлорын агууламж	мг/л	350	88.61	94.74	94.4	74.43	77.979	87	102.79	88.61		116.9	88.61		94.4	41.2	95.9	84.1

SO Ч ш Сульфатын агуулам ж	мг/л	500	-	-	180		-	195	-	-		-	-		180	98	180	170
NO Fнь итритын агуулам ж	мг/л	1	-	-	0.03	0.1	-	0.03	-	-		-	-		0.03	0.03	0.03	0.03
NO ғ ш Нитратын агуулам ж	мг/л	50	0.2		18			0.9	0.1			0.3			18	8	18	25
CO ғ ш	мг/л	-	-	-	12		-	0	-	-		-	-		12	0	0	0
HCO ғ ц	мг/л	-	-	-	156.8		-	183	-	-		-	-		158.6	311.1	176.9	207.4
Na ф+K ф	мг/л	-	-	-	183.1		-	153.7	-	-		-	-		183.1	102.6	182.4	153.9
Ca ф ф Кальцийн агуулам ж	мг/л	100	30.06	20.04	32.1	20.04	32.064	46.7	20.04	25.05		61.112	15.03		32.1	58.7	31.7	49.7
Mg ф ф Магний	мг/л	30	6.08	-	1.6	3.04	-	6.1	3.04	-		12.768	-		1.6	12.4	1.6	6.6

агуулам ж																	
NH ϟ ϕ Аммонийн агуулам ж	мг/л	1.5	0.15	0.09	0.2	0.12	0.09	0.2	0.2	0.1		0.3	0.08		0.2	0.3	0	0.1
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	0		-	0	-	-		-	-		0	0	0	0
Fe ϕ ϕ Төмрийн агуулам ж	мг/л	0.3	-	-	0		-	0.05	-	-		-	-		0	0.05	0.05	0
TDS	мг/л	-	-	-	588		-	578	-	-		-	-		588	466	573.5	567
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	1	1.75	-	1.25	2	-	1.25	1.75		4.1	1.5		-	-	-	-

Усны мониторингийн цэг (Монгол гал тогоо):

Хүснэгт 10. 2023.08.21, 2024.01.15, 2024.06.07 саруудын шинжилгээний үр дүнгийн харьцуулалт.

Физик болон химийн үзүүлэлтүүд			144 Нийтийн хоолны гал тогоо		
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07
Тунгалаг	см	-	-	-	30
Өнгө	-*-	20	-	-	Үгүй
Үнэр			-	-	Үгүй
Тунадас	-	-	-	-	Үгүй
Булингаршил	NTU	5	-	-	2.48
Усны орчин, pH	-*-	6.5-8.5	6.87	7.54	8.1
EC	мСм/см	1	0.71	0.653	980
Cl ϖ Хлорын агууламж	мг/л	350	88.61	94.74	94.4
SO Ҳ ϖ Сульфатын агууламж	мг/л	500	-	-	180
NO F Нитритын агууламж	мг/л	1	-	-	0.03
NO ϝ Нитратын агууламж	мг/л	50	0.2		18
CO ϝ ϖ ϖ	мг/л	-	-	-	12
HCO ϝ ϖ	мг/л	-	-	-	156.8
Na ϕ K ϕ	мг/л	-	-	-	183.1
Ca ϕ Кальцийн агууламж	мг/л	100	30.06	20.04	32.1
Mg ϕ Магнийн агууламж	мг/л	30	6.08	-	1.6
NH Ҳ Аммонийн агууламж	мг/л	1.5	0.15	0.09	0.2
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	0
Fe ϕ ϕ Гөмрийн агууламж	мг/л	0.3	-	-	0
TDS	мг/л	-	-	-	588
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	1	1.75	-



График 12. Cl⁻ Хлорын агууламж



График 13. Mg++ Магнийн агууламж



График 14. Ca++ Кальцийн агууламж



График 15. NH₄ Аммонийн агууламж

Усны мониторингийн цэг (Хятад гал тогоо):

Хүснэгт 11. 2023.08.21, 2024.01.15, 2024.06.07 саруудын шинжилгээний үр дүнгийн харьцуулалт

Физик болон химийн үзүүлэлтүүд			143 Оффисын гал тогооны ус		
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07
Тунгалаг	см	-		-	30
Өнгө	-*-	20		-	Үгүй
Үнэр				-	Үгүй
Тунадас	-	-		-	Үгүй
Булингаршил	NTU	5		-	3.23
Усны орчин, pH	-*-	6.5-8.5	7.19	7.46	7.8
EC	мСм/см	1	1184	0,683	964
Cl Хлорын агууламж	мг/л	350	74.43	77.979	87
SO Сульфатын агууламж	мг/л	500		-	195
NO Нитритын агууламж	мг/л	1	0.1	-	0.03
NO Нитратын агууламж	мг/л	50			0.9
CO	мг/л	-		-	0
HCO	мг/л	-		-	183
Na+K	мг/л	-		-	153.7
Ca Кальцийн агууламж	мг/л	100	20.04	32.064	46.7
Mg Магнийн агууламж	мг/л	30	3.04	-	6.1
NH Аммонийн агууламж	мг/л	1.5	0.12	0.09	0.2

Fe ф ф	мг/л	0.3		-	0
Fe ф ф Гөмрийн агууламж	мг/л	0.3		-	0.05
TDS	мг/л	-		-	578
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	1.25	2	-



График 16. Cl ф Хлорын агууламж



График 17. Mg ф Магнийн агууламж



График 18. Ca ф Кальцийн агууламж



График 19. NH Ч Аммонийн агууламж

Усны мониторингийн цэг (Оффисын угаалтуурын ус, Нийтийн өрөө) **Хүснэгт 12. 2023.08.21, 2024.01.15, 2024.06.07 саруудын шинжилгээний үр дүнгийн харьцуулалт**

Физик болон химийн үзүүлэлтүүд			142 Оффисын угаалтуурын ус		
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07
Тунгалаг	см	-	-	-	Шинжилгээ
Өнгө	-*-	20	-	-	
Үнэр			-	-	
Тунадас	-	-	-	-	

Физик болон химийн үзүүлэлтүүд			145 Нийтийн ариун цэврийн өрөө		
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07
Тунгалаг	см	-	-	-	Шинжилгээ
Өнгө	-*-	20	-	-	
Үнэр			-	-	
Тунадас	-	-	-	-	

Булингар шил	NTU	5	-	-	хий гдэ эгүй
Усны орчин, pH	-*-	6.5 - 8.5	6.81	7.49	
EC	мСм/см	1	0.71	0.674	
Cl ϖ Хлорын агууламж	мг/л	350	102.79	88.61	
SO ϰ ϖ ϖ Сульфатын агууламж	мг/л	500	-	-	
NO Fнϖ Нитритын агууламж	мг/л	1	-	-	
NO ϝ ϖ Нитратын агууламж	мг/л	50	0.1		
CO ϝ ϖ ϖ	мг/л	-	-	-	
HCO ϝ ϖ	мг/л	-	-	-	
Na ϕ+K ϕ	мг/л	-	-	-	
Ca ϕ ϕ Кальцийн агууламж	мг/л	100	20.04	25.05	
Mg ϕ ϕ Магнийн агууламж	мг/л	30	3.04	-	
NH ϰ ϕ Аммонийн агууламж	мг/л	1.5	0.2	0.1	
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	
Fe ϕ ϕ ϕ Төмрийн агууламж	мг/л	0.3	-	-	
TDS	мг/л	-	-	-	

Булингар шил	NTU	5	-	-	хий гдэ эгүй
Усны орчин, pH	-*-	6.5 - 8.5	6.97	7.43	
EC	мСм/см	1	0.713	0.616	
Cl ϖ Хлорын агууламж	мг/л	350	116.9	88.61	
SO ϰ ϖ ϖ Сульфатын агууламж	мг/л	500	-	-	
NO Fнϖ Нитритын агууламж	мг/л	1	-	-	
NO ϝ ϖ Нитратын агууламж	мг/л	50	0.3		
CO ϝ ϖ ϖ	мг/л	-	-	-	
HCO ϝ ϖ	мг/л	-	-	-	
Na ϕ+K ϕ	мг/л	-	-	-	
Ca ϕ ϕ Кальцийн агууламж	мг/л	100	61.112	15.03	
Mg ϕ ϕ Магнийн агууламж	мг/л	30	12.768	-	
NH ϰ ϕ Аммонийн агууламж	мг/л	1.5	0.3	0.08	
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	
Fe ϕ ϕ ϕ Төмрийн агууламж	мг/л	0.3	-	-	
TDS	мг/л	-	-	-	

Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	1.25	1.75		Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	4.1	1.5	

ДӨРӨВ. ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

4.1. Хөрсний хээрийн судалгаа, судалгааны арга зүй

“Баруун ноён уул” уурхайн 2024 оны эхний хагас жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2024 оны 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Энэхүү талбайд хөрсний мониторинг хийдэг нийт 7-н цэгээс өнгөн хөрсний буюу 0-10 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдлын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан.

4.1.1. Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжүүдэд агро-хими, физик шинж, хүнд металл зэрэг 20 орчим үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг “Green lab” Хөрс судлалын лабораторид тодорхойллоо. Үүнд:

- Органик нүүрс
- төрөгчийн агуулга - Шатаалтын алдагдал
- Ялзмаг - Тюриний
- Урвалын орчин (pH) - Потенциометрийн
- $CaCO_3$ карбонат - Кальциметрийн
- Механик бүрэлдэхүүн - Гидрометрийн
- Давсжилт, EC - Потенциометрийн
- Фосфор - Спектро фотометр
- Кали - Дөлт фотометр

Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991” стандартуудыг мөрдлөг болгосон.

Хүнд металл. Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг магадлан итгэмжлэгдсэн SGS олон улсын лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.

4.2. Судалгааны үр дүн

4.2.1. Хөрсний гадаргын өнөөгийн төлөв байдал

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-1: Энэ цэг нь шинэ карьерын хойно байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй цэвэр байна.

Зураг 19. BNU-SM-1 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-2: Энэ цэг нь үндсэн овоолгын зүүн урд байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй цэвэр байна.

Зураг 20. BNU-SM-2 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-3: Энэ цэг нь гаалийн хяналтын талбайн урд замын дэргэд байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг нягтавтар, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй, нүүрсний тоосонцрын нимгэн хучаастай байна.

Зураг 21 BNU-SM-3 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-4: Энэ цэг нь шимт хөрсний овоолгын урд захад байрлах бөгөөд хөрсний гадарга нь өнгөр тогтож бэхэжсэн, хөрсний өнгөн хэсэг сийрэг, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна.

Зураг 22. BNU-SM-4 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-5: Энэ цэг нь кемпийн цэвэрлэх байгууламж орчимд байрлах бөгөөд хөрсний гадарга нь хүчтэй талхадсан, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна.

Зураг 23. BNU-SM-5 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-6: Энэ цэг нь хог хаягдал түр хадгалах цэгийн дэргэд байрлах бөгөөд хөрсний өнгөн хэсэг нь хүний хөлийн болон техникийн нөлөөгөөр нэлээд талхадсан, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдол бага байна.

Зураг 24. BNU-SM-6 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-7 (Контрол цэг): Энэ цэг нь кемпийн талбайгаас зүүн хойшоо 750м орчим зайд байрлах бөгөөд ямар нэгэн нөлөөлөл байхгүй ердийн хөрсөн бүрхэвчтэй, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, ургамал бүрхэвч сайтай, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна..

Зураг 25. BNU-SM-7 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

4.2.2. Хөрсний агро-хими, физик шинж чанар

Хөрсний урвалын орчин (pH)

Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад нэн тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) харахад pH-ийн утгын хэлбэлзэл 8.5-9.1 хооронд буюу хүчтэй шүлтлэг орчинтой байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 20. Хөрсний мониторинг цэгүүд дэх pH-ийн утга

Хүснэгт 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх агро-химийн үзүүлэлтүүд

Цэг	Гүн, см	pH	Карбонат, %	Ялзмаг, %	EC, dS/m	Хөдөлгөөнт	
						Фосфор, мг/100гр	Кали, мг/100 гр
BNU-SM-1	0-10	9.14	1.65	0.95	0.06	1.50	22.0
BNU-SM-2	0-10	9.00	1.65	0.92	0.07	2.30	30.0
BNU-SM-3	0-10	8.96	1.65	1.17	0.06	1.20	13.0
BNU-SM-4	0-10	9.07	1.81	0.90	0.06	1.90	22.0
BNU-SM-5	0-10	8.48	1.65	0.90	0.27	2.10	19.0
BNU-SM-6	0-10	8.81	1.32	0.90	0.13	1.50	6.0

BNU-SM-7	0-10	8.97	1.15	0.76	0.06	0.80	13.0

Хөрсний карбонатжилт

Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO_3)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) харахад карбонатын агууламж 1.1-1.6%-ийн хооронд буюу сул карбонатжсан байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 21. Хөрсний мониторинг цэгүүд дэх карбонатын агууламж

Хөрсний ялзмагийн агууламж

Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Энэ бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарах учраас

хүний нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсөн бүрхэвч дунджаар 1.0% ялзмагтай байдаг (суурь судалгаа). Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) харахад ялзмагийн утгын хэлбэлзэл 0.76%-1.17%-ийн хооронд буюу маш бага агууламжтай байна. Нүүрсний тоосжилт ихтэй BNU-SM-3 цэгт бага зэрэг механик бохирдол үүссэн байна. Мөн энэ жилийн дундаж нь өмнөх жилүүдийн дунджаас бага зэрэг өссөн байгаа нь уурхай орчимд нүүрсний тоосноос шалтгаалсан органик бохирдол нэмэгдэж байгааг илтгэж байна.



График 22. Хөрсний мониторинг цэгүүд дэх ялзмагийн агууламж

Хөрсний цахилгаан дамжуулалт (EC) буюу хялбар уусах давсжилт

EC буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд EC нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний EC-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсний EC нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) $EC_{1:2.5}$-ийн утгын хэлбэлзэл 0.09-0.27 dS/m хооронд буюу маш сул давсархаг байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 23. Хөрсний мониторинг цэгүүд дэх EC-ийн түвшин

Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P_2O_5, K_2O)

Хөрсний фосфор, кали (P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Фосфор нь мөн ургамлын үндэсний өсөлтийг дэмжиж, цэцэглэж ургахад чухал нөлөөтэй байдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P_2O_5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидыг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K_2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K_2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) ха рахад P_2O_5-ын утгын хэлбэлзэл 0.8-2.3 мг/100г -ийн хооронд буюу хөдөлгөөнт фосфор бага байгаа нь харагдаж байна. Хөдөлгөөнт калийн хувьд утгын хэлбэлзэл нь 6-30 мг/100г -ийн хооронд буюу багаас сайн хангамжтай байна (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**). Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 24. Хөрсний мониторинг цэгүүд дэх P_2O_5-ын хангамж



График 25. Хөрсний мониторинг цэгүүд дэх K_2O-ийн хангамж

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаврынх <0.002мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэд маш нөлөөтэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) харахад хөрсөн дэх элсэн фракцын утгын хэлбэлзэл 78-85%, шавар 5-12%-ийн хооронд буюу том ширхэгтэй элсэн фракц давамгайлсан элсэнцэр болон нарийн элсэн хөрстэй байна.



График 26 Хөрсний мониторинг цэгүүд дэх механик бүрэлдэхүүн

Хүснэгт 14. Хөрсний мониторинг цэгүүд дэх механик бүрэлдэхүүн

Цэг	Гүн, см	Элс, %	Тоос, %	Шавар, %	Механик бүрэлдэхүүн
BNU-SM-1	0-10	78.1	17.3	4.7	Элсэнцэр
BNU-SM-2	0-10	78.1	12.9	9.0	Элсэнцэр
BNU-SM-3	0-10	81.7	10.5	7.8	Нарийн элс
BNU-SM-4	0-10	80.5	7.9	11.6	Нарийн элс
BNU-SM-5	0-10	85.1	6.4	8.5	Нарийн элс
BNU-SM-6	0-10	78.5	14.2	7.4	Элсэнцэр
BNU-SM-7	0-10	79.5	10.5	9.9	Элсэнцэр

4.2.3. Хөрсний хүнд металл

Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см3–ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм. Судалгаагаар хөрсний мониторингийн цэгүүдээс авсан өнгөн хөрс (0-10см)-ний дээжүүдэд Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цагаан тугалга (Sn), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг тодорхойлуулсан. Судалгааны үр дүнгээс харахад эдгээр металлуудаас Cd, Mo, Sn маш бага буюу бараг илрээгүй, харин бусад металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн байна (**Error! Reference source not found.**). Эдгээр илэрсэн хүнд м еталлуудын үр дүнг доор дэлгэрэнгүй оруулсан.

Хүснэгт 15. Хөрсний мониторинг цэгүүд дэх хүнд металлын агууламж

Цэгийн дугаар	Хортой, мг/кг				Био-идэвхт, мг/кг							
	As	Cd	Cr	Pb	Co	Cu	Mo	Ni	Sn	Sr	V	Zn
BNU-SM-1	14	<1	28	29	7	27.6	2	15	<10	308	63	80

BNU-SM-2	<3	<1	43	23	13	29	2	23	<10	263	106	70
BNU-SM-3	9	<1	40	21	10	26	2	20	<10	225	87	60
BNU-SM-4	8	<1	29	19	8	22.9	2	13	<10	339	76	58
BNU-SM-5	4	<1	12	17	3	7	2	5	<10	165	35	32
BNU-SM-6	17	<1	35	20	6	16.7	2	20	<10	211	55	59
BNU-SM-7	<3	<1	20	20	6	10.9	2	9	<10	178	50	44

Хөрсний хүнцэл (As)

Хүнцэл нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад As-ийн утгын хэлбэлзэл 3-17 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний хүнцлийн агууламж стандартын хүлцэх агууламж 20.0 мг/кг-аас хэтэрсэн тохиолдол байхгүй буюу хэвийн байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 27. Хөрсний мониторинг цэгүүд дэх As-ийн агууламж

Хөрсний хром (Cr)

Хром нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн Хромын гуравч исэл (CrO_3) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Cr-ийн утгын хэлбэлзэл 1 2-43 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний Хромын агууламж стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 28. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cr-ийн агууламж

Хөрсний хар тугалга (Pb)

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Pb-ын утгын хэлбэлзэл б үх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 17-29 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 29. Хөрсний мониторинг цэгүүд дэх Pb-ын агууламж

Хөрсний кобальт (Co)

Кобальт нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! R eference source not found.**) харахад Co-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 3-13 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 50 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 30. Хөрсний мониторинг цэгүүд дэх Co-ийн агууламж

Хөрсний зэс (Cu)

Зэс нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Cu-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд бага агууламжтай буюу 7-28 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 100 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 31. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cu-ийн агууламж

Хөрсний никель (Ni)

Никель нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Ni-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 5-23 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 32. Хөрсний мониторинг цэгүүд дэх Ni-ийн агууламж

Хөрсний стронций (Sr)

Стронций нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Sr-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 165-339 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 800 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.



График 33. Хөрсний мониторинг цэгүүд дэх Sr-ийн агууламж

Хөрсний ванадий (V)

Ванадий нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! R eference source not found.**) харахад V-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 35-106 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 34. Хөрсний мониторинг цэгүүд дэх V-ийн агууламж

Хөрсний цайр (Zn)

Цайр нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн цайрын исэл (ZnO) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Zn-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 32-80 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 300 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 35. Хөрсний мониторинг цэгүүд дэх Zn-ийн агууламж

4.2.4. Хөрсний нянгийн бохирдол

Кемпийн цэвэрлэх байгууламж болон түүний ойр орчмын хөрсний нянгийн бохирдлыг шалгах зорилгоор авсан дээжүүдэд нийт бичил биетний тоо нь байх ёстой хязгаарт илэрсэн, мөн халдварт өвчин үүсгэгч болон гэдэсний бүлгийн савханцар илрээгүй буюу бохирдолгүй гарсан байна. Шинжилгээний үр дүнг хавсралтаас үзнэ үү!

4.1.2. Зураглал

Хөрсний мониторинг цэгүүдийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.2 программ дээр ESRI Map ашиглан хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А4 хуудсан дээр шугаман масштабтайгаар бэлдсэн.



Зураг 26. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил

Хүснэгт 16. Хөрсний мониторинг цэгүүдийн ерөнхий мэдээлэл

Цэгийн дугаар	Ерөнхий байршил	Хөрсний гадаргын төлөв	Цэгийн солбицол	
			Y	X
BNU-SM-1	Шинэ карьерын хойно	Нөлөөлөл байхгүй	102.394697	43.089772
BNU-SM-2	Үндсэн овоолгын зүүн урд	Нөлөөлөл байхгүй	102.379075	43.086638
BNU-SM-3	Гаалийн хяналтын талбайн урд	Нүүрсний тоостой	102.368502	43.086525
BNU-SM-4	Шимт хөрсний овоолго	Бага зэрэг талхадсан	102.370914	43.0991
BNU-SM-5	Кемпийн цэвэрлэх байгууламж орчим	Хүчтэй талхадсан	102.407693	43.090183
BNU-SM-6	Кемпийн түр хогийн цэг орчим	Хүчтэй талхадсан	102.410122	43.090051
BNU-SM-7	Кемпээс зүүн хойшоо (Хяналтын цэг)	Нөлөөлөл байхгүй	102.41518	43.096149

4.3. Дүгнэлт

- Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь “Баруун ноён уул” уурхайн хөрсний орчны хяналт шинжилгээг 2024 оны 5-р сард нийт 7 цэг дээр хөрсний агро-хими ба ус-физик шинж чанар, хүнд металл зэрэг 21-н үзүүлэлтээр тодорхойллоо.
- Нийт 7-н цэгээс 1 цэг нь ердийн буюу ямар нэг эвдрэл, талхагдалд ороогүй буюу контрол цэг, 1 цэг нь шимт хөрсний, 2 цэг нь кемп орчмын, 3 цэг нь уурхай орчмын хяналт хийхээр сонгосон.
- Ахуйн болон техникийн гаралтай хатуу хог хаягдал болон шатах тослох материалаар бохирдож болзошгүй цэгийн хөрсний гадарга дээр мэдэгдэхүйц том хэмжээний бохирдол байхгүй, ганц нэг цэгт тослох материалын жижиг толботой байна.
- Хөрсний органик бохирдлын хувьд нүүрсний тоосжилт ихтэй BNU-SM-3 цэгт бага зэрэг механик бохирдол үүссэн байна. Мөн энэ жилийн дундаж нь өмнөх жилүүдийн дунджаас бага зэрэг өссөн байгаа нь уурхай орчимд нүүрсний тоосноос шалтгаалсан органик бохирдол бага зэрэг нэмэгдэж байгааг илтгэж байна.
- Хөрсний урвалын орчин нь контрол цэгтэй ойролцоо түвшинд байгаа буюу хэт хүчиллэг юм уу шүлтлэг болоогүй байна.
- Нийт төслийн талбайд зонхилон тархсан хөрсөн бүрхэвч нь ихэвчлэн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй учраас хөдөлгөөнт фосфор, калийн хангамж багатай буюу үржил муутай байна.
- Хөрсний хүнд металлуудын хувьд Cd, Mo, Sn маш бага буюу бараг илрээгүй, харин бусад металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн бөгөөд эдгээрийн агууламж стандартын хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй хэвийн түвшинд байна.

ТАВ. УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

5.1. Ургамлан нөмрөгийн судалгаа хийсэн арга зүй

Судалгааны зорилго: Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж, бүрхцийн үндсэн үзүүлэлт, биомасс, зүйлийн тохиолдоц болон зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд түүний тархалт, хамгааллын статус, ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал өөрчлөлт, доройтлыг илрүүлэх зорилгоор мониторинг судалгааг орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгаа: Ургамлан нөмрөгийн хээрийн судалгааг 2024 оны 05-р сарын 25-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Судалгаа хийсэн арга зүй: Ургамалжилтын судалгааг хийхдээ ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, түүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, тусгаг бүрхэцийг Л.Г.Раменскийн аргаар тодорхойлсон. Геоботаникийн бичиглэл хийхдээ 1х1 м^2 раменскийн тор ашиглан тодорхойлсон бөгөөд санамсаргүй байрлуулан зүйл тус бүрээр бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материалуудад үндэслэн ургамлын тайланг боловсруулсан.

Геоботаникийн бичиглэлд

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйл тус бүрийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг И.В.Грубовын (1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.

Арви: Ургамалжилтын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Ургамалжилтын зүйлийн тусгаг бүрхцийг Раменскийн 1 м^2–ийн хэмжээст тороор тодорхойлсон.

Өсөлт: Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт хэмжсэн.

Хүснэгт 17. Ургамлан бүрхэвчийн арви ба бүрхцийн үнэлгээ

Арви	Тусгаг бүрхэц, %	Ургамлын тохиолдоц, тархалтын шинж
Soc	75 %,<	Ургамал маш ихээр буюу нэлэнхүйд нь тархсан
Cop3	51 -75 %	Ургамал ихээр биш буюу нэлэнхүйд нь тархсан
Cop2	26 - 50 %	Ургамал нэлээд ихээр тархсан
Cop1	11 - 25 %	Ургамал дунд зэрэг тархсан
Sp	5 - 10 %	Ургамал бага зэрэг тархсан
Sol	1 -2 %	Ургамал хааяа нэг тохиолдоно
Rr	1>	Талбайд зөвхөн ганц нэг тохиолдоно

5.2. Ургамлан нөмрөгийн судлагдсан байдал

Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их муж (III), Алтайн өвөр говийн муж (III.2)-ийн Алтайн өвөр говийн тойрогт хамаарна. Харин байгалийн байгалийн бүс бүслүүрээр Цөлийн бүсэд хамаарна.

Цөлийн бүс: Монголын нутагт Төв Азийн цөлийн зөвхөн хойд зах нь оршино. Цөлийн бүс нь ихэнх хэсэгтээ цөлийн бор саарал хөрстэй, харин Алтайн өвөр говийн хэсэгтээ нэн цөлөрхөг гөлтгөнөт бор саарал хөрстэй. Хотгор хотостоо хужир мараатай, давстай тойрмуудтай. Алашаа горвийн хэсэгтээ ихээхэн манхан элстэй, бусад хэсэгт нь сул элсэн хөрстэй газар нэлээд бий. Цөлийн бүсэд жилдээ 100 мм-ээс ямагт бага тунадас унадаг. Ургамал ургах тохиромжтой хугацаа хангалттай урт боловч энэ үед байнга гантай, чийг дутагдалтай байдгаараа онцлог юм. Зарим нутагт хур бороо орохгүй хэдэн жил ч өнжих явдал бий. Цөлд ус чийг хомс, хуурай халуун, салхи ихтэй байдаг учраас тэнд өвс ургамал тун сийрэг, төдийгүй тачирхан, намхан ургадаг юм.



Зураг 27. Монгол орны физик газарзүйн мужлалт



Зураг 28. Монгол орны ургамал газарзүйн тойрог

5.3. Ургамлан нөмрөгийн хэв шинж, өнөөгийн төлөв байдал



Усны орчин, pH	-*-	6.5-8.5	6.81	7.49	
EC	мСм/см	1	0.71	0.674	
Cl ѿ Хлорын агууламж	мг/л	350	102.79	88.61	
SO ҂ѿ Сульфатын агууламж	мг/л	500	-	-	
NO ҧѿ Нитритын агууламж	мг/л	1	-	-	
NO ҧѿ Нитратын агууламж	мг/л	50	0.1		

Физик болон химийн үзүүлэлтүүд			145 Нийтийн ариун цэврийн өрөө		
Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2023.08.21	2024.01.15	2024.06.07
Тунгалаг	см	-	-	-	Шинжилгээ хийгдээгүй
Өнгө	-*-	20	-	-	
Үнэр			-	-	
Тунадас	-	-	-	-	
Булингаршил	NTU	5	-	-	
Усны орчин, pH	-*-	6.5-8.5	6.97	7.43	
EC	мСм/см	1	0.713	0.616	
Cl ѿ Хлорын агууламж	мг/л	350	116.9	88.61	
SO ҂ѿ Сульфатын агууламж	мг/л	500	-	-	
NO ҧѿ Нитритын агууламж	мг/л	1	-	-	
NO ҧѿ Нитратын агууламж	мг/л	50	0.3		

CO ₹ ₪	мг/л	-	-	-	
HCO ₹	мг/л	-	-	-	
Na ϕ+K ϕ	мг/л	-	-	-	
Ca ϕ ϕ Кальцийн агууламж	мг/л	100	20.04	25.05	
NH ϒϕ Аммонийн агууламж	мг/л	1.5	0.2	0.1	
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	
Fe ϕ ϕ ϕ Төмрийн агууламж	мг/л	0.3	-	-	
TDS	мг/л	-	-	-	
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	1.25	1.75	

CO ₹ ₪	мг/л	-	-	-	
HCO ₹	мг/л	-	-	-	
Na ϕ+K ϕ	мг/л	-	-	-	
Ca ϕ ϕ Кальцийн агууламж	мг/л	100	61.112	15.03	
NH ϒϕ Аммонийн агууламж	мг/л	1.5	0.3	0.08	
Fe ϕ ϕ	мг/л	0.3	-	-	
Fe ϕ ϕ ϕ Төмрийн агууламж	мг/л	0.3	-	-	
TDS	мг/л	-	-	-	
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	4.1	1.5	

Дээрх харьцуулалтаас харахад өмнө авсан гал тогооны уснуудын дээжийг ундны усны стандартын дагуу шинжилгээнд өгөөгүй нь бидний авсан дээжийн хариутай харьцуулахад усны анионууд харьцуулагдах боломжгүй нөхцөл үүссэн. Цаашид ундны усны дээжүүдийг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартаар өгч байхыг зөвлөж байна.

3.3.11 Төслийн гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Усны хэрэглээнд хяналт тавьж, хэрэглэсэн усны балансыг гаргаж байх;
- Компанийн байгаль орчны мэргэжилтнүүдийг усны түвшин хэмжих болон тухайн үеийн температур, TDS, Ph хэмжих, түвшин хэмжигч зэрэг багаж хэрэгслээр хангаж газрын доорх усны чанар, түвшний өөрчлөлтийн урт хугацааны өөрчлөлтийн мэдээллийг цуглуулах нөхцөлийг бүрдүүлэх,
- Газрын доорх усны чанарын хяналт, түвшний хэмжилт зэргийг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж өмнөх хяналт мониторингийн ажилтай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгч байх.

Бууруулах арга хэмжээ:

- Орчны хяналт шинжилгээний хүрээнд олон нийтийн оролцоог хангаж нутгийн иргэд эсвэл орон нутгийн байгаль орчны газар бусад төлөөлөгчдийг оролцуулан усны хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулах (Уснаас дээж авах)
- Усны дээж авахдаа MNS ISO 5667-1-2002, MNS ISO 5667-3-1999, MNS ISO 5667-4-2001, MNS 5667-6-2001, MNS ISO 5667-10-2001 стандартын арга аргачлалын дагуу гүйцэтгэх
- Гүний худгуудын тоолуурын бүрэн бүтэн хэвийн ажиллагааг хангаж ажиллах
- Гүний худгийн гадна байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, гаднын хүн нэвтрэхээс хамгаалсан байх,
- Гүний худгаас мэргэжлийн байгууллага, эрх бүхий хүмүүс дээж авах, тоолуурын бичилт хийх үед нэвтрэхэд саад учруулахгүй, түвшин хэмжигч орох нүх гаргасан байх шаардлагатай
- Усны хэрэглээний бүртгэл: Ус ашиглалтын тайлан, бүртгэлийг байнга хөтлөн явуулах, шаардлагатай мэдээ, тайланг холбогдох газруудад цаг тухай бүрд хүргүүлэх.

3.3 Дүгнэлт, зөвлөмж

- Химийн дүн шинжилгээг харахад 6 сарын усны найрлагаас 9 дүгээр сарын усны найрлагын голлох элементүүд болох Na+K болон Сульфат (SO_4) буурсан байгаа нь зуны хур тунадасны тэжээгдлээс шалтгаалсан байх боломжтой. Тухайн элемент өндөр байх нь усыг шорвог амттай болгодог. Харин усны цэнгэг байдлыг илэрхийлдэг гидрокарбонат (HCO_3) болон кальци (Ca ф)ф9 сард өндөр болж байгаа нь хур тунадасны усаар тэжээгдэн нөхөн сэлбэгдэж байгааг илэрхийлж болохоор байна.
- Дээж авахад хүндрэл учраагүй боловч, газрын доорх усны түвшин хэмжихэд хүндрэл учирсан. Иймд цаашид ашиглалтын худаг бүрд түвшин хэмжих нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай.
- Уурхайн урсгалын доор байрлах “Малчны худаг 1, 2, 3” дугаартай худгуудын усны түвшин болон ундны усны стандартын дагуу шинжлүүлсэн үр дүнг харахад уурхайн үйл ажиллагаагаар өнөөгийн байдлаар ноцтой нөлөөлсөн зүйл байхгүй байна. Гэвч энэ нь үргэлж ийм байдлаар байна гэсэн шууд утга биш тул тогтмол орон нутгийн иргэдийн усан хангамжийн худгуудад дээжлэлт, түвшний хэмжилт хийж ажиллах. Улмаар үр дүнг нутгийн иргэдэд улирал тутамд тайлагнаж байх шаардлагатай. Усны түвшин буурах болон бага зэрэг шорвог болох тухайн бүс нутгийн цаг уурын онцлогоос шалтгаалж болно. Хэрэв ийм төрлийн асуудал тулгарсан тохиолдолд мэргэжлийн инженерүүдээс зөвлөгөө авч юунаас үүдэлтэйг олох шаардлагатай.
- Уурхайн үйл ажиллагаа буюу ухмал, шүүрлийн ус зайлуулах үйл ажиллагааны нөлөөлөлд малчны худгууд өртөхгүй байх геоморфологийн зүй тогтол ажиглагдаж байна. Харин уурхайн усан хангамжийн худгуудын ус ашиглалт нь тодорхой хэмжээнд малчдын худагт нөлөөлөх боломжтой.
- Уурхайд орж ирэх шүүрлийн усны тооцоог “Их худгийн арга”-р хийхэд 1206.6 м3/хоног байна. Харин цаашид уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай татан зайлуулах усны хэмжээг Ф.Форхгеймерийн томьёогоор тооцоход 6613 м3/хоног гэж тус тус гарсан.
- Уурхайд орж ирэх усны хэмжээнээс зайлуулах усны хэмжээ их байгаа нь одоогийн хуримтлагдсан уснаас шалтгаалсан ба цаашид шүүрч орж ирэх ус болон татан зайлуулах усны хэмжээ тэнцэх боломжтой. Иймд уурхайн ус зайлуулах помпийг сонгохдоо тухайн нөхцөл байдлыг тулгуурлан сонгох шаардлагатай.

¶ Уурхайн усан орчинд үзүүлэх нөлөөлөл химийн найрлага талаас бага, газрын доорх усны нөөцөд нөлөөлөх талаас дунд зэргийн нөлөөлөлтэй байна.

ДӨРӨВ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

4.1 Судалгааны аргазүй

4.1.1 Хөрсний хээрийн судалгаа

“Баруун ноён уул” уурхайн 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2024.05 болон 9-р сард хоёр удаагийн давталттайгаар авч лабораторын үр дүнг харьцуулсан байдлаар боловсруулсан. Энэхүү талбайд хөрсний мониторинг хийдэг нийт 7-н цэгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) өнгөн хөрсний буюу 0-10 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдлын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298 : 1990” стандартыг баримталсан.

4.1.2 Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжүүдэд агро-хими, физик шинж, хүнд металл зэрэг 20 орчим үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. ***Хөрсний агрохимийн шинж*** чанарын үзүүлэлтүүдийг “Green lab” Хөрс судлалын лабораторид тодорхойллоо. Үүнд:

- Органик нүүрс
- төрөгчийн агуулга - Шатаалтын алдагдал
- Ялзмаг - Тюриний
- Урвалын орчин (pH) - Потенциометрийн
- $CaCO_3$ карбонат - Кальциметрийн
- Механик бүрэлдэхүүн - Гидрометрийн
- Давсжилт, EC - Потенциометрийн
- Фосфор - Спектро фотометр
- Кали - Дөлт фотометр

Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991” стандартуудыг мөрдлөг болгосон.

Хүнд металл. Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг магадлан итгэмжлэгдсэн SGS олон улсын лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.

4.1.3 Зураглал

Хөрсний мониторинг цэгүүдийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.2 программ дээр ESRI Map ашиглан хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А4 хуудсан дээр шугаман масштабтайгаар бэлдсэн.


Цэгийн дугаар | Ерөнхий Байршил | Шинжилгээний төрөл | Координат, Decimal degree | X | Y
BNU-SM-1 | Шинэ карьерийн хойно | Агрохимик, Хүнд металл | 102.394657 | 43.089772
BNU-SM-2 | Үндсэн овоолгын зүүн урд | Агрохимик, Хүнд металл | 102.379075 | 43.086638
BNU-SM-3 | Тавцайн ялтсын халбайн урд | Хүнд металл | 102.368502 | 43.086525
BNU-SM-4 | Шинэ хөрсний овоолго | Агрохимик | 102.370914 | 43.0991
BNU-SM-5 | Кемпийн цэвэрлэх байгууламж орчим | Эрүүл ахуй | 102.407693 | 43.090183
BNU-SM-6 | Кемпийн түр хогийн цэг орчим | Хүнд металл | 102.410122 | 43.090051
BNU-SM-7 | Кемпээс зүүн хойшоо (Тэнхлэгтэн цэг) | Агрохимик, Хүнд металл | 102.41518 | 43.096149
BNU-SM-4
BNU-SM-7
BNU-SM-1
BNU-SM-5
BNU-SM-6
BNU-SM-3
BNU-SM-2
0 0.2 0.4 0.8 1.2 Kilometers

Зураг 4- 1. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил

Хүснэгт 4- 1. Хөрсний мониторинг цэгүүдийн ерөнхий мэдээлэл

Цэгийн дугаар	Ерөнхий байршил	Хөрсний гадаргын төлөв	Цэгийн солбицол	
			Y	X
BNU-SM-1	Шинэ карьерын хойно	Нөлөөлөл байхгүй	102.394697	43.089772
BNU-SM-2	Үндсэн овоолгын зүүн урд	Нөлөөлөл байхгүй	102.379075	43.086638
BNU-SM-3	Гаалийн хяналтын талбайн урд	Нүүрсний тоостой	102.368502	43.086525
BNU-SM-4	Шимт хөрсний овоолго	Бага зэрэг талхадсан	102.370914	43.0991
BNU-SM-5	Кемпийн цэвэрлэх байгууламж орчим	Хүчтэй талхадсан	102.407693	43.090183
BNU-SM-6	Кемпийн түр хогийн цэг орчим	Хүчтэй талхадсан	102.410122	43.090051
BNU-SM-7	Кемпээс зүүн хойшоо (Хяналтын цэг)	Нөлөөлөл байхгүй	102.41518	43.096149

4.2 Судалгааны үр дүн

4.2.1 Хөрсний гадаргын өнөөгийн төлөв байдал

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-1: Энэ цэг нь шинэ карьерын хойно байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй цэвэр байна.

Зураг 4- 2. BNU-SM-1 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-2: Энэ цэг нь үндсэн овоолгын зүүн урд байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй цэвэр байна.

Зураг 4- 3. BNU-SM-2 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-3: Энэ цэг нь гаалийн хяналтын талбайн урд замын дэргэд байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг

нягтавтар, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй, нүүрсний тоосонцрын нимгэн хучаастай байна.

Зураг 4- 4. BNU-SM-3 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-4: Энэ цэг нь шимт хөрсний овоолгын урд захад байрлах бөгөөд хөрсний гадарга нь өнгөр тогтож бэхэжсэн, хөрсний өнгөн хэсэг сийрэг, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна.

Зураг 4- 5. BNU-SM-4 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-5: Энэ цэг нь кемпийн цэвэрлэх байгууламж орчимд байрлах бөгөөд хөрсний гадарга нь хүчтэй талхадсан, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна.

Зураг 4- 6. BNU-SM-5 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-6: Энэ цэг нь хог хаягдал түр хадгалах цэгийн дэргэд байрлах бөгөөд хөрсний өнгөн хэсэг нь хүний хөлийн болон техникийн нөлөөгөөр нэлээд талхадсан, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдол бага байна.

Зураг 4- 7. BNU-SM-6 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

Хөрсний мониторингийн цэг BNU-SM-7 (Контрол цэг): Энэ цэг нь кемпийн талбайгаас зүүн хойшоо 750м орчим зайд байрлах бөгөөд ямар нэгэн нөлөөлөл байхгүй ердийн хөрсөн бүрхэвчтэй, хөрсний өнгөн хэсэг сийрэгдүү, ургамал бүрхэвч сайтай, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдолгүй цэвэр байна..

Зураг 4- 8. BNU-SM-7 цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

4.2.2 Хөрсний агро-хими, физик шинж чанар

Хөрсний урвалын орчин (pH)

Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад нэн тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад pH-ийн утгын хэлбэлзэл 8.5-9.35 хооронд буюу хүчтэй шүлтлэг орчинтой байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 1.. Хөрсний мониторинг цэгүүд дэх pH-ийн утга

Хөрсний карбонатжилт

Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO_3)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад карбонатын агууламж 1.1-1.6%-ийн хооронд буюу сул карбонатжсан байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 2. Хөрсний мониторинг цэгүүд дэх карбонатын агууламж

Хөрсний ялзмагийн агууламж

Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг

сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Энэ бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарах учраас хүний нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсөн бүрхэвч дунджаар 1.0% ялзмагтай байдаг (суурь судалгаа). Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад ялзмагийн утгын хэлбэлзэл 0.76%-1.17%-ийн хооронд буюу маш бага агууламжтай байна. Нүүрсний тоосжилт ихтэй BNU-SM-3 цэгт бага зэрэг механик бохирдол үүссэн байна. Мөн энэ жилийн дундаж нь өмнөх жилүүдийн дунджаас бага зэрэг өссөн байгаа нь уурхай орчимд нүүрсний тоосноос шалтгаалсан органик бохирдол нэмэгдэж байгааг илтгэж байна.



График 4- 3. Хөрсний мониторинг цэгүүд дэх ялзмагийн агууламж

Хөрсний цахилгаан дамжуулалт (EC) буюу хялбар уусах давсжилт

EC буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд EC нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний EC-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсний EC нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад (**Error! Reference source not found.**) $EC_{1:2.5}$-ийн утгын хэлбэлзэл 0.09-0.27 dS/m хооронд буюу маш сул давсархаг байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 4. Хөрсний мониторинг цэгүүд дэх EC-ийн түвшин

Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P_2O_5, K_2O)

Хөрсний фосфор, кали (P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Фосфор нь мөн ургамлын үндэсний өсөлтийг дэмжиж, цэцэглэж ургахад чухал нөлөөтэй байдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P_2O_5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидыг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K_2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K_2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад P_2O_5-ын утгын хэлбэлзэл 0.8-2.3 мг/100г -ийн хооронд буюу хөдөлгөөнт фосфор бага байгаа нь харагдаж байна. Хөдөлгөөнт калийн хувьд утгын хэлбэлзэл нь 6-30 мг/100г -ийн хооронд буюу багаас сайн хангамжтай байна (**Error! Reference source not found.**). Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 5. Хөрсний мониторинг цэгүүд дэх P_2O_5-ын хангамж



График 4- 6. Хөрсний мониторинг цэгүүд дэх K_2O-ийн хангамж

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаврынх <0.002мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэд маш нөлөөтэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**) харахад хөрсөн дэх элсэн фракцын утгын хэлбэлзэл 78-85%, шавар 5-12%-ийн хооронд буюу том ширхэгтэй элсэн фракц давамгайлсан элсэнцэр болон нарийн элсэн хөрстэй байна.



График 4- 7 Хөрсний мониторинг цэгүүд дэх механик бүрэлдэхүүн

4.2.3 Хөрсний хүнд металл

Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см3–ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм. Судалгаагаар хөрсний мониторингийн цэгүүдээс авсан өнгөн хөрс (0-10см)-ний дээжүүдэд Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цагаан тугалга (Sn), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг тодорхойлуулсан. Судалгааны үр дүнгээс харахад эдгээр

металлуудаас Cd, Mo, Sn маш бага буюу бараг илрээгүй, харин бусад металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн байна (Хүснэгт 1). Эдгээр илэрсэн хүнд металлуудын үр дүнг доор дэлгэрэнгүй оруулсан.

Хүснэгт 1. Хөрсний мониторинг цэгүүд дэх хүнд металлын агууламж (9-р сар)

Цэгийн дугаар	Хортой, мг/кг				Био-идэвхт, мг/кг							
	As	Cd	Cr	Pb	Co	Cu	Mo	Ni	Sn	Sr	V	Zn
BNU-SM-1	13	<1	34	23	9	39	<1	16	<10	235	70	188
BNU-SM-2	<3	<1	43	17	14	33	<1	24	<10	208	97	100
BNU-SM-3	17	<1	42	18	13	33	<1	22	<10	231	90	78
BNU-SM-4	4	<1	28	16	11	25	<1	13	<10	308	72	74
BNU-SM-5	8	<1	24	15	6	15	<1	8	<10	179	42	54
BNU-SM-6	15	<1	26	16	7	17	<1	11	<10	184	50	59
BNU-SM-7	11	<1	26	17	8	23	<1	11	<10	169	55	52

Хөрсний хүнцэл (As)

Хүнцэл нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад As-ийн утгын хэлбэлзэл 3-17 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний хүнцлийн агууламж стандартын хүлцэх агууламж 20.0 мг/кг-аас хэтэрсэн тохиолдол байхгүй буюу хэвийн байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 8. Хөрсний мониторинг цэгүүд дэх As-ийн агууламж

Хөрсний хром (Cr)

Хром нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн Хромын гуравч исэл (CrO_3) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Cr-ийн утгын хэлбэлзэл 12-43 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний Хромын агууламж стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 9. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cr-ийн агууламж

Хөрсний хар тугалга (Pb)

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Pb-ын утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 17-29 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 10 Хөрсний мониторинг цэгүүд дэх Pb-ын агууламж

Хөрсний кобальт (Co)

Кобальт нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Co-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 3-13 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 50 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 11 Хөрсний мониторинг цэгүүд дэх Co-ийн агууламж

Хөрсний зэс (Cu)

Зэс нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Cu-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд бага агууламжтай буюу 7-28 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 100 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 12. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cu-ийн агууламж

Хөрсний никель (Ni)

Никель нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Ni-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 5-23 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх Ni-ийн агууламж

Хөрсний стронций (Sr)

Стронций нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Sr-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 165-339 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 800 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.



График 4- 14. Хөрсний мониторинг цэгүүд дэх Sr-ийн агууламж

Хөрсний ванадий (V)

Ванадий нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад V-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 35-106 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 15. Хөрсний мониторинг цэгүүд дэх V-ийн агууламж

Хөрсний цайр (Zn)

Цайр нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн цайрын исэл (ZnO) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (**Error! Reference source not found.**) харахад Zn-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 32-80 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 300 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна. Мөн энэ жилийн судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүнгээс хэт их өөрчлөлт багатай буюу хэвийн байна.



График 4- 16. Хөрсний мониторинг цэгүүд дэх Zn-ийн агууламж

4.2.4 Хөрсний нянгийн бохирдол

Кемпийн цэвэрлэх байгууламж болон түүний ойр орчмын хөрсний нянгийн бохирдлыг шалгах зорилгоор авсан дээжүүдэд 6-р сарын байдлаар нийт бичил биетний тоо нь байх ёстой хязгаарт илэрсэн, мөн халдварт өвчин үүсгэгч болон гэдэсний бүлгийн савханцар илрээгүй буюу бохирдолгүй гарсан байна. Харин 9-р сарын шинжилгээний үр дүнгээс харахад халдварт өвчин үүсгэгч болон гэдэсний бүлгийн савханцар илэрсэн буюу бага зэрэг бохирдолтой гарсан байна. Шинжилгээний үр дүнг хавсралтаас үзнэ үү!

4.3 Дүгнэлт

- Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь “Баруун ноён уул” уурхайн хөрсний орчны хяналт шинжилгээг 2024 оны 5-р сард нийт 7 цэг дээр хөрсний агро-хими ба ус-физик шинж чанар, хүнд металл зэрэг 21-н үзүүлэлтээр тодорхойллоо.

- Нийт 7-н цэгээс 1 цэг нь ердийн буюу ямар нэг эвдрэл, талхагдалд ороогүй буюу контрол цэг, 1 цэг нь шимт хөрсний, 2 цэг нь кемп орчмын, 3 цэг нь уурхай орчмын хяналт хийхээр сонгосон.
- Ахуйн болон техникийн гаралтай хатуу хог хаягдал болон шатах тослох материалаар бохирдож болзошгүй цэгийн хөрсний гадарга дээр мэдэгдэхүйц том хэмжээний бохирдол байхгүй, ганц нэг цэгт тослох материалын жижиг толботой байна.
- Хөрсний органик бохирдлын хувьд нүүрсний тоосжилт ихтэй BNU-SM-3 цэгт бага зэрэг механик бохирдол үүссэн байна. Мөн энэ жилийн дундаж нь өмнөх жилүүдийн дунджаас бага зэрэг өссөн байгаа нь уурхай орчимд нүүрсний тоосноос шалтгаалсан органик бохирдол бага зэрэг нэмэгдэж байгааг илтгэж байна.
- Хөрсний урвалын орчин нь контрол цэгтэй ойролцоо түвшинд байгаа буюу хэт хүчиллэг юм уу шүлтлэг болоогүй байна.
- Нийт төслийн талбайд зонхилон тархсан хөрсөн бүрхэвч нь ихэвчлэн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй учраас хөдөлгөөнт фосфор, калийн хангамж багатай буюу үржил муутай байна.
- Хөрсний хүнд металлуудын хувьд Cd, Mo, Sn маш бага буюу бараг илрээгүй, харин бусад металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн бөгөөд эдгээрийн агууламж стандартын хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй хэвийн түвшинд байна.

ТАВ. УРГАМЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

5.1 Танилцуулга

“Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших ““Баруун ноён уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж, бүрхцийн үндсэн үзүүлэлт, биомасс, зүйлийн тохиолдоц болон зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд түүний тархалт, хамгааллын статус, ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал өөрчлөлт, доройтлыг илрүүлэх мониторинг судалгааг орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Төслийн талбайн 2024 оны ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг 6, 9-р саруудад 2 удаагийн хээрийн хэмжилт судалгааны мэдээлэлд үндэслэн, үр дүнг харьцуулан боловсруулллаа.

Зураг 5- 1. Ургамлан нөмрөгийн төлөв байдал /2024.06 сар/

Зураг 5- 2. Ургамлан нөмрөгийн төлөв байдал /2024.09 сар/

5.2 Ургамлан нөмрөгийн судалгаа хийсэн арга зүй

Ургамалжилтын судалгааг хийхдээ ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, түүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, тусгаг бүрхцийг Л.Г.Раменскийн аргаар тодорхойлсон. Геоботаникийн бичиглэл хийхдээ тухайн ургамлын мониторингийн цэгийг төлөөлүүлэн 1х1 м2 болон 10 х10 м2 талбайд раменскийн тор ашиглан тодорхойлсон бөгөөд санамсаргүй байрлуулан цэг тус бүрээр бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материалуудад үндэслэн ургамлын тайланг боловсруулсан.

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйл тус бүрийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг И.В.Грубовын (1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.

Арви: Ургамалжилтын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Ургамалжилтын зүйлийн тусгаг бүрхцийг Раменскийн 1 м^2–ийн хэмжээст тороор тодорхойлсон.

Хүснэгт 5- 1. Ургамлан бүрхэвчийн арви ба бүрхцийн үнэлгээ

ф tѳ ѳ ɑf	ʊ lz fŋ ɢ Θ ɢ в %	ʊ tѳ ɢ Θ dʒdzr dz. ls ts:: ɑf ts dzн ts ч , ls Θ tѳ::
Soc- Socialis	*75 %,<*	*Ургамал маш ихээр буюу нэлэнхүйд нь тархсан*
Cop3- Copiosae 3	*51 -75 %*	*Ургамал ихээр биш буюу нэлэнхүйд нь тархсан*
Cop2- Copiosae 2	*26 - 50 %*	*Ургамал нэлээд ихээр тархсан*
Cop1- Copiosae 1	*11 - 25 %*	*Ургамал дунд зэрэг тархсан*
Sp- Sparsae	*5 - 10 %*	*Ургамал бага зэрэг тархсан*
Sol- Solitaries	*1 -2 %*	*Ургамал хааяа нэг тохиолдоно*
Rr-Rare	*1>*	*Талбайд зөвхөн ганц нэг тохиолдоно*
Un-Unicum	*1>*	*Маш ховор тохиолдоно*

Ургац: Мониторингийн цэг тус бүрээс ургацын дээжийг газрын хөрснөөс 0 см өндөрт хайчлан авч ерөнхий ургацыг тодорхойлсон бөгөөд, ургацыг нойтон ба хуурай жинг жигнэж тодорхойлсон.

NDVI тодорхойлох арга: Ургамлын нормчлогдсон ялгаврын индексийг тодорхойлохдоо “Сэнтинэл 2” хиймэл дагуулын зуны мэдээг ашиглан дүрс зүйн боловсруулалт хийн NDVI S2 = Band8 – Band4 / band8 + Band4 томьёог ашиглаж тодорхойлсон.



Зураг 5- 3 Ургамлан нөмрөгийн хэмжилт судалгаа хийж буй байдал

5.3 Судалгааны талбайн ургамлан нөмрөг

Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их муж (III), Алтайн өвөр говийн муж (III.2)-ийн Алтайн өвөр говийн тойрогт хамаарна. Харин байгалийн байгалийн бүс бүслүүрээр Цөлийн бүсэд хамаарна.

Цөлийн бүс: Монголын нутагт Төв Азийн цөлийн зөвхөн хойд зах нь оршино. Цөлийн бүс нь ихэнх хэсэгтээ цөлийн бор саарал хөрстэй, харин Алтайн өвөр говийн хэсэгтээ нэн цөлөрхөг гөлтгөнөт бор саарал хөрстэй. Хотгор хотостоо хужир мараатай, давстай тойрмуудтай. Алашаа горвийн хэсэгтээ ихээхэн манхан элстэй, бусад хэсэгт нь сул элсэн хөрстэй газар нэлээд бий. Цөлийн бүсэд жилдээ 100 мм-ээс ямагт бага тунадас унадаг. Ургамал ургах тохиромжтой хугацаа хангалттай урт боловч энэ үед байнга гантай, чийг дутагдалтай байдгаараа онцлог юм. Зарим нутагт хур бороо орохгүй хэдэн жил ч өнжих явдал бий. Цөлд ус чийг хомс, хуурай халуун, салхи ихтэй байдаг учраас тэнд өвс ургамал тун сийрэг, төдийгүй тачирхан, намхан ургадаг юм.



Зураг 5- 4 Төслийн талбайн ургамал газарзүйн тойргийн байршил

5.4 Судалгааны талбайн ургамлан нөмрөг, өнөөгийн төлөв байдал

Ургамалжилтын судалгааны үр дүнд судалгааны талбай түүний орчимд ландшафтын онцлогоос хамааран гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн **Холимог сөөгт (180, Ц-I-2-8)** болон **Баглуур-бударганат (164. Ц-I-1-2) бүлгэмдэл** тархсан байна.



Зураг 5- 5. Судалгааны талбайн ургамалжилт

<u>Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл:</u> Бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц дунджаар 66.4%, ургамлын дундаж өндөр 35 см, чийгтэй дунджаар ургац 188.6 гр/м^2, хуурай ургац дунджаар 114.8 гр/м^2, 1м^2 талбайн зүйлийн баялаг дунджаар 7 зүйл ургамал, 10 м^2 талбайн зүйлийн баялаг дунджаар 12 зүйл ургамал бүртгэгдэж байв.

Бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц дунджаар 28%, 10 зүйлийн ургамал зонхилон бүртгэгдсэн, ургац 62.2 ц/га байна. Бүлгэмдлийн сөөглөг, сөөгөнцөрлөг ургамлын дундаж өндөр 32 см, олон наст өвслөг ургамлын дундаж өндөр 14 см байлаа. Энэхүү бүлгэмдэл нь сөөг, сөөглөг ургамлаас бүрдсэн учраас өнөөгийн төрх байдал нь харьцангуй хэвийн өөрчлөлтөнд өртөөгүй байна. Бүлгэмдлийн зонхилогч ургамлын хувьд Сибирь хармаг, Бор бударгана, Ахар навчит баглуур, Шар хотир, Орог тэсэг, Алтан харгана зэрэг зүйлүүд зонхилно.

Холимог сөөгт бүлгэмдэлд Nitraria sibirica-сибирь Хармаг, Salsola passerina- бор Бударгана, Anabasis brevifolia-ахар навчит Багалуур, Zygophyllum xanthoxylon- шар Хотир, Caragana leucophloea-алтан Харгана, Sympegma Regelii-Регелийн Шар мод, Amygdalus pedunculataбариулт Бүйлээс, Atraphaxis pungens-өргөст Эмгэн шилбэ зэрэг сөөглөг, сөөгөнцөрлөг ургамлууд ихэнх хувийг бүрдүүлж буй боловч олон наст өвслөг ургамлаас Stipa gobica-говийн Хялгана, Achnatherum splendens-цагаан Дэрс, Allium polyrrhizum-таана Сонгино зэрэг ургамлууд голлон тааралдана. Эдгээр зүйл ургамлууд нь арвийн хувьд cop1-sp үнэлгээтэйгээр тархаж, тусгаг бүрхэцийн хувьд сөөг, сөөглөг ургамал-20-25%, олон наст ургамлын борог өвснүүд 10-15%-ийн бүрхэцтэй.

Зураг 5- 6. бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар

Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл: Бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц дунджаар 19%, 5 зүйлийн ургамал зонхилон бүртгэгдсэн, ургац 71.4 ц/га байна. Бүлгэмдлийн сөөглөг, сөөгөнцөр ургамлын дундаж өндөр 28 см, олон наст өвслөг ургамлын дундаж өндөр 10 см байна. Бүлгэмдлийн зонхилогч ургамлын хувьд Ахар навчит баглуур, Улаан бударгана, Алтан харгана, Төлөгчдүү боролзой, Хөмөл зэрэг зүйлүүд зонхилно.

Баглуур-бударганат бүлгэмдэлд Salsola passerina-бор Бударгана, Anabasis brevifolia-ахар навчит Багалуур, Reamuria soongorica-улаан Бутаргана Caragana leucophloea-алтан Харгана, Ajania achilleoides-төлөгчдүү Боролзой, Salsola arbuscula-модлиг Бударгана зэрэг сөөглөг, сөөгөнцөр ургамлууд ихэнх хувийг бүрдүүлж буй боловч олон наст өвслөг ургамлаас Stipa gobica-говийн Хялгана, Achnatherum splendens-цагаан Дэрс, Allium polyrrhizum-таана Сонгино, Cleistogenes songorica-зүүнгарын Хазаар өвс зэрэг ургамлууд голлон тааралдана. Эдгээр зүйл ургамлууд нь арвийн хувьд cop1-sp үнэлгээтэйгээр тархаж, тусгаг бүрхэцийн хувьд сөөг, сөөглөг ургамал 15-20%, олон наст ургамлын борог өвснүүд 15-20%-ийн бүрхэцтэй.

Зураг 6- 1. Баглуур-бударганат (164. Ц-I-1-2) бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар

Төслийн талбайн газрын гадарга, ургамалжилтын ялгаатай байдал, нөлөөллийн эх үүсвэр зэргээс хамааруулан ургамлын мониторингийн 8 цэгийг байгуулсан байна. Эдгээр мониторингийн цэгүүдийн байршил, дугаар, солбицлыг доорх хүснэгт болон зургаар үзүүлэв.

Хүснэгт 5- 2. Ургамлын мониторингийн цэгүүдийн нэр, дугаар, солбицол

Цэгийн дугаар	Ерөнхий байршил	Цэгийн солбицол	
		Y	X
BNU-SM-1	Шинэ карьерын хойно	102.394697	43.089772
BNU-SM-2	Үндсэн овоолгын зүүн урд	102.379075	43.086638
BNU-SM-3	Гаалийн хяналтын талбайн урд	102.368502	43.086525
BNU-SM-4	Шимт хөрсний овоолго	102.370914	43.0991
BNU-SM-5	Кемпийн цэвэрлэх байгууламж орчим	102.407693	43.090183
BNU-SM-6	Кемпийн түр хогийн цэг орчим	102.410122	43.090051
BNU-SM-7	Кемпээс зүүн хойшоо (Хяналтын цэг)	102.41518	43.096149

Ургамлын мониторингийн BNU-SM-1 цэг: Тус цэг нь шинэ карьерын хойно байрлах бөгөөд уурхайн нөлөөллийг хянах зорилготойгоор тухайн мониторингийн цэгийг байгуулсан байна. Тухайн орчинд Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл тохиолдоно.

Ургамлын мониторингийн цэг BNU-SM-1

Зонхилох зүйл:
Allium polyrrhizum
Ajania acheleoides (Turcz.) Poljak.
Salsola laricifolia
Ptilotrichum canescens C.A. Mey
Ajania acheleoides(Turcz.) Poljak.)
Дагалдах зүйлүүд:
Eurotia ceratoides
Zygophyllum pterocarpum Bge..
Amygdalus mongolica Maxim.
Caragana brachypoda Pojark
Astragalus laguroides Pall.
Artemisia xanthochroa Krasch..

Ургамлын бүрхэц: 6 сард 31%, 9 сард 40%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Хэвийн соргог” ангилалд хамруулав.

BNU-SM-1 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 31%, 9 сард 40% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 4 зүйл тохиолдож байсан

бол 9 сард 5 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 9 зүйл, 9 сард 7 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 11 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 13-24 см байна.

Хүснэгт 0-1. Ургамлын мониторингийн BNU-SM-1 цэгийн бичиглэл

№	ŋ C ₽ dzɑʃ ₽ lʂdzʃ dʤOdzɹ tʂ	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	*Allium polyrrhizum*	12	15	cop1	+	+	14
2	*Ajania acheleoides (Turcz.) Poljak.*	8	10	sp	+	+	12
3	*Salsola laricifolia*		2	sp		+	13
4	*Ptilotrichum canescens C.A. Mey*	6	5	sp	+	+	8
5	*Ajania acheleoides(Turcz.) Poljak.)*	5	8	sp	+	+	17
Нийт 1 м^2 талбайд		**31**	**40**		**4**	**5**	**13**
Дагалдах зүйлүүд							
6	*Eurotia ceratoides*			-	+		35
7	*Zygophyllum pterocarpum Bge..*			-	+		14
8	*Amygdalus mongolica Maxim.*			-		+	19
9	*Caragana brachypoda Pojark*			-	+		35
10	*Astragalus laguroides Pall.*			-	+		11
11	*Artemisia xanthochroa Krasch..*			-		+	32
Нийт 10 м^2 талбайд		**-**	**-**	**-**	**9**	**7**	**24**

Ургамлын мониторингийн BNU-SM-2 цэг: Тус цэг нь үндсэн овоолгын зүүн урд байрлах бөгөөд ургамлан нөмрөг бага зэрэг талхадсан. Тухайн орчинд Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл тохиолдоно.

Зонхилох зүйлүүд:
Stipa glareosa P.Smirn.
Chenopodium acuminatum Willd
Salsola laricifolia Turcz.ex Litv
Ajania acheleoides (Turcz. Poljak.
Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.
Дагалдах зүйлүүд:
Anabasis brevifolia C.A.Mey
Caragana brachypoda Pojark
Haplophyllum dahuricum
Artemisia scoparia Waldst. et Kit.
Reaumuria soongorica (Pall.)
Artemisia intricata Franch..
Eurotia ceratiodes (L.) C. A. Mey

Зураг 0-1 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-2

Ургамлын бүрхэц: 6 сард 31%, 9 сард 42%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Сул” доройтсон ангилалд хамруулав.

BNU-SM-2 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 31%, 9 сард 42% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 4 зүйл тохиолдож байсан бол 9 сард 5 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 болон 9 сард 12 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 12 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 19-24 см байна.

Хүснэгт 0-2. Ургамлын мониторингийн BNU-SM-2 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	*Stipa glareosa P.Smirn.*	15	18	cop1	+	+	20
2	*Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.*	8	11	cop1	+	+	21
3	*Salsola laricifolia Turcz.ex Litv*	4	6	sp	+	+	22
4	*Ajania acheleoides (Turcz. Poljak.*	4	5	sp	+	+	21
5	*Chenopodium acuminatum Willd*		2	sp		+	14
Нийт 1 м^2 талбайд		**31**	**42**		**4**	**5**	**19**
Дагалдах зүйлүүд							
6	Anabasis brevifolia C.A.Mey			-		+	10
7	Caragana brachypoda Pojark			-	+		30
8	Haplophyllum dahuricum			-	+	+	12

9	Artemisia scoparia Waldst. et Kit.			-	+		31
10	Reaumuria soongorica (Pall.)			-	+	+	32
11	Artemisia intricata Franch..			-			28
12	Eurotia ceratiodes (L.) C. A. Mey			-	+	+	35
Нийт 10 м^2 талбайд		-	-	-	**9**	**9**	**24**

Ургамлын мониторингийн BNU-SM-3 цэг: Тус цэг нь гаалийн хяналтын талбайн урд замын дэргэд байрлах бөгөөд ургамлан нөмрөг сул доройтсон тухайн цэгийг гаалийн хяналтын талбайн ургамлан нөмрөгт үзүүлэх талхлагдал нөлөөллийг хянах зорилготойгоор байгуулсан. Тухайн орчинд Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл тохиолдоно.

Зонхилох зүйлүүд:
Stipa glareosa P.Smirn
Allium polyrrhizum Turcz. ex
Anabasis brevifolia C.A.Mey
Scorzonera divaricata
Дагалдах зүйлүүд:
Caragana brachypoda Pojark
Haplophyllum dahuricum
Artemisia Sieversiana Willd.
Artemisia scoparia Waldst. et Kit.
Artemisia intricata Franch..
Lactuca tatarica
Reaumuria soongorica (Pall.)
Convolvulus Ammanii Desr.

Зураг 0-2 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-3

Ургамлын бүрхэц: 6 сард 35%, 9 сард 44%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Сул” доройтсон ангилалд хамруулав. Төв суурьшлын нөлөө болон олон хүн техникийн нөлөөгөөр тухайн орчны ургамлан нөмрөг дунд зэрэг доройтсон байна.

BNU-SM-3 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 35%, 9 сард 44% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 3 зүйл тохиолдож байсан бол 9 сард 4 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 7 зүйл, 9 сард 9 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 12 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 11-26 см байна.

Хүснэгт 0-3. Ургамлын мониторингийн BNU-SM-3 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	Stipa glareosa P.Smirn	18	21	cop1	+	+	18
2	Allium polyrrhizum Turcz. ex	13	15	cop1	+	+	11
3	Anabasis brevifolia C.A.Mey	4	6	sp	+	+	10
4	Scorzonera divaricata		2	sol		+	6
Нийт 1 м² талбайд		**35**	**44**		**3**	**4**	**11**
Дагалдах зүйлүүд							
5	Caragana brachypoda Pojark				+	+	34
6	Haplophyllum dahuricum					+	12
7	Artemisia Sieversiana Willd.					+	35
8	Artemisia scoparia Waldst. et Kit.				+		38
9	Artemisia intricata Franch..				+	+	22
10	Lactuca tatarica					+	24
11	Reaumuria soongorica (Pall.)					+	41
12	Convolvulus Ammanii Desr.				+		6
Нийт 10 м² талбайд					**7**	**9**	**26**

Ургамлын мониторингийн BNU-SM-4 цэг: Энэ цэг нь шимт хөрсний овоолгын урд захад байрлана. Тухайн орчинд Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл тохиолдоно.



Зонхилох зүйлүүд:
Salsola laricifolia Turcz.ex Litv.
Stipa glareosa P.Smirn.
Anabasis brevifolia C.A.Mey..
Nitraria sibirica Pall
Дагалдах зүйлүүд:
Caryopteris mongolica Bge.
Ptilotrichum canescens C.A. Mey.
Scorzonera mongolica Maxim.
Enneapogon borealis
Achnatherum splendens
Iris lactea Pall.
Caragana brachypoda Pojark
Eurotia ceratoides(L.) C.A.Mey.
Reaumuria soongorica (Pall.)
Artemisia Sieversiana Willd.

Зураг 0-3 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-4

Ургамлын бүрхэц: 6 сард 38%, 9 сард 53%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Сул доройтсон” ангилалд хамруулав.

BNU-SM-4 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 38%, 9 сард 53% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 4 зүйл тохиолдож байсан бол 9 сард 4 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 8 зүйл, 9 сард 13 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 14 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 24-29 см байна.

Хүснэгт 0-4. Ургамлын мониторингийн BNU-SM-4 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	Salsola laricifolia Turcz.ex Litv.	12	18	cop1	+	+	25
2	Stipa glareosa P.Smirn.	10	15	cop1	+	+	24
3	Anabasis brevifolia C.A.Mey..	9	11	sp	+	+	11
4	Nitraria sibirica Pall	7	9	sp	+	+	35
Нийт 1 м^2 талбайд		**38**	**53**		**4**	**4**	**24**
Дагалдах зүйлүүд							
5	Caryopteris mongolica Bge.				+	+	38
6	Ptilotrichum canescens C.A. Mey.					+	11
7	Scorzonera mongolica Maxim.				+	+	5
8	Enneapogon borealis					+	6
9	Achnatherum splendens					+	56
10	Iris lactea Pall.				+	+	28
11	Caragana brachypoda Pojark				+		35
12	Eurotia ceratoides(L.) C.A.Mey.					+	41
13	Reaumuria soongorica (Pall.)					+	42
14	Artemisia Sieversiana Willd.				+	+	32
Нийт 10 м^2 талбайд					**8**	**13**	**29**

Ургамлын мониторингийн BNU-SM-5 цэг: Энэ цэг нь кемпийн цэвэрлэх байгууламж орчимд байрлана. Тус цэгийг кемпээс ургамал нөмрөгт үзүүлэх талхлагдал нөлөөллийг хянах зорилготойгоор байгуулсан. Тухайн орчинд Холимог сөөгт (180, Ц-I-2-8) бүлгэмдэл тохиолдоно.



Зонхилох зүйлүүд:
Ajania acheleoides (Turcz.) Poljak.
Allium polyrrhizum Turcz. ex RgL.
Salsola laricifolia Turcz.ex Litv
Stipa glareosa P.Smirn
Anabasis brevifolia C.A.Mey.
Дагалдах зүйлүүд:
Nitraria sibirica Pall.
Artemisia xerophytica Krasch
Caragana brachypoda Pojark
Peganum nigellastrum Bge
Reaumuria soongorica (Pall.) Maxim

Зураг 0-4 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-5

Ургамлын бүрхэц: 6 сард 7%, 9 сард 17%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Сул” доройтсон ангилалд хамруулав. Петро транс ХХК-ийн кемпийн ойр орчмын ургамал нөмрөг олон машин техникийн нөлөөгөөр хүчтэй доройтсон байна.

BNU-SM-5 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 7%, 9 сард 17% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 2 зүйл тохиолдож байсан бол 9 сард 5 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 5 зүйл, 9 сард 10 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 10 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 17-34 см байна.

Хүснэгт 0-5. Ургамлын мониторингийн BNU-SM-5 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	Ajania acheleoides (Turcz.) Poljak.		5	sp		+	19
2	Allium polyrrhizum Turcz. ex RgL.	3	2	sp	+	+	15
3	Salsola laricifolia Turcz.ex Litv		3	sp		+	20
4	Stipa glareosa P.Smirn		3	sp		+	24
5	Peganum nigellastrum Bge	4	4	sp	+	+	10
Нийт 1 м² талбайд		**7**	**17**		**2**	**5**	**17**
Дагалдах зүйлүүд							
6	Nitraria sibirica Pall.				+	+	39
7	Artemisia xerophytica Krasch				+	+	40
8	Caragana brachypoda Pojark					+	54
9	Anabasis brevifolia C.A.Mey.					+	6
10	Reaumuria soongorica (Pall.) Maxim				+	+	35
Нийт 10 м² талбайд					**5**	**10**	**34**

Ургамлын мониторингийн BNU-SM-6 цэг: Тус цэг нь хог хаягдал түр хадгалах цэгийн дэргэд байрлана. Тухайн хаягдлын цэгээс ургамлан нөмрөгт үзүүлж буй нөлөөллийг хянах зорилготой байгуулсан байна. Тухайн орчинд Баглуур-бударганат (164, Ц-I-1-2) бүлгэмдэл тохиолдоно.



Зонхилох зүйлүүд:
Anabasis brevifolia C.A.Mey.
Stipa glareosa P.Smirn
Bassia hyssopifolia (Pall.) Ktze. Б
Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze
Дагалдах зүйлүүд:
Ajania acheleoides (Turcz.) Poljak.
Allium polyrrhizum Turcz. ex RgL.
Ptilotrichum canescens
C.A.Mey.

Зураг 0-5 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-6

Ургамлын бүрхэц: 6 сард 14%, 9 сард 29%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр

“Дунд зэрэг” доройтсон ангилалд хамруулав. Тухайн мониторингийн цэг буюу 19-3 цооногийн ургамлан нөмрөг нь техноген болон антропоген нөлөөгөөр дунд зэрэг доройтсон байна.

BNU-SM-6 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 14%, 9 сард 29% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 3 зүйл тохиолдож байсан бол 9 сард 4 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 4 зүйл, 9 сард 7 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 7 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 16-25 см байна.

Хүснэгт 0-6. Ургамлын мониторингийн BNU-SM-6 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц, %		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	Anabasis brevifolia C.A.Mey.	7	11	cop1	+	+	12
2	Stipa glareosa P.Smirn	6	8	sp	+	+	20
3	Bassia dyssopifolia (Pall.) Ktze.	1	6	sp	+	+	24
4	Ptilotrichum canescens C.A.Mey.		4	sp		+	8
Нийт 1 м^2 талбайд		**14**	**29**		**3**	**4**	**16**
Дагалдах зүйлүүд							
5	Ajania acheleoides (Turcz.) Poljak.					+	15
6	Allium polyrrhizum Turcz. ex RgL.					+	16
7	Achnatherum splendens				+	+	45
Нийт 10 м^2 талбайд					**4**	**7**	**25**

Ургамлын мониторингийн BNU-SM-7 цэг: Тус цэг нь кемпийн талбайгаас зүүн хойшоо байрлах бөгөөд ямар нэгэн нөлөөлөл байхгүй этолон цэг юм. Тухайн орчинд Баглуур-бударганат (164, Ц-I-1-2) бүлгэмдэл тохиолдоно.

Зонхилох зүйлүүд:
Anabasis brevifolia C.A.Mey.
Stipa glareosa P.Smirn
Bassia hyssopifolia (Pall.) Ktze. Б
Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze
Ptilotrichum canescens C.A. Mey.
Reaumuria soongorica (Pall.)
Дагалдах зүйлүүд:
Scorzonera mongolica Maxim.
Enneapogon borealis
Achnatherum splendens
Caragana brachypoda Pojark
Eurotia ceratoides(L.) C.A.Mey.
Artemisia Sieversiana Willd.

Зураг 0-6 Ургамлын мониторингийн цэг BNU-SM-7

Ургамлын бүрхэц: 6 сард 12%, 9 сард 25%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын ангиллын дагуу ургамлын талхагдлын зэрэглэлээр “Хэвийн соргог” ангилалд хамруулав. Тухайн мониторингийн цэг орчмын ургамлан нөмрөг нь техноген болон антропоген нөлөөгөөр хүчтэй доройтсон байна.

BNU-SM-7 цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 12%, 9 сард 25% байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м^2 талбайд 6 сард 2 зүйл тохиолдож байсан бол 9 сард 6 зүйл тохиолдож байна. Харин 10 м^2 талбайд 6 сард 4 зүйл, 9 сард 9 зүйл тохиолдож байна. Харин тухайн бичиглэл хийсэн цэгийн ойр орчимд 2 удаагийн мониторинг судалгаагаар нийт 15 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 14-34 см байна.

Хүснэгт 0-7. Ургамлын мониторингийн BNU-SM-7 цэгийн бичиглэл

№	Зүйлийн латин нэр	Бүрхэц,%		Арви	Тохиолдоц		Дундаж өндөр, см
		VI	IX		VI	IX	
1	Anabasis brevifolia C.A.Mey.	3	8	sp	+	+	12
2	Stipa glareosa P.Smirn	1	4	sp	+	+	21
3	Enneapogon borealis		3	sol		+	26
4	Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze		2	sol		+	8
5	Ptilotrichum canescens C.A. Mey.		2	sol		+	5
6	Reaumuria soongorica (Pall.)		6	sp		+	12
Нийт 1 м^2 талбайд		**12**	**25**		**2**	**6**	**14**
Дагалдах зүйлүүд							
11	Scorzonera mongolica Maxim.					+	6
12	Achnatherum splendens				+		48
13	Caragana brachypoda Pojark					+	35
14	Eurotia ceratoides(L.) C.A.Mey.					+	41
15	Artemisia Sieversiana Willd.				+		40
Нийт 10 м^2 талбайд		**-**	**-**		**4**	**9**	**34**

5.5 Мониторинг судалгааны гол үр дүнгүүд

Ургамлын мониторингийн 7 цэгийн 2 улирлын судалгааны ургамлан нөмрөгийн тусгаг бүрхцийг харьцуулан үзвэл 6-р сард ургамлын бүрхэц хамгийн багадаа 7%-ийн тусгаг бүрхэцтэй байхад хамгийн ихдээ 38%, дунджаар 24%-ийн тусгаг бүрхэцтэй байна. Харин 9-р сард ургамлын бүрхэц хамгийн багадаа 17% байхад хамгийн ихдээ 53%, дунджаар 35%-ийн бүрхэцтэй байна.

